



УУЛ УУРХАЙ
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

БИЧИЛ УУРХАЙН ХОЛБОГДОЛТОЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ЭМХЭТГЭЛ

2022 он



Хянасан: Д.Хишгээ
*planetGOLD Монгол төслийн
Орон нутаг хариуцсан зохицуулагч*

Эмхэтгэсэн: Г.Мөнхцэцэг
*Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбооны
Хууль, бодлогын зөвлөх*

planetGOLD ТӨСЛИЙН ТУХАЙ

Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцод нэгдэн орсон улс орнуудын алтны бичил уурхай дах мөнгөн усны хэрэглээг бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Даян дэлхийн байгаль орчны сангийн санхүүгийн дэмжлэгтэй planetGOLD хөтөлбөр дэлхийн 24 улсад хэрэгжиж байна.

Монгол Улс дахь planetGOLD төслийг НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр болон НҮБ-ын Аж үйлдвэр, хөгжлийн байгууллага хэрэгжүүлж буй бөгөөд Канадын Алтны бичил уурхайн зөвлөл байгууллага Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран гүйцэтгэж байна.

planetGOLD төсөл нь алтны бичил уурхайг албажуулахад хувь нэмэр оруулж, бичил уурхайчдыг мэргэшүүлэн, тэдэнд санхүүгийн боломж бий болгох, хариуцлагатай алтны зах зээлд оролцох, мөнгөн усгүй баяжуулах технологи нэвтрүүлэх зэрэг дэмжлэг үзүүлэн, бичил уурхайн сайн туршлага, мэдлэг мэдээллийг түгээх зорилготой.

**БИЧИЛ УУРХАЙН
ХОЛБОГДОЛТОЙ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
ЭМХЭТГЭЛ**

УЛААНБААТАР ХОТ
2022 ОН

АГУУЛГА

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ	4
АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ.....	4
ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ.....	6
ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ.....	8
ЭРҮҮГИЙН ХУУЛЬ.....	11
ИРГЭНИЙ ХУУЛЬ.....	14
ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛЬ.....	15
НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬ.....	19
ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬ.....	19
АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬ.....	20
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ.....	27
НӨХӨРЛӨЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ.....	28
ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ТУХАЙ.....	34
ВАЛЮТЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ.....	35
УЛСЫН ИХ ХУРЛААС ТОМИЛОГДДОГ БАЙГУУЛЛАГЫН ДАРГА, ТҮҮНТЭЙ	
АДИЛТГАХ АЛБАН ТУШААЛТНЫ ШИЙДВЭР	36
ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН	
АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ,	
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОЛТ, БҮРТГЭЛИЙН ЖУРАМ.....	37
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ	47
БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ЖУРАМ.....	48
ҮНЭТ МЕТАЛЛЫН СОРЬЦ ТОГТООХ, БАТАЛГААЖУУЛАХ, ЭРДЭНИЙН ЧУЛУУ	
ТОДОРХОЙЛОХ, ТЭДГЭЭРИЙГ БҮРТГЭХ ЖУРАМ.....	70
САЙДЫН ТУШААЛ	72
БИЧИЛ УУРХАЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮРЭМ.....	73
БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ	
ЖУРАМ.....	82
БИЧИЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН УЛМААС ЭВДЭГДСЭН ГАЗАРТ НӨХӨН	
СЭРГЭЭЛТ ХИЙХ АРГАЧЛАЛ.....	88

— МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ —

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

2006 оны 7 дугаар сарын 08-ны өдөр

/Шинэчилсэн найруулга/

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хуулиар ус, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт болон түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмал эрэх, хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна.

/Энэ хэсэгт 2009 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хэсэгт 2014 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

3.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг журмаар зохицуулах бөгөөд уг журмыг Засгийн газар батална.

/Энэ хэсгийг 2010 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

3.3. Түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулна.

/Энэ хэсгийг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.23. "бичил уурхай эрхлэх" гэж үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд ашигт малтмал олборлох зорилгоор Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн, Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-д заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагааг;

/Энэ заалтыг 2010 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/

/Энэ заалтыг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

/Энэ заалтад 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

7 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглахад тавигдах ерөнхий шаардлага

7.1. Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад татвар төлөгч хуулийн этгээдэд энэ хуульд өөрөөр заагаагүй бол сонгон шалгаруулалтын журмаар олгоно.

/Энэ хэсэгт 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

7.3.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно. Байгалийн өнгөт болон үнэт чулууг түүх, олборлох үйл ажиллагааг ердийн ашигт малтмалын адил тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

/Энэ хэсэгт 2010 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хэсгийг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

11 дүгээр зүйл. Төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

11.1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид энэ хуульд “төрийн захиргааны байгууллага” гэх) дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

11.1.13. тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион явуулах, бичил уурхайн болон түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар талбай олгох дүгнэлт гаргах;

/Энэ заалтад 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

/Энэ заалтыг 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

11.1.23.энэ хуулийн 12.1.5-д заасны дагуу сум, дүүргийн Засаг даргын гаргасан хүсэлтийг хүлээн авч сонгосон газар нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, эсхүл тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхацсан эсэх талаар дүгнэлт гаргаж, газрын хэмжээ, хил хязгаарыг тогтоох.

/Энэ заалтыг 2010 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/

11.2.Төрийн захиргааны байгууллагын геологийн асуудал хариуцсан нэгж нь энэ зүйлийн 11.1.1 – 11.1.7, уул уурхайн асуудал хариуцсан нэгж нь энэ зүйлийн 11.1.8 – 11.1.12, кадастрын асуудал хариуцсан нэгж нь энэ зүйлийн 11.1.13 – 11.1.23-т заасан асуудлыг эрхэлнэ.

/Энэ хэсэгт 2010 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

12 дугаар зүйл. Аймаг, сумын Засаг даргын бүрэн эрх

/Энэ зүйлийн гарчигт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

12.1.Ашигт малтмалын асуудлаар аймгийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

12.1.1.ашигт малтмалын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

12.1.4.Газрын тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шийдвэр гаргах.

12.1.5.Газрын тухай хуулийн 16.1.11-д заасан зориулалтаар олгохоор сонгосон газрын талаар энэ хуулийн 11.1.23-д заасан дүгнэлт гаргуулах тухай хүсэлтийг төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

/Энэ заалтыг 2010 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/

35 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг үүрэг

35.6.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд, бичил уурхайгаас алт олборлогч нь олборлосон алтаа тухайн санхүүгийн жилдээ багтааж тушаана.

/Энэ хэсгийг 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн/

47 дугаар зүйл. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

47.3.1.олборлож өөрийн хэрэгцээнд ашигласан, дотоодод худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан нүүрсний нөөц ашигласны төлбөр борлуулалтын үнэлгээний 2.5 хувь;

47.3.2.Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд худалдсан алтанд ногдох нөөц ашигласны төлбөр борлуулалтын үнэлгээний 5.0 хувь байх бөгөөд энэ хуулийн 47.5-д заасан хувиар нэмэгдүүлж тооцохгүй;

47.3.3.энэ хуулийн 47.3.1, 47.3.2-т зааснаас бусад бүх төрлийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тухайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5.0 хувь.

/Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 07-ны өдөр

/Шинэчилсэн найруулга/

16 дугаар зүйл.Тусгай хэрэгцээний газар

16.1.Монгол Улс тусгай хэрэгцээний газартай байна. Улсын тусгай хэрэгцээний газарт дараахь газар хамаарна:

16.1.1.улсын тусгай хамгаалалттай газар;

16.1.2.улсын хилийн зурвас газар;

16.1.3.улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар;

16.1.4.гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар;

16.1.5.шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай;

16.1.6.аймаг дундын отрын бэлчээр;

16.1.7.улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай;

16.1.8.бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай;

16.1.9.чөлөөт бүсийн газар;

16.1.10.цөмийн төхөөрөмж барих, ашиглах зориулалтаар олгосон газар;

/Энэ заалтыг 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн/

16.1.11.бичил уурхайн зориулалтаар олгосон газар;

/Энэ заалтыг 2010 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/

16.1.12.хилийн боомтын бүс;

/Энэ заалтыг 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн/

16.1.13.үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар;

/Энэ заалтыг 2015 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/

16.1.14.аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар;

/Энэ заалтыг 2015 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/

16.1.15.хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газар.

/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн./

16.1.16.үйлдвэрлэл, технологийн паркийн газар.

/Энэ заалтыг 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./

16.2.Аймаг, сум, нийслэл, дүүрэг энэ хуулийн 16.1.1, 16.1.6, 16.1.7, 16.1.11, 16.1.16-д заасан зориулалтаар өөрийн эрх хэмжээнд нийцүүлэн газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч болно.

/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

/Энэ хэсэгт 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

/Энэ хэсэгт 2010 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

16.3.Газрын нэгдмэл сангийн аль ч ангиллын газраас тусгай хэрэгцээнд авч болно.

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр

/Шинэчилсэн найруулга/

5.11 дүгээр зүйл.Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль зөрчих

1.Химийн хорт, аюултай бодис:

1.1.экспортлох;

1.2.импортлох;

1.3.хилээр дамжуулан тээвэрлэх;

1.4.үйлдвэрлэх;

1.5.тээвэрлэх;

1.6.хадгалах;

1.7.худалдах;

1.8.ашиглах;

1.9.устгах үндсэн шаардлага, журам, аюулгүй ажиллагааны дүрэм, технологийн горимыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хурааж, зөрчлийг арилгуулж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

/Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

2.Хуульд заасныг зөрчиж:

2.1.ашиглаж болох бодис, пестицид, химийн бордоо, ахуйн хортон шавж, мэрэгч устгал, ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг турших, ашиглах журам зөрчсөн, эсхүл ашиглалтын хэмжээг хэтрүүлсэн;

2.2.химийн хорт, аюултай бодисын эрсдэлийн үнэлгээ хийх журам зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Хуульд заасны дагуу батлагдсан химийн хорт, аюултай бодистой холбогдох үйл ажиллагааг зохицуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаархи журам зөрчсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Химийн хорт, аюултай бодистой холбогдсон үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр явуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчилтэй бараа, бүтээгдэхүүн, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

5.Химийн хорт, аюултай бодисын хүний эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн хүлцэх хэмжээний талаарх стандартыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

6.Химийн хорт болон аюултай бодисын ашиглалт, зарцуулалтад дотоод хяналт тавиагүй бол хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.12 дугаар зүйл. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль зөрчих

1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тухай мэдээ, тайланг холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлээгүй, эсхүл зориуд буруу мэдээлсэн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг эзэмших эрх бүхий этгээд:

2.1.түүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах, аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлага;

2.2.тэсэлгээний ажил явуулах, үйлчилгээ үзүүлэх журам;

2.3.аюулгүй байдлын бүсийн дэглэм, журам зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах дүрмийг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйлийг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./

7.11 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хууль зөрчих

1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч олборлосон ашигт малтмалын хэмжээг нуун дарагдуулсан, эсхүл энэ зорилгоор хуурамч гэрээ байгуулсан, эсхүл үндэслэлгүй бага үнээр борлуулж борлуулалтын орлогыг санаатайгаар бууруулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь:

2.1.ашигт малтмал эрэх, хайх, ашиглахдаа хүлээх нийтлэг үүргийг биелүүлээгүй;

2.2.хайгуулын, ашиглалтын талаар хуульд заасан мэдээ, тайлан, төлөвлөгөөг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл хуурамч мэдээ, тайлан гаргасан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

/Энэ заалтыг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

3.Үнэт металл, эрдэнийн чулууны сорьц, чанарыг тогтоолгох, эсхүл бүртгүүлэх журам зөрчсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг зохицуулах талаар тогтоосон журам зөрчсөн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Тусгай зөвшөөрөлгүй хүн, хуулийн этгээд хуулиар тогтоосон журам зөрчиж байгалийн үнэт, эсхүл өнгөт чулууг:

7.1.олборлосон;

7.2.худалдсан;

7.3.худалдан авсан;

7.4.тээвэрлэсэн;

7.5.хадгалсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

/Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр

/Шинэчилсэн найруулга/

24.2 дугаар зүйл. Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох

1.Тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт, ашиглалт явуулсан, эсхүл ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар хууль бусаар газрын хэвлийд халдсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

2.Тусгай зөвшөөрөлтэйгөөр ашигт малтмалын хайгуул, ашиглалт, олборлолт, боловсруулалт явуулсан талбайд нөхөн сэргээлтийн ажлыг зохих журмын дагуу хийгээгүйн улмаас байгаль орчинд их хэмжээний хохирол учирсан бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

4.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

186 дугаар зүйл. Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар олж авах

186.1.Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг хулгайлах, булаах, дээрэмдэх, залилан мэхлэх, завших зэргээр хууль бусаар олж авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсгийг 2015 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

186.2.Энэ хэргийг давтан буюу урьдчилан үгсэж тохиролцсон болон зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл, түүнчлэн уг зүйлийг албан ажлын хувьд ашиглах буюу хамгаалахаар итгэмжлэгдэн хариуцсан этгээд үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс гурван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

191 дүгээр зүйл. Тэсэрч дэлбэрэх болон цацраг идэвхт бодисыг бүртгэх, хадгалах, ашиглах, тээвэрлэх, илгээх журам зөрчих

190.1. Тэсэрч дэлбэрэх болон цацраг идэвхт бодисыг бүртгэх, хадгалах, ашиглах, тээвэрлэх, илгээх журмыг зөрчсөний улмаас хүний бие махбодод хүндэвтэр буюу хүнд гэмтэл учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

190.2. Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

**ХОРИН НАЙМДУГААР БҮЛЭГ
АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРЭГ**

263 дугаар зүйл. Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах

263.1. Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хуулиар хамгаалсан эрх, ашиг сонирхолд үлэмж хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

263.2. Энэ хэргийг давтан үйлдсэн, уг хэргийн улмаас их хэмжээний хохирол, хүнд хор уршиг учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасаж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

Тайлбар: Энэ бүлэгт дурдсан төрийн албан тушаалтан гэдэгт төрийн байгууллагад удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байгаа этгээдийг хамааруулна.

/Энэ тайлбарыг 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

264 дүгээр зүйл. Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх

264.1. Төрийн албан тушаалтан албан үүргийн хувьд хуулиар олгогдсон эрх мэдлээ хэтрүүлснээс аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд үлэмж хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

264.2. Энэ хэргийг давтан, эсхүл хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

265 дугаар зүйл. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах

265.1. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан, арбитрч хувьдаа болон бусдад давуу байдал тогтоох, ашиг хонжоо олох зорилгоор хууль тогтоомж, дүрмээр олгогдсон албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд үлэмж хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хэсэгт 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

265.2. Энэ хэргийг давтан үйлдсэн, эсхүл их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Энэ бүлэгт дурдсан төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан гэдэгт төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байгаа этгээдийг хамааруулна.

266 дугаар зүйл. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх

266.1. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан, арбитрч албан үүргийн хувьд хууль тогтоомж, дүрмээр олгогдсон эрх мэдлээ илтэд хэтрүүлсний улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд үлэмж хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

266.2. Энэ хэргийг давтан үйлдсэн, эсхүл түүний улмаас их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

ИРГЭНИЙ ХУУЛЬ

2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр

35 дугаар зүйл. Нөхөрлөл

35.1.Гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх эд хөрөнгөтэй, хүлээсэн үүргээ уг эд хөрөнгө болон гишүүдийн хувийн өмчийн эд хөрөнгөөр хуульд заасны дагуу хариуцдаг хуулийн этгээдийг нөхөрлөл гэнэ.

35.2.Нөхөрлөлийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

36 дугаар зүйл. Холбоо, сан, хоршоо

36.4.Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.

481 дүгээр зүйл. Бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөл

481.1.Хамтран ажиллах гэрээний үндсэн дээр хэд хэдэн этгээд холбоо болон нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдаж үйл ажиллагаа явуулж болох бөгөөд ийм байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэхгүй, бүтэц, зохион байгуулалтыг гишүүд харилцан тохиролцож тодорхойлно.

481.2.Бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөл нь иргэний эрх зүйн харилцаанд бүрэн эрх бүхий төлөөлөгч буюу гишүүдээр дамжин оролцоно.

ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛЬ

2021 оны 05 сарын 06 өдөр

/Шинэчилсэн найруулга/

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.”хоршоо” гэж Иргэний хуулийн 36.4-т заасан хуулийн этгээдийг;

4.1.2.”хоршооны гишүүн” гэж хоршооны дүрэмд заасан хэмжээгээр хоршоонд хувь хөрөнгө оруулсан, 16 насанд хүрсэн иргэнийг, дундын хоршооны тухайд хоршоо, хуулийн этгээдийг;

6 дугаар зүйл. Хоршооны хэлбэр, үйл ажиллагааны чиглэл

6.1.Хоршоо анхан шатны болон дундын гэсэн хэлбэртэй байна.

6.5.Хоршоо хууль тогтоомжоор хориглоогүй, хоршооны дүрэмд заасан үйл ажиллагаа явуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХОРШООГ ҮҮСГЭН БАЙГУУЛАХ

7 дугаар зүйл. Хоршооны оноосон нэр, оршин байгаа газар

7.1.Хоршоо оноосон нэртэй байна. Хоршооны оноосон нэрийн ард “Хоршоо” гэсэн ялгах тэмдгийг хэрэглэнэ.

7.2.Хоршоог хоршооны аль нэг гишүүний нэрээр нэрлэж үл болно.

7.3.Хоршооны ерөнхий захиргаа оршин байгаа газрыг хоршооны төв гэж үзнэ.

8 дугаар зүйл. Үүсгэн байгуулах гэрээ

8.1.Хоршоог үүсгэн байгуулагчид хоршоо үүсгэн байгуулах талаар гэрээ байгуулж, уг гэрээнд хоршооны зорилго, үүсгэн байгуулагчдын оруулах хувь хөрөнгийн хэмжээ, эрх, үүрэг, хариуцлага зэргийг тусгана.

8.2.Хоршоог улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсгэн байгуулах гэрээ дуусгавар болно.

9 дүгээр зүйл. Хоршоог улсын бүртгэлд бүртгүүлэх

9.1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хоршоог үүсгэн байгуулагч хоршоо байгуулах тухай шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.

10 дугаар зүйл. Хоршооны дүрэм, түүний агуулга

10.1.Хоршоог үүсгэн байгуулах баримт бичиг нь хоршооны дүрэм байна.

10.2.Хоршооны дүрмийг бүх гишүүдийн хурлаар батална.

10.3.Хоршооны дүрэмд дараах асуудлыг тусгана:

10.3.1.хоршооны оноосон нэр, оршин байгаа газрын хаяг;

10.3.2.хоршооны гишүүний ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, иргэний бүртгэлийн дугаар, дундын хоршооны тухайд гишүүн хоршоо, хуулийн этгээдийн оноосон нэр, оршин байгаа газрын хаяг;

/Энэ заалтад 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

10.3.3.хоршооны зорилго, үйл ажиллагааны чиглэл;

10.3.4.тодорхой хугацаагаар үйл ажиллагаа явуулахаар тохиролцсон бол үйл ажиллагаа явуулах хугацаа;

10.3.5.хоршоонд элсэх, хоршооноос гарах, хасах нөхцөл, журам, хоршооны гишүүний эрх, үүрэг, хариуцлага;

10.3.6.хоршооны гишүүний оруулах хувь хөрөнгийн хэлбэр, үнэлэх арга;

10.3.7.хоршооны гишүүний заавал оруулах хувь хөрөнгийн хэмжээ, хугацаа;

10.3.8.хоршооны гишүүний заавал оруулах хувиас гадна хоршоонд нэмж оруулж болох хувь хөрөнгийн дээд хэмжээ;

10.3.9.хоршооны гишүүнчлэлийн журам;

10.3.10.хоршооны гишүүнд үйлчлэх хэлбэр;

10.3.11.хоршоо үйл ажиллагаандаа хоршооны гишүүн бус этгээдийг оролцуулах нөхцөл, журам;

10.3.12.хоршооны эд хөрөнгө, түүнийг бүртгэх, ашиглах, захиран зарцуулах журам;

10.3.13.хоршооны орлого, зарлагыг тооцох, бүртгэх, түүнийг хуваарилах журам;

10.3.14.хоршооны гишүүнд ногдох орлого хуваарилах, оруулсан хувь хөрөнгийг буцаан олгох журам;

10.3.15.хоршооны бүтэц, хэлбэр, удирдлагын бүрэлдэхүүн, түүний бүрэн эрх, хүлээх хариуцлага, шийдвэр гаргах журам;

10.3.16.хоршооны үйл ажиллагаанд тавих дотоод болон хөндлөнгийн хяналт;

10.3.17.хоршооны гүйцэтгэх удирдлагад тавих шаардлага;

10.3.18.хоршооны салбар, төлөөлөгчийн газар байгуулах үндэслэл, ажиллах журам, түүний эрх, үүрэг, хариуцлага;

10.3.19.хоршооны бүх гишүүдийн хурал, хоршооны Тэргүүлэгчид /цаашид “Тэргүүлэгчид” гэх/, хоршооны Хяналтын зөвлөл /цаашид “Хяналтын зөвлөл” гэх/-ийн хуралдааныг хуралдуулахтай холбогдсон энэ хуульд зааснаас бусад асуудал;

10.3.20.болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуримтлуулах хөрөнгийн хувь хэмжээ, уг санд заавал байлгах хөрөнгийн хэмжээ;

10.3.21.хоршооны хөгжлийн санд төвлөрүүлэх хөрөнгийн хувь хэмжээ;

10.3.22.хоршоодын холбоонд нэгдэх, холбооноос гарах;

10.3.23.хоршоог өөрчлөн байгуулах, татан буулгах, өр төлбөрийг барагдуулах, үлдэгдэл эд хөрөнгийг гишүүдэд хуваах журам;

10.3.24.хоршооноос их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх эрх, уг хэлцлийн улмаас үүссэн хохирлыг барагдуулах, үр дагаврыг арилгах журам;

10.3.25.хоршооны гишүүний хоршоонд оруулсан хувь хөрөнгийг өв залгамжлах, бусдад шилжүүлэх журам;

10.3.26.хоршооны үйл ажиллагаатай холбоотой бусад асуудал.

12.2.3.хоршооны үйлчилгээг шуурхай, чанартай хүргэх техник, технологийг нэвтрүүлэх, хоршооны эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах;

12.2.4.хоршооны бараа, бүтээгдэхүүнийг борлуулах сүлжээ, үйлчилгээг бий болгох, хоршооны бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний онцлог, үйл ажиллагааны

чиглэлийг харгалзан бусад хоршоо, хуулийн этгээдтэй хорших, төрөлжих хэлбэрээр харилцан уялдаатай хамтран ажиллах;

12.2.5.хоршооллын хөдөлгөөнийг дэмжих;

12.2.6.хуульд заасан бусад үүрэг.

13 дугаар зүйл. Хоршооны хариуцлага

13.1.Хоршоо үйл ажиллагааныхаа улмаас бий болсон үүргийг хоршооны эд хөрөнгөөр хариуцна.

13.2.Хоршоо нь хоршооны гишүүний бусдын өмнө хүлээх үүргийг хариуцахгүй.

13.3.Хоршооны гишүүн нь хоршооны хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү хоршоонд оруулсан хувь хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХОРШООНЫ ГИШҮҮН

14 дүгээр зүйл.Хоршоонд элсэх

14.1.Хоршооны дүрмийг зөвшөөрсөн иргэн сайн дураар анхан шатны хоршоонд элсэнэ.

14.2.Дундын хоршооны дүрмийг зөвшөөрсөн хоршоо, хуулийн этгээд сайн дураар дундын хоршоонд элсэнэ.

14.3.Хоршоонд элсэхийг хүссэн этгээд хүсэлтээ хоршооны даргад гаргана.

14.4.Хоршооны дүрэмд өөрөөр заагаагүй бол хоршоонд элсэх хүсэлтийг хоршооны бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж, хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

14.5.Хүсэлт гаргагч нь бүх гишүүдийн хурлын шийдвэрийг үндэслэн хоршооны дүрэмд заасан хэмжээгээр хоршооны гишүүний элсэлтийн хураамжийг төлж, хувь хөрөнгөө хоршоонд оруулснаар хоршооны гишүүний эрх баталгаажна.

14.6.Хоршоонд гишүүн элсүүлсэн тохиолдолд энэ тухай шийдвэр гарснаас хойш 90 хоногийн дотор Тэргүүлэгчид улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХОРШООНЫ ХӨРӨНГӨ, ЭХ ҮҮСВЭР

22 дугаар зүйл.Хоршооны өөрийн хөрөнгө

22.1.Хоршооны өөрийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

22.1.1.хоршооны гишүүний оруулсан хувь хөрөнгө;

22.1.2.хоршоонд бэлэглэсэн, хандивласан болон буцалтгүй тусламжийн хэлбэрээр өгсөн хөрөнгө;

22.1.3.болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуваарилсан хөрөнгө;

22.1.4.хоршооны хөгжлийн санд төвлөрүүлсэн хөрөнгө;

22.1.5.хоршооны ашиг, алдагдал.

24 дүгээр зүйл.Хоршоонд гишүүний оруулсан хувь хөрөнгө

24.1.Хоршооны гишүүн хоршоонд эд хөрөнгө, мөнгөн хөрөнгө, хөдөлмөр оролцоо, ажил, үйлчилгээ, оюуны өмчийн хэлбэрээр хувь хөрөнгө оруулж болно.

24.2.Хоршооны гишүүний хоршоонд оруулах хувь хөрөнгийн дээд хэмжээг тухайн хоршооны өөрийн хөрөнгийн 15 хувиас хэтрэхгүй байна.

24.3.Хоршооны гишүүний хоршоонд оруулах хувь хөрөнгийн хэлбэр, хэмжээг хоршооны дүрмээр энэ хуулийн 24.2-т заасны дагуу тогтооно.

24.4.Хоршооны эд хөрөнгөөс хоршооны гишүүнд оногдох хувь нь гишүүний оруулсан нийт хувь хөрөнгө, тухайн гишүүнд ногдох хоршооны жилийн ашиг, алдагдлын зөрүүг тооцсон дүнтэй тэнцүү байна.

26 дугаар зүйл.Хоршооны гишүүнд ногдох орлого хуваарилах

26.1.Хоршооны гишүүнд ногдох орлогын хувь хэмжээг Тэргүүлэгчид болон Хяналтын зөвлөлийн саналыг харгалзан бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэнэ.

26.2.Хоршооны гишүүн хоршоонд төлөх өр төлбөртэй тохиолдолд түүнд ногдох орлогоос өр төлбөрийг хасаж, үлдэх дүнгээр хуваарилна.

28 дугаар зүйл.Хоршоог дэмжих хөрөнгө оруулалт

28.1.Хоршоо үйл ажиллагаагаа өргөжүүлэх, хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор хоршооны гишүүн бус этгээдээс хөрөнгө оруулалт авч болно. Хоршоонд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ хоршооны өөрийн хөрөнгийн 50 хувиас хэтрэхгүй байна.

28.2.Хоршоо болон хөрөнгө оруулагчийн хооронд байгуулсан гэрээгээр хөрөнгө оруулалтын нөхцөлийг зохицуулна.

28.3.Хөрөнгө оруулагч нь хоршооны удирдлага, үйл ажиллагаанд оролцохгүй, хоршооны гишүүний аливаа эрхийг эдлэхгүй.

28.4.Хөрөнгө оруулагчид хувь хүртээх эсэх асуудлыг бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэнэ.

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬ

2015 оны 7 дугаар сарын 09-ний өдөр

/Шинэчилсэн найруулга/

13 дугаар зүйл.Албан татвараас чөлөөлөх

13.1. Дараах барааг албан татвараас чөлөөлнө:

13.1.11.борлуулсан алт;

13.1.13.энэ хуулийн 12.1.7-д зааснаас бусад экспортод гаргасан ашигт малтмалын бүтээгдэхүүн;

13.6.Жилийн 50 саяас доош төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ борлуулсан этгээд /импортоор оруулахаас бусад/-ийг албан татвараас чөлөөлнө.

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬ

2019 оны 03 сарын 22 өдөр

/Шинэчилсэн найруулга/

6 дугаар зүйл.Албан татвар ногдох орлого

6.1.Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй, түүнчлэн гадаад улсад олсон орлогод албан татвар ногдоно.

6.3.Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно:

6.3.1.цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого;

6.3.2.үйл ажиллагааны орлого;

6.3.3.хөрөнгийн орлого;

6.3.4.хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;

6.3.5.шууд бус орлого;

6.3.6.бусад орлого.

8 дугаар зүйл.Үйл ажиллагааны орлого

8.1.Үйл ажиллагааны орлогод хуулийн этгээд байгуулахгүйгээр үйл ажиллагаа явуулж олсон дараах орлогыг хамруулна:

8.1.1.бие даан эрхэлсэн мэргэжлийн ажил, үйлчилгээний орлого;

8.1.2.хувиараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх, зуучлалын үйл ажиллагаа эрхэлж олсон орлого;

8.1.3. шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого;

8.1.4. эрхэлж байгаа үйл ажиллагаатай холбоотойгоор үнэ төлбөргүй бусдаас авсан бараа, ажил, үйлчилгээ.

8.2. Тогтмол бус үйл ажиллагаа эрхэлж олсон орлогыг үйл ажиллагааны орлогод хамруулна.

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬ

2019 оны 03 сарын 22 өдөр

/Шинэчилсэн найруулга/

5 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөгч

5.1. Тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсхүл орлого олоогүй боловч хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг бүхий аж ахуйн нэгж нь албан татвар төлөгч байна.

5.2. Албан татвар төлөгчийг Монгол Улсад байрладаг, Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч гэж ангилна.

5.3. Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчид дараах аж ахуйн нэгж хамаарна:

5.3.1. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж;

7 дугаар зүйл. Албан татвар ногдох орлого

7.1. Энэ хуулийн 5.3-т заасан албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон, түүнчлэн гадаад улсаас олсон орлогод албан татвар ногдоно.

7.4. Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно:

7.4.1. үйл ажиллагааны орлого;

7.4.2. хөрөнгийн орлого;

7.4.3. хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;

7.4.4. бусад орлого.

7.5. Албан татвар ногдох орлогын дүнг тодорхойлохдоо албан татвараас чөлөөлөгдөх орлогыг хасаж тооцно.

8 дугаар зүйл. Үйл ажиллагааны орлого

8.1. Үйл ажиллагааны дараах орлогод албан татвар ногдоно:

8.1.1. бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлого;

8.1.2.төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны үйл ажиллагаанаас олсон орлого;

8.1.3.техникийн, удирдлагын, зөвлөхийн болон бусад үйлчилгээний орлого;

8.1.4.үнэ төлбөргүйгээр бусдаас авсан бараа, ажил, үйлчилгээний орлого;

8.1.5.энэ хуулийн 8.1.1, 8.1.2, 8.1.3, 8.1.4-т заасантай адилтгах бусад орлого.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

АЛБАН ТАТВАР НОГДОХ ОРЛОГООС ХАСАГДАХ ЗАРДАЛ

13 дугаар зүйл.Албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тавигдах шаардлага

13.1.Дараах нөхцөлийг нэгэн зэрэг хангасан зардлыг албан татвар ногдох орлогоос хасаж тооцно:

13.1.1.тухайн татварын тайлант хугацаанд хамаарсан байх;

13.1.2.албан татвар төлөгчийн албан татвар ногдох орлого олох үйл ажиллагаатай шууд холбогдон гарсан байх;

13.1.3.зардал бодитой гарсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан баримт болон холбогдох бүртгэлээр баталгаажсан байх;

13.1.4.доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх:

13.1.4.а.энэ хуулийн 5.5.2-т зааснаас бусад албан татвар төлөгчийн үзүүлсэн ажил, үйлчилгээний зардал;

13.1.4.б.хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, биет бус хөрөнгө худалдан авахтай холбогдон гарах зардал.

13.1.5.зардлыг тухайн үйл ажиллагаа эрхэлж байгаа албан татвар төлөгч төлсөн, эсхүл төлөхөөр тайлагнасан байх.

13.2.Энэ хуулийн 13.1-д заасан нөхцөлийг хангасан зардлыг доор дурдсан хязгаар, нөхцөлтэйгөөр албан татвар ногдох орлогоос хасна:

13.2.1.албан татвар, төлбөр, хураамж нь төсөвт төлөхөөр тайлагнасан байх;

13.2.2.албан томилолтын зардал нь төрийн албан хаагчдын албан томилолтын зардлыг хоёр дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байх;

13.2.3.банк, банк бус санхүүгийн байгууллагын зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах санд төвлөрүүлсэн хөрөнгөд хэвийн зээлийн үлдэгдэлд байгуулсан сангийн хөрөнгө хамаарахгүй байх;

13.2.4.Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу гамшгийн улмаас учирсан хохирлыг арилгахад гарсан зардал нь холбогдох байгууллагын дүгнэлтээр баталгаажсан байх;

13.2.5.ёслол хүндэтгэлийн арга хэмжээний зардал нь тухайн татварын жилд Хөдөлмөрийн тухай хуульд заасан хөдөлмөрийн гэрээ болон онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа ажиллагчдад олгосон цалингийн зардлын нийт дүнгийн 5 хувиас хэтрэхгүй байх;

/Энэ заалтад 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

13.2.6.Даатгалын тухай хуулийн 4.1.2-т заасан даатгагчаас бусад этгээдийн сайн дурын даатгалын хураамжийн дүн нь тухайн татварын жилийн албан татвар ногдуулах орлогын 15 хувиас хэтрэхгүй байх;

13.2.7.Даатгалын тухай хуулийн 4.1.2-т заасан даатгагчийн харилцан хамааралтай этгээдүүдтэй хийсэн сайн дурын даатгалын хураамжийн дүн нь тухайн татварын жилийн албан татвар ногдуулах орлогын 15 хувиас хэтрэхгүй байх;

13.2.8.урсгал засварын зардал нь сэлбэг хэрэгслийн зардлыг багтаасан байх бөгөөд тухайн үл хөдлөх эд хөрөнгийн хувьд үлдэгдэл өртгийн 2 хувь, бусад хөрөнгийн хувьд үлдэгдэл өртгийн 5 хувиас хэтрэхгүй бөгөөд үүнээс хэтэрсэн урсгал засварын зардлыг их засварын зардалд тооцох;

13.2.9.цалин, хөдөлмөрийн хөлс, нэмэгдэл, түүнтэй адилтгах орлогод нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар ногдуулж, суутгасан байх;

13.2.10.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан шууд бус орлогод хувь хүний орлогын албан татвар ногдуулж, суутгасан байх;

13.2.11.хүүгийн зардлын хувьд энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу тодорхойлсон байх;

13.2.12.албан татвар суутгах орлого олгосон тохиолдолд холбогдох албан татварыг суутган тайлагнасан байх.

13.3.Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмших болон шилжүүлэн авахтай холбогдон гарсан зардлыг тухайн тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаанд жил тутам ижил хэмжээгээр үйл ажиллагааны зардалд оруулан хасаж тооцно.

13.4.Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч, гэрээлэгчийн байгаль орчны нөхөн сэргээлт, уурхайн хаалтын зардалд хуримтлуулах мөнгөн хөрөнгийг тухайн тусгай зөвшөөрөл хүчинтэй байх хугацаанд жил тутам ижил хэмжээгээр үйл ажиллагааны зардалд оруулан хасаж тооцно.

13.5.Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч албан татвар ногдох орлогоос хасагдах зардлыг энэ хуулийн 26.9, 26.10, 26.11, 26.12, 26.13-т заасны дагуу тайлан тус бүрээр тооцно.

15 дугаар зүйл.Албан татвар ногдох орлогоос хасагдах бусад зардал

15.1.Энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан дараах зардлыг албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцож болно:

15.1.1.бараа, материалын хэвийн хорогдол;

15.1.2.эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл;

15.1.3.энэ хуулийн 16.1.8-д зааснаас бусад төсөвт төлөхөөр тайлагнасан албан татвар, төлбөр, хураамж;

15.1.4.мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн сургалтын орчныг бүрдүүлэх, дадлагын газрыг тоног төхөөрөмжөөр хангах, дадлагын байрыг засварласан зардал;

15.1.5.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 11.5, 18 дугаар зүйлд заасан багш нарыг дадлагажуулсан зардал;

15.1.6.өөрийн захиалгаар мэргэжилтэн бэлтгүүлэх зорилгоор мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад үзүүлсэн санхүүгийн дэмжлэг;

15.1.7.хөгжлийн бэрхшээлтэй Монгол Улсын иргэний үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагыг дэмжих зорилгоор өгсөн 10 сая хүртэлх төгрөгийн хандив;

15.1.8.Спортыг дэмжих санд спортын холбоо, клубийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор өгсөн 10 сая хүртэлх төгрөгийн хандив;

/Энэ заалтыг 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

15.1.9.мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд өгсөн хандив, хөрөнгө;

15.1.10.агаарын бохирдлыг бууруулах зорилгоор өгсөн хандив;

15.1.11.банк, банк бус санхүүгийн байгууллагын зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах санд төвлөрүүлсэн хөрөнгө;

15.1.12.хадгаламж, зээлийн хоршооны зээлийн эрсдэлийн санд, бусад үйл ажиллагаа эрхэлдэг хоршооны болзошгүй эрсдэлээс хамгаалах санд төвлөрүүлсэн хөрөнгө;

15.1.13.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, төсөл хэрэгжүүлэгч, гэрээлэгчийн байгаль орчны менежментийн жилийн төлөвлөгөөнд тусгаж, холбогдох төрийн байгууллагаас нээсэн тусгай сан, төрийн сан болон Газрын тосны тухай хуулийн 11.2.9-д заасан дансанд шилжүүлсэн мөнгөн хөрөнгө;

15.1.14.Ахмад настны тухай хуулийн 14.7-д заасан хязгаарт багтаан Ахмадын санд хуримтлуулсан зардал.

15.2.Энэ хуулийн 15.1.1-д заасан хорогдлын хэмжээг Засгийн газар батална.

15.3.Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй албан татвар төлөгч нийслэл хотод байрлалтай үйлдвэр, эсхүл агуулахаа Багануур, Багахангай, Налайх дүүргээс бусад нийслэлийн хилийн цэсээс нүүлгэсэн тохиолдолд тухайн нүүлгэн шилжүүлэхтэй холбогдон гарсан энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан шаардлага хангасан зардлыг 50 хувиар нэмэгдүүлж албан татвар ногдох орлогоос хасаж тооцно.

/Энэ хэсгийг 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

15.4.Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй, Багануур, Багахангай, Налайх дүүргээс бусад нийслэл хотын хилийн цэсээс гадна үндсэн үйл ажиллагаа эрхлэн явуулдаг, хуулийн этгээдийн ерөнхий захиргаа нь үйл ажиллагааг явуулж байгаа тухайн орон нутагт бүртгэлтэй, тухайн орон нутгийн татварын албанд бүртгэгдсэн албан татвар төлөгч ажил хайгч иргэнийг хөдөлмөрийн гэрээний дагуу үргэлжилсэн 12 сарын хугацаанд нийт 183 ба түүнээс дээш хоног шинээр ажиллуулсан бол тухайн хугацаанд хамаарах цалингийн зардлыг 20 хувиар нэмэгдүүлж албан татвар ногдох орлогоос нэг удаа хасаж тооцно.

/Энэ хэсгийг 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

16 дугаар зүйл. Албан татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал

16.1.Дараах зардлыг албан татвар ногдох орлогоос хасахгүй:

16.1.1.энэ хуулийн 13.1, 13.2-т заасан нөхцөл, хязгаарыг хангаагүй зардал;

16.1.2.түрээслэгчийн түрээсийн хөрөнгийн үндсэн төлбөр;

16.1.3.гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс бусдад төлсөн төлбөр, хүү, торгууль, анз;

16.1.4.ажиллагчид болон харилцагч байгууллага, хувь хүнд зориулсан амралт зугаалга, түүнтэй адилтгах бусад зардал;

16.1.5.харилцан хамааралтай этгээдэд борлуулсан хөрөнгийн гарз;

16.1.6.төлөөний газрын өөрийн толгой компанид шилжүүлсэн хүүгийн төлбөр, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө ашиглуулсан болон түрээслүүлсний төлбөр, эрхийн шимтгэлийн төлбөр, техникийн, удирдлагын, зөвлөхийн болон бусад үйлчилгээний төлбөр;

16.1.7.энэ хуульд заасан албан татвараас чөлөөлөгдөх орлого олохтой холбогдон гарсан зардал;

16.1.8.нийслэл хотын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн төсөвт төлсөн нэмэгдсэн өртгийн албан татвар болон энэ хуулийн дагуу бусад этгээдийн олсон орлогоос суутган авсан татвар;

16.1.9.гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит бус алдагдал;

16.1.10.барааны дахин үнэлгээний нэмэгдүүлсэн зөрүү;

16.1.11.банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн зээлийн эрсдэлийн сангаас хаасан зээл;

16.1.12.энэ хуулийн 15.1.6, 15.1.7, 15.1.8, 15.1.9, 15.1.10-т зааснаас бусад хандив, тусламжийн зардал.

ДОЛДУГААР БҮЛЭГ

АЛБАН ТАТВАР СУУТГАХ, ТӨСӨВТ ТӨЛӨХ, ТАЙЛАГНАХ, БУЦААН ОЛГОХ

24 дүгээр зүйл. Албан татварыг суутган төлөх

24.1.Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч энэ хуулийн 18.6.1, 18.6.2, 18.6.3, 18.6.4, 18.6.5, 18.6.7, 18.6.8-д заасан орлогод ногдох албан татварыг суутган төлөгч ногдуулж, суутгана.

24.2.Энэ хуулийн 18.6.6-д заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулах албан татварыг төлөөний газар ногдуулж, суутгана.

24.3.Энэ хуулийн 5.5.1-д заасан татвар төлөгч өөрийн төлөөний газрын үйл ажиллагаатай холбогдох орлогыг Монгол Улсад байрладаггүй этгээдэд шилжүүлсэн тохиолдолд тухайн төлөөний газар холбогдох албан татварыг ногдуулж, суутгана.

24.4.Энэ хуулийн дагуу суутган төлөгчийг тодорхойлох боломжгүй тохиолдолд албан татвар ногдуулах орлого олсон этгээд нь албан татварыг өөрөө тодорхойлж ногдуулна.

24.5.Суутган ногдуулсан албан татварыг ажлын 10 өдрийн дотор төсөвт шилжүүлнэ.

25 дугаар зүйл. Албан татварыг өөрөө тодорхойлон ногдуулж, төсөвт төлөх

25.1.Төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хуваарийг үндэслэн харьяалах татварын алба тухайн татварын жилд энэ хуулийн 20.1, 20.2.7-д заасны дагуу ногдуулан төлөх албан татварын сар, улирлын хуваарийг албан татвар төлөгчид хүргүүлнэ.

25.2.Энэ хуулийн 25.1-д заасан урьдчилан тодорхойлсон хуваарийн дагуу сар бүр төлөх татвараа сар бүрийн 25-ны дотор, улирлын эцэст хийсэн тооцооны дагуу татвараа дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцэст хийсэн эцсийн тооцооны дагуу татвараа дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор төсөвт төлнө.

25.3.Төр нь өмчдөө ногдох ашиг болон хувьцааны ногдол ашгийг бүрэн буюу хэсэгчлэн төсөвт дайчлах эрхтэй бөгөөд хэмжээг нь тухайн жилийн Төсвийн тухай хуулиар тогтооно.

26 дугаар зүйл. Албан татварыг тайлагнах

26.1.Өмнөх татварын жилийн албан татвар ногдуулах орлого нь 6 тэрбум төгрөг ба түүнээс дээш бол уг албан татвар төлөгч тухайн татварын жилийн улирлын татварын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцсийн татварын тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд хүргүүлнэ.

26.2.Татварын өмнөх жилийн албан татвар ногдуулах орлого нь 6 тэрбум төгрөг хүртэл энэ хуулийн 29.1-д заасны дагуу татварын албанд бүртгүүлээгүй

албан татвар төлөгч тухайн татварын жилийн эхний хагас жилийн татварын тайланг 07 дугаар сарын 20-ны дотор, жилийн эцсийн татварын тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор гаргаж, харьяалах татварын албанд хүргүүлнэ.

26.3.Энэ хуулийн 26.1, 26.2-т заасан албан татвар ногдуулах жилийн орлогыг тодорхойлохдоо албан татвар төлөгчийн зөвхөн тухайн тайлант жилийн өмнөх татварын жилд тайлагнасан албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээнд үндэслэнэ.

26.4.Албан татвар төлөгч холбогдох татварын тайланг жилийн эхнээс өссөн дүнгээр гаргана.

26.5.Албан татвар төлөгч холбогдох татварын тайланд энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу суутган ногдуулсан татварын тайланг хавсаргана.

26.6.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчид орлого олгосон суутган төлөгч нь хувь хүн бол энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу суутган ногдуулсан татварын тайланг Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу тайлагнах албан татварын тайланд хавсаргана.

26.7.Тайлант жилд үүсгэн байгуулагдсан албан татвар төлөгч энэ хуулийн 26.2-т заасны дагуу татварын тайлан гаргана.

26.8.Албан татвар төлөгч үйл ажиллагаа эрхлээгүй тухай тайлан гаргасан жилийн дараагийн татварын жилээс эхлэн жилд нэг удаа дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд хүргүүлнэ.

26.9.Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж нь энэ хуулийн дагуу тухайн татварын жилд тусгай зөвшөөрөл тус бүрд хамаарах татварын тайланг тус тус гаргаж, албан татварын тооцоо хийнэ.

26.10.Доор дурдсан нөхцөлийг нэгэн зэрэг хангасан тохиолдолд энэ хуулийн 26.9-д заасан тайланг нэгтгэн гаргаж болно:

26.10.1.албан татвар төлөгчийн эзэмшил дэх тусгай зөвшөөрөл бүхий талбай хоорондоо хиллэдэг бол;

26.10.2.ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн хувьд ашиглах бүтээгдэхүүний нэр төрөл ижил бол.

26.11.Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайг энэ хуулийн 26.10-т заасны дагуу нэгтгэн тайлагнахгүй.

26.12.Энэ хуулийн 26.10-т заасны дагуу татварын тайланг дараагийн татварын жилд нэгтгэн гаргах тухай хүсэлтийг тухайн татварын жилийн 09 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гаргана.

26.13.Энэ хуулийн 26.12-т заасан хүсэлтийг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага 30 хоногийн дотор хянан, хүсэлтийг баталгаажуулах эсэх талаар хариу мэдэгдэнэ.

26.14.Энэ хуулийн 24.4-т заасны дагуу тодорхойлон ногдуулсан албан татварыг албан татвар төлөгч энэ хуульд заасан хугацаанд тайлагнана.

26.15.Энэ хуулийн 22.5.11-д заасан хөнгөлөлтийг эдлэх аж ахуйн нэгж нь тухайн төсөлд хамаарах орлого, хасагдах зардал, алдагдал, хөнгөлөлт, чөлөөлөлт зэрэг татварын тооцоог хийж, тухайн төслийн татварын тайланг тусдаа гаргаж тайлагнана.

/Энэ хэсгийг 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

1994 оны 5 дугаар сарын 31-ний өдөр

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Нийгмийн даатгалын шимтгэл

15 дугаар зүйл.Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, төлөх хугацаа

1.Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө:

Нийгмийн даатгалын төрөл	Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/	Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/
Тэтгэврийн даатгал	8.5	8.5
Тэтгэмжийн даатгал	1.0	0.8
Эрүүл мэндийн даатгал	2.0	2.0
Ажилгүйдлийн даатгал	0.2	0.2
Шимтгэлийн дүн	11.7	11.5

/Энэ хэсэгт 2021 оны 6 дугаар сарын 11-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

/Энэ хэсэгт 1997 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан, энэ хэсгийг 2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ хэсэгт 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хууль, 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хууль, 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/

2.Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1,0 хувиас багагүй байна. */Энэ хэсэгт 2021 оны 6 дугаар сарын 11-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ хэсэгт 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

3. Эрүүл мэндийн даатгалын хэлбэр, хамрах хүрээ, шимтгэлийн хэмжээ болон эрүүл мэндийн даатгалтай холбогдсон бусад харилцааг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар зохицуулна.

/Энэ хэсгийг 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмсэн/

4. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хамаарагдах даатгуулагчийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг ажил олгогч бүрэн төлнө.

5. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагаас хамааралтайгаар ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос 2.8 хүртэл хувиар ялгавартай тогтоох бөгөөд ялгавартайгаар шимтгэл төлөх ажил олгогчийн жагсаалт, шимтгэлийн хувь хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан Засгийн газар тогтооно.

/Энэ хэсгийг 1997 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хууль, 2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөн найруулсан, энэ хэсэгт 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

6. Тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоох газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтыг хөдөлмөрийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

НӨХӨРЛӨЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

1995 оны 5 дугаар сарын 11-ний өдөр

2 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1/”үүсгэн байгуулах гэрээ” гэж хэд хэдэн этгээд ашиг олох зорилгоор эд хөрөнгөө нэгтгэн энэ хуульд заасан хэлбэрээр зохион байгуулагдаж тодорхой төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахаар хэлэлцэн тохирч бичгээр байгуулсан хэлцлийг хэлнэ;

2/”үүсгэн байгуулах баримт бичиг” гэж эрх бүхий байгууллагын шийдвэр, нөхөрлөлийн гэрээ /төсөл/, дүрмийг хэлнэ;

3/”гишүүн” гэж нөхөрлөлд хөрөнгө оруулсан этгээдийг хэлнэ. Хувь хүн, нөхөрлөл, төрийн эрх бүхий байгууллага гишүүн байж болно.

3 дугаар зүйл. Нөхөрлөлийн хэлбэр

1. Нөхөрлөл дор дурдсан хэлбэрээр зохион байгуулагдаж болно:

1/бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай;

2/зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай.

3/хязгаарлагдмал хариуцлагатай.

/Энэ заалтыг 2013 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн/

4 дүгээр зүйл. Гадаад худалдааны эрх

Нөхөрлөл эдийн засгийн гадаад харилцаанд бие даан оролцох эрхтэй.

5 дугаар зүйл. Зөвшөөрөл авах

/Энэ зүйлийн гарчигт “Тусгай зөвшөөрөл” гэснийг “Зөвшөөрөл” гэж 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

1.Зөвшөөрөл шаардлагатай үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх нөхөрлөл хууль тогтоомжид заасан журмын дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авна.

/Энэ хэсэгт “тусгай” гэснийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

/Энэ хэсэгт “Тусгай зөвшөөрөл” гэснийг “Зөвшөөрөл” гэж 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

2.Нөхөрлөл татан буугдах үед эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл хүчингүй болох бөгөөд бүртгэх байгууллага энэ тухай зөвшөөрөл олгосон байгууллагад мэдэгдэнэ.

/Энэ хэсэгт “тусгай” гэснийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

7 дугаар зүйл. Нөхөрлөл нэгдэх

Нөхөрлөл үйл ажиллагаагаа зохицуулах, ашиг сонирхлоо төрийн болон бусад байгууллагад төлөөлөх зорилгоор нутаг дэвсгэрийн болон бусад чиглэлээр Иргэний хуульд зааснаар нэгдэж болно.

8 дугаар зүйл. Нөхөрлөлийн нэр

1.Нөхөрлөл оноосон нэртэй байна. Оноосон нэр товч бөгөөд төрийн албан бичгээр илэрхийлэгдсэн, бусад нөхөрлөлийн оноосон нэртэй давхардаагүй байна.

2.Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан хэлбэрээр зохион байгуулагдаж байгаа аж ахуйн нэгжүүдийг энэ хуульд зааснаас өөрөөр нэрлэхийг хориглоно.

9 дүгээр зүйл. Нөхөрлөлийг бүртгэх

1.Нөхөрлөлийг оршин байгаа газрынх нь нутаг дэвсгэрийн бүртгэх байгууллага улсын бүртгэлд бүртгэнэ.

/Энэ хэсэгт 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2.Гадаад улсад байгуулагдсан бөгөөд энэ хуульд заасан нөхөрлөлтэй адил төрлийн хуулийн этгээд, тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газар Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулахаар бол Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу бүртгүүлж, Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

/Энэ хэсэгт 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

3.Нөхөрлөлийг бүртгэгдсэн өдрөөс эхлэн байгуулагдсанд тооцно.

12 дугаар зүйл. Оршин байгаа газар, түүнийг өөрчлөх

1.Нөхөрлөлийн оршин байгаа газрыг тэдгээрийн ерөнхий захиргаа байршин байгаа газраар тодорхойлно.

/Энэ хэсэгт 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

2.Нөхөрлөл оршин байгаа газраа өөрчлөхөөр бол энэ тухайгаа харьяаллынхаа бүртгэх байгууллагад 14 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

3.Бүртгэх байгууллага энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш хоёр хоногийн дотор шилжилт хийсэн тухай улсын бүртгэлд тэмдэглэл хийж, шинээр орших газрын харьяаллын бүртгэх байгууллагад бичгээр мэдэгдэх бөгөөд түүнд тухайн нөхөрлөлтэй холбогдолтой бүх баримт бичгийг хавсаргана.

/Энэ хэсэгт 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан.

13 дугаар зүйл. Нөхөрлөл зохион байгуулалтын төрөл, хэлбэрээ өөрчлөх

Нөхөрлөл хуульд заасан төрөл, хэлбэрээр энэ хуульд болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу өөрчлөгдөн зохион байгуулагдаж болно.

/Энэ зүйлд 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

18 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

/Энэ зүйлийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

18.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

18.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

/Энэ бүлгээс “компани”, “салбар” гэсэн үгийг 1999 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хассан/

ХОЁРДУГААР БҮЛЭГ

БҮХ ГИШҮҮД НЬ БҮРЭН ХАРИУЦЛАГАТАЙ НӨХӨРЛӨЛ

19 дүгээр зүйл.Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл

1.Нөхөрлөлийн хүлээсэн үүргийг гишүүд нь нөхөрлөлд оруулсан эд хөрөнгө болон хувийн өмчийн эд хөрөнгөөрөө хамтран хариуцдаг нөхөрлөлийг бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэнэ.

2.Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн оноосон нэрийн ард “ББ” гэсэн ялгах тэмдэг хэрэглэнэ.

20 дугаар зүйл. Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл байгуулах, бүртгүүлэх

1.Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл / цаашид нөхөрлөл гэх/ -ийг энэ хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэрээний үндсэн дээр байгуулна.

2.Гэрээнд дор дурдсан зүйлийг заавал тусгана:

1/нөхөрлөлийн оноосон нэр, оршин байгаа газрын хаяг;

2/эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, үйл ажиллагаа явуулах хугацаа;

3/удирдах, төлөөлөх эрх бүхий этгээдийн овог нэр, хаяг, иргэний бүртгэлийн дугаар;

/Энэ заалтад 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

4/гишүүн тус бүрийн нөхөрлөлд оруулсан хөрөнгийн хэмжээ, үнэлгээ, үнэлэх аргачлал, буцаан олгох нөхцөл болон үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн дугаар;

/Энэ заалтад 1997 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хуулиар нэмэлт орсон/

5/хэрвээ ажиллах чадвараа нэгтгэж байгаа бол түүний үнэлгээ, үнэлэх аргачлал, үзүүлэх үйлчилгээ, хугацаа;

6/ашиг, алдагдал хуваах зарчим;

7/гэрээ байгуулсан он, сар, өдөр;

8/гишүүдийн овог, нэр, иргэний харьяалал, хаяг, гарын үсэг;

9/шаардлагатай гэж үзсэн бусад зүйл.

3.Гишүүд гэрээ баталснаас хойш 15 өдрийн дотор бүртгэх байгууллагад бүртгүүлэх тухай өргөдөл гаргана.

/Энэ хэсэгт 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хэсэгт 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

21 дүгээр зүйл. Нөхөрлөлийн удирдлага, хяналт

1.Гишүүн бүр нөхөрлөлийг удирдах, төлөөлөх эрхтэй.

2.Гэрээнд нөхөрлөлийг удирдах, төлөөлөх эрхийг нэг буюу хэд хэдэн гишүүнд олгохоор зааж болно.

3.Удирдах эрх бүхий гишүүд олонхын саналаар шийдвэр гаргах бөгөөд шийдвэртэй холбогдон үүсэх хариуцлагыг хамтран хариуцна.

4.Нөхөрлөлийг удирдах эрх бүхий гишүүд нөхөрлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, энгийн бүртгэл хөтөлнө.

5.Удирдах, төлөөлөх эрх бүхий гишүүдийн болон нөхөрлөлийн үйл ажиллагаанд бусад гишүүд хяналт тавина.

6.Удирдах, төлөөлөх эрх бүхий гишүүнийг удирдах үүргээ зохих ёсоор биелүүлээгүй гэж үзвэл гишүүд түүнийг уг үүргээс чөлөөлж болно.

7.Нөхөрлөлийг удирдах, төлөөлөх эрх бүхий гишүүн нөхөрлөлийн үйл ажиллагааны талаар бусад гишүүдэд байнга мэдээлнэ.

22 дугаар зүйл. Нөхөрлөл, гишүүдийн хоорондын харилцаа

1.Гишүүд үйл ажиллагаа явуулахад шаардагдах мөнгө, эд хөрөнгө, ажиллах чадвараа үнэлж нэгтгэн нөхөрлөлд оруулна.

2.Гишүүн нь нөхөрлөлийн үйл ажиллагаанд заавал биечлэн оролцоно.

3.Нөхөрлөлийн гишүүн өөр нөхөрлөлийн гишүүн байхыг хориглоно.

4.Гишүүдээс нөхөрлөлд оруулсан хувь хөрөнгийн хэмжээг үндэслэн гишүүн тус бүрийн саналын эрхийн тоог гэрээнд тусгана.

5.Гишүүд дор дурдсан асуудлыг заавал санал нэгтэй шийдвэрлэнэ:

1/гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

2/үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлийг өөрчлөх.

Гэрээнд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг гишүүдийн саналын эрхийн дийлэнх олонхиор шийдвэрлэнэ.

23 дугаар зүйл. Нөхөрлөлд орох, нөхөрлөлөөс гарах, хасагдах

1.Нөхөрлөлд шинээр гишүүнээр орж болох бөгөөд нөхөрлөлийн хүлээсэн үүргийг бусад гишүүдийн нэг адил хариуцна.

2.Нөхөрлөлөөс дор дурдсан үндэслэлээр гарна:

1/гэрээнд заасан хугацаа дууссан;

2/гэрээнд заасан бусад нөхцөл.

3.Нөхөрлөлөөс дор дурдсан үндэслэлээр хасагдана:

1/гэрээгээр хүлээсэн үйлчилгээ үзүүлэх үүргээ биелүүлэх чадваргүй, эсхүл хөрөнгөө оруулах боломжгүй нь тогтоогдсон;

2/гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн.

4.Нөхөрлөлөөс хасагдах үндэслэлийг тухайн гишүүнд урьдчилан мэдэгдэнэ. Хасах тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхэд уг гишүүн санал өгөх эрхгүй.

5.Хасагдсан гишүүн шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.

6.Гэрээнд өөрөөр заагаагүй бол нөхөрлөлөөс гарсан буюу хасагдсан гишүүний нөхөрлөлд оруулсан хөрөнгийг гарсан өдрөөс нь хойш 3 сарын дотор буцаан олгоно.

24 дүгээр зүйл. Ашиг, алдагдал хуваах зарчим

Гэрээнд өөрөөр заагаагүй бол нөхөрлөл жил бүр ашиг, алдагдлаа тодорхойлно. Гишүүдэд ногдох ашиг, алдагдал нь тэдгээрээс нөхөрлөлд оруулсан хөрөнгөтэй хувь тэнцүү байна.

/Энэ зүйлд 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

25 дугаар зүйл. Эд хөрөнгө хуваах

1.Нөхөрлөл татан буугдсаны дараа гишүүд нөхөрлөлд оруулсан хөрөнгөө буцаан авах эрхтэй. Гэхдээ харилцагчдын төлбөрийг бүрэн барагдуулах хүртэл нөхөрлөлийн хөрөнгийг гишүүдэд хувааж болохгүй.

2.Нөхөрлөлийн төлбөрийг бүрэн барагдуулсны дараа гишүүдийн оруулсан хөрөнгийг буцаан олгож, үлдэх эд хөрөнгийг гишүүдэд оруулсан хөрөнгөтэй нь хувь тэнцүү хуваана. Эд хөрөнгийн хэлбэрээр оруулсан хөрөнгийг биет байдлаар нь буцаан олгох боломжгүй бол гэрээнд заасан үнэлгээ, нөхцөлийг баримтална.

3.Нөхөрлөлийн эд хөрөнгө төлбөр барагдуулахад хүрэлцэхгүй бол гэрээнд гишүүн тус бүр саналын нэг эрхтэй байхаар зааснаас бусад нөхцөлд гишүүдээс оруулсан хөрөнгөтэй хувь тэнцүү хэмжээгээр тэдгээрийн хувийн өмчийн эд хөрөнгөөс гаргуулж, харилцагчдын төлбөрийг бүрэн барагдуулна.

26 дугаар зүйл. Татан буугдах онцлог

Аль нэг гишүүн нөхөрлөлөөс гарсан, хасагдсан, хөрөнгийн чадваргүй болсон буюу нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон гишүүний өв залгамжлагч тухайн нөхөрлөлд ороогүй тохиолдолд нөхөрлөл татан буугдана. Гэхдээ тухайн нөхөрлөл цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулахаар бол гэрээгээ шинэчилж бүртгэх байгууллагад дахин бүртгүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ**ЗАРИМ ГИШҮҮД НЬ БҮРЭН ХАРИУЦЛАГАТАЙ НӨХӨРЛӨЛ****27 дугаар зүйл.Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл**

1.Нөхөрлөлийн хүлээсэн үүргийг наад зах нь нэг гишүүн нөхөрлөлд оруулсан хөрөнгө болон хувийн өмчийн эд хөрөнгөөрөө бүрэн хариуцдаг, бусад гишүүд нь гагцхүү нөхөрлөлд оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцдаг нөхөрлөлийг зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэнэ.

2.Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн оноосон нэрийн ард “ЗБ” гэсэн ялгах тэмдэг хэрэглэнэ.

28 дугаар зүйл. Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн онцлог

1.Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл байгуулах гэрээнд энэ хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас гадна гишүүн тус бүрийн хариуцлагыг ялгаж заана.

2.Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн гагцхүү бүрэн хариуцлага хүлээдэг гишүүд нөхөрлөлийг удирдах, төлөөлөх эрхтэй.

3.Энэ хуулийн 22 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт бүрэн хариуцлагатай гишүүдэд нэг адил хамаарна.

4.Оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцлага хүлээдэг гишүүд нөхөрлөлийн үйл ажиллагаанд биечлэн оролцохгүй байж болно.

5.Оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцлага хүлээдэг гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох нь тухайн нөхөрлөлийг татан буулгах үндэслэл болохгүй. Харин тэдгээр нь бүгд гарвал нөхөрлөл татан буугдана.

6. Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан тохиолдолд үлдсэн гишүүдийн шийдвэрээр уг нөхөрлөл бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн хэлбэрээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж болно. Энэ тохиолдолд гэрээгээ шинэчлэн, бүртгэх байгууллагад дахин бүртгүүлнэ.

7.Оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцлага хүлээдэг гишүүд нөхөрлөлийг татан буулгах үед оруулсан хөрөнгөө тэргүүн ээлжид буцаан авах давуу эрхтэй байна.

8.Энэ зүйлийн 1-7 дахь хэсэгт заасан онцлогоос бусад харилцаа энэ хуулийн 2 дугаар бүлгийн холбогдох зүйл, заалтын дагуу зохицуулагдана.

ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬ

2022 оны 04 сарын 22 өдөр

/Шинэчилсэн найруулга/

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.2.”үнэт металл” гэж алт, мөнгө, платина болон түүний бүлэгт багтдаг палладий, иридий, родий, рутений, осмийг

3.1.4.”Эрдэнэсийн сан” гэж төрийн нэрийн өмнөөс Монголбанк эрхэлж, бүрдүүлж, хамгаалж, эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулж байгаа эрдэнэс, түүний дагалдах зүйл, хөрөнгийн хуримтлалыг;

7 дугаар зүйл.Монголбанкны бүрэн эрх

7.1.2.Эрдэнэсийн сангийнэрдэнэс, хөрөнгийн хөдөлгөөний бүртгэл хийж, төлбөр тооцоог гүйцэтгэх;

7.1.3.Энэ хуулийн 5.1.3-т заасан саналыг боловсруулж, Улсын Их Хуралд хүргүүлэх;

7.1.4.Эрдэнэсийн санд эрдэнэс худалдан авах, гүйлгээ сангаас эрдэнэс худалдах, арилжих болон үнийг тогтоох;

7.1.5.эрдэнэсийн зах зээлийн үнийн судалгааг гаргах;

7.1.7.Эрдэнэсийн санг эрхлэхтэй холбоотой журам батлах, холбогдох шийдвэр гаргах;

15 дугаар зүйл.Хүн, хуулийн этгээд, бусад байгууллагын эрх, үүрэг

15.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт эрдэнэс эзэмшигч хүн, хуулийн этгээд, бусад байгууллага нь эрдэнэсийн санд худалдах эрдэнэс, тэдгээрээр хийсэн эдлэлийг сорьц тогтоох эрх бүхий хуулийн этгээд, эсхүл сорьцын асуудалэрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар сорьц тогтоолгон баталгаажуулсан байх үүрэгтэй.

15.2.Хүн, хуулийн этгээд, бусад байгууллага нь эрдэнэсийн санд худалдах болон хадгалуулах эрдэнэсийн үнийг хэлэлцэн тохирох, нэхэмжлэн авах эрхтэй.

ВАЛЮТЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ

1994 оны 05 дугаар сарын 12-ны өдөр

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

1. “Валют” гэж Монгол Улсын үндэсний валют, гадаад валют, улс хоорондын худалдаа, эдийн засгийн харилцааны төлбөрт хэрэглэгдэж буй тооцооны нэгж, мөнгөжсөн алт болон валютын үнэт зүйлсийг хэлнэ.

4. “Мөнгөжсөн алт” гэж олон улсын жишигт хүргэн цэвэршүүлж, олон улсын санхүүгийн аль нэг төвд хадгалуулж байгаа, гадаад валютаар борлуулахад бэлэн болсон алтыг хэлнэ.

5. “Валютын үнэт зүйлс” гэж мөнгөжсөн алттай адилтгах үнэт металл, эрдэнийн чулууг хэлнэ.

6. “Цэвэршүүлсэн алт” гэж алтны агуулгыг нь нэмэгдүүлж цэвэршүүлсэн боловч гадаад валютаар шууд борлуулах нөхцөл хангагдаагүй алтыг хэлнэ.

8 дугаар зүйл. Монголбанкны бүрэн эрх

Монголбанк нь валютын зохицуулалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ улсын хэмжээнд валютын гүйлгээг зохицуулж, хэрэгжүүлэх;

2/ улсын валютын гадаад нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

3/ Монгол Улсын болон гадаадын валютын зах дээр эрх хэмжээнийхээ дотор валютын гүйлгээ, гадаад төлбөр, тооцоо эрхлэх;

4/ төрийн өмчид байвал зохих валютын гадаад цэвэр нөөцийн доод хэмжээ тогтоох тухай санал боловсруулж шийдвэрлүүлэх, түүнийг хадгалах, оновчтой, үр ашигтай байршуулах;

5/ Засгийн газрын валютын гүйлгээ, гадаад төлбөр, тооцоог гүйцэтгэх;

7/ валютын гүйлгээний тайлан, мэдээ гаргах журмыг тогтоох;

8/ валютын гүйлгээний нэгдсэн тайлан, мэдээг Улсын Их Хуралд улирал бүр оруулж байх;

9/ хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

10 дугаар зүйл. Монголбанкны эрхлэх валютын гүйлгээ

1. Монголбанк нь Монгол Улсын валютын гадаад нөөцийг нэмэгдүүлэх, зохицуулах зорилгоор тус улсын болон гадаад орны банк, бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс валют, цэвэршүүлсэн алт худалдан авч болно.

2. Монголбанк нь төгрөгийн ханшийг тогтвортой байлгах зорилгоор өөрийн эзэмшилд байгаа валютын гадаад нөөцөөс гадаад валютыг худалдана.

**— УЛСЫН ИХ ХУРЛААС ТОМИЛОГДДОГ БАЙГУУЛЛАГЫН ДАРГА, —
ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ АЛБАН ТУШААЛТНЫ ШИЙДВЭР**

**МОНГОЛ УЛС САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2020 он 03 сар 25 өдөр

Дугаар 150

Улаанбаатар хот

“Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.3.1, 6.3.2, 6.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ 2020 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй этгээдүүдэд үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын 2 дахь заалтыг хэрэгжүүлээгүй этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу арга хэмжээ авч ажиллахыг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны
2020 оны 120 дугаар тогтоолын хавсралт

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОЛТ, БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл /цаашид “тусгай зөвшөөрөл” гэх/, зөвшөөрөл олгох, бүртгэхэд тавигдах нөхцөл шаардлагыг тодорхойлох, тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг олгох, олгохоос татгалзах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Тайлбар: “үнэт металл” гэж Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт заасныг, “үнэт чулуу” гэж Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт тус тус заасныг ойлгоно.

1.2. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч этгээд /цаашид “арилжаа эрхлэгч этгээд” гэх/ тусгай зөвшөөрлийн хүрээнд дараах үйл ажиллагаа эрхэлнэ:

1.2.1. үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэх;

1.2.2. үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх.

1.3. Арилжаа эрхлэх этгээдийн үйл ажиллагааг энэ журамд заасан тусгай зөвшөөрөлтэй этгээд эрхэлнэ.

Хоёр. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага

2.1. Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь мөнгөн хөрөнгө байх бөгөөд дараах шаардлагыг хангана:

2.1.1. суманд үйл ажиллагаа эрхлэх бол 5,000,000 /таван сая/ төгрөг;

2.1.2. аймгийн төвд үйл ажиллагаа эрхлэх бол 25,000,000 /хорин таван сая/ төгрөг;

2.1.3. нийслэлд үйл ажиллагаа эрхлэх бол 50,000,000 /тавин сая/ төгрөг.

2.2. Үнэт металл, үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь мөнгөн хөрөнгө байх бөгөөд дараах шаардлагыг хангана:

2.2.1. суманд үйл ажиллагаа эрхлэх бол 1,000,000 /нэг сая/ төгрөг;

2.2.2. аймгийн төвд үйл ажиллагаа эрхлэх бол 3,000,000 /гурван сая/ төгрөг;

2.2.3. нийслэлд үйл ажиллагаа эрхлэх бол 10,000,000 /арван сая/ төгрөг.

2.3. Арилжаа эрхлэгч этгээд нь хуулийн этгээд бол дараах нөхцөл, шаардлагыг хангана:

2.3.1. холбогдох хуульд заасны дагуу үүсгэн байгуулагдсан, Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байх;

2.3.2. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан байх;

2.3.3. хувь нийлүүлсэн хөрөнгийг мөнгөн хөрөнгөөр бүрдүүлэх бөгөөд зээлийн эх үүсвэрээр бүрдүүлээгүй, хууль ёсны орлого байх;

2.3.4. үйл ажиллагаа явуулах ажлын байр, зориулалтын тоног төхөөрөмжтэй байх;

2.3.5. хоёроос доошгүй ажилтантай байх /гэрээт болон орон тооны бус ажилтан байж болно/;

2.3.6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан томилсон байх /гүйцэтгэх захирал давхар эрхэлж болно/;

2.3.7. эрхлэх үйл ажиллагааг зохицуулсан дотоод журам, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй байх;

2.3.8. эрхлэх үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөтэй байх;

2.3.9. энэ журмын 1 дүгээр хавсралт дахь маягтын дагуу өргөдөл гаргаж, 4 дүгээр хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд ирүүлсэн байх;

2.3.10. эрх бүхий албан тушаалтан нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх;

2.3.11. Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад баримт бичгийг шаардаж болно.

2.4. Арилжаа эрхлэх этгээд нь хувь хүн бол дараах шаардлагыг хангасан байна:

2.4.1. үйл ажиллагаа явуулах ажлын байр, зориулалтын тоног төхөөрөмжтэй байх;

2.4.2. энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу өргөдөл гаргаж, 5 дугаар хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд ирүүлсэн байх;

2.4.3. Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх.

2.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах нийтлэг шаардлагыг хангаж ажиллана:

2.5.1. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Компанийн тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай болон холбогдох бусад хууль, тогтоомж, Хорооноос баталсан журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана;

2.5.2. арилжаа эрхлэгч этгээд нь 20 сая төгрөг болон түүнээс дээш бэлэн мөнгөний гүйлгээ хийх тохиолдолд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтад зааснаар Мэдээлэх үүрэгтэй этгээдэд тооцогдоно;

2.5.3. мэдээлэх үүрэгтэй этгээдэд тооцогдсон арилжаа эрхлэгч этгээд нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан үүргийг хэрэгжүүлнэ;

2.5.4. хэрэв хуулийн этгээдийн дүрэмд 20 сая төгрөг болон түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээг хийхгүй байх талаар зохицуулалт тусгагдсан бол энэ журмын 2.5.2 дахь заалт хамаарахгүй;

2.5.5. Хорооноос зохион байгуулсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр сертификатжуулсан сургалтад холбогдох албан тушаалтан нь хамрагдсан байх;

Тайлбар: Энэ заалт нь 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжинэ.

2.5.6. Хорооноос баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу Холбооноос зохион байгуулагдсан сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцэж, сертификат авсан байх;

Тайлбар: Энэ заалт нь 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжинэ.

2.5.7. Хорооноос баталсан журмын дагуу жил бүр болон тухай бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тогтоосон хэмжээгээр журамд заасан хугацаанд төвлөрүүлэх;

2.5.8. Хорооноос баталсан холбогдох журмын дагуу харилцагчийн талаарх бүртгэлийг хөтөлдөг байх;

2.5.9. Хорооноос тавигдах шаардлага, шалгуурыг хангаж ажиллах;

2.5.10. холбогдох хууль тогтоомжийн дагуу Хорооны хяналт, шалгалтад хамрагдах;

2.5.11. худалдах үнэт металл, үнэт чулуу, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийг сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар сорьц тогтоолгон баталгаажуулсан байх.

Тайлбар: Энэ заалт нь 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжинэ.

2.5.12. энэ журмын 2.5.11 дэх заалт нь Монголбанк болон түүнээс эрх олгосон банкинд худалдсан үнэт металлд хамаарахгүй.

Тайлбар: 2.5.11-д заасан мөрдөх хугацаа эхлэхэд энэ заалт хүчингүй болно.

2.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч арилжаа эрхлэгч этгээд нь хувь хүн бол энэ журмын 2.4, 2.5.1-2.5.3, 2.5.5-2.5.10-д заасан шаардлагыг тогтмол хангаж ажиллана.

Гурав. Тусгай зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах

3.1. Тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл, баримт бичгийг Хорооны холбогдох ажилтан хянаж, зөвлөгөө өгөх бөгөөд тухайн өргөдөл, баримт бичгийн бүрдүүлбэр, шаардлагыг хангасан гэж үзвэл Хорооны бичиг хэрэгт бүртгүүлнэ.

3.2. Тусгай зөвшөөрөл олгох эсэхийг тусгай зөвшөөрөл хүсэж ирүүлсэн өргөдөл, холбогдох баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд, холбогдох хууль тогтоомж болон энэхүү журамд заасан шаардлагуудыг хангаж Хороонд ирүүлсэн өдрөөс эхлэн ажлын 21 хоногийн дотор шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд хугацааг 14 хоногоор сунгаж болно.

3.3. Энэ журмын 1.2-т заасан тусгай зөвшөөрлийг олгох эсэх асуудлыг Хорооны хуралдаанаар шийдвэрлэнэ.

3.4. Хороо өргөдлийн мэдээлэл, бүрдүүлсэн баримт бичигтэй холбоотойгоор нэмж тодруулах шаардлагатай гэж үзвэл өргөдөл гаргасан этгээдэд албан бичгээр мэдэгдэж, нэмэлт мэдээлэл, баримт бичгийг шаардаж болох бөгөөд нэмэлт баримт бичгийг хууль, журамд заасан шаардлагыг ханган ирүүлсэн өдрөөс эхлэн энэ журмын 3.2-т заасан хугацааг тооцно.

3.5. Хороо тусгай зөвшөөрлийг хугацаагүйгээр олгох бөгөөд тус шийдвэрт тухайн хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагааг тодорхой тусгана.

3.6. Тусгай зөвшөөрөл олгосон тухай шийдвэрийг үндэслэн Хороо тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгож, нэгдсэн бүртгэлд бүртгэн, зохих зааврын дагуу хувийн хэрэг нээн хөтөлнө.

3.7. Энэ журмын 3.4-т заасан Хорооны шийдвэрийг үндэслэн арилжаа эрхлэгч этгээд нь Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлснээр үйл ажиллагаа эхлүүлсэнд тооцно.

3.8. Тусгай зөвшөөрөл олгогдсонтой холбоотой өөрчлөлтийг энэ тухай шийдвэр гарснаас хойш ажлын 15 хоногийн дотор Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, нотариатаар гэрчлүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээний болон дүрмийн хуулбарыг Хороонд ирүүлнэ.

3.9. Хороо дараах үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана:

3.9.1. хуулийн этгээд бол энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангаагүй;

3.9.2. тусгай зөвшөөрөл хүсэж ирүүлсэн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн болох нь тогтоогдсон;

3.9.3. холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан бусад нөхцөл, шаардлагыг хангаагүй;

3.9.4. тусгай зөвшөөрөл хүсэж ирүүлсэн баримт бичгийг энэхүү журмын шаардлагад нийцэхүйц хэмжээнд бүрдүүлэх хугацаа нь хүсэлт тавьсан өдрөөс хойш 6 сарын хугацаатай байх бөгөөд тус хугацаа өнгөрсөн;

3.9.5. хувь нийлүүлсэн хөрөнгийг зээлийн эх үүсвэрээр бүрдүүлсэн эсхүл мөнгөн хөрөнгийг хууль ёсны үйл ажиллагаанаас олсон болох нь нотлогдоогүй, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хангаагүй;

3.9.6. хууль тогтоомжид заасан бусад нөхцөл, шаардлагыг хангаагүй.

3.10. Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд Хороо энэ талаарх үндэслэл бүхий тайлбарыг өргөдөл гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

3.11. Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн гэдэг үндэслэлээр татгалзсан өдрөөс хойш тухайн өргөдөл гаргагч этгээдээс тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг 1 жилийн дотор дахин хүлээн авахгүй.

Дөрөв. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох

4.1. Тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр 3 сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлнэ:

4.1.1. энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн, тэдгээрт заасан шаардлагыг хангаагүй;

4.1.2. ирүүлбэл зохих тайлан, мэдээг 3 улирал дараалан Хороонд ирүүлээгүй;

4.1.3. тусгай зөвшөөрөл авснаас хойш 3 улирал дараалан үйл ажиллагаа эрхлээгүй;

4.1.4. төвлөрүүлбэл зохих зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төлөх хугацааг 3 сараас дээш хугацаагаар хэтрүүлсэн;

4.1.5. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангаж ажиллаагүй;

4.1.6. үйлчлүүлэгч болон иргэдийн ашиг сонирхолд хохирол учруулахуйц нөхцөл байдал үүссэн гэж Хороо үзсэн болон анхан шатны шүүхийн шийдвэр гарсан;

4.1.7. холбогдох хууль тогтоомжийн дагуу Хорооноос өгсөн даалгаврыг биелүүлээгүй;

4.1.8. Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаагүй;

4.1.9. Хорооноос хийсэн зайны хяналт шалгалтаар өндөр эрсдэлтэй гэж дүгнэсэн, газар дээр шалгалтаар хангалтгүй үнэлгээ авсан;

4.1.10. сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналыг үндэслэн;

4.1.11. гарал үүсэл тодорхой бус үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхэлсэн бол;

4.1.12. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

4.2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхээс өмнө Хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэлийг заасан мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлж, хүргэсэн огноог тэмдэглэнэ.

4.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ журмын 4.2-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж үзсэн тайлбарыг Хороонд ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

4.4. Ирүүлсэн тайлбарыг үндэслэлгүй, гаргасан зөрчил арилаагүй гэж үзвэл Хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

4.5. Хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн шийдвэрийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид албан бичгээр мэдэгдэнэ.

4.6. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх шийдвэр гарсан өдрөөс тусгай зөвшөөрлийг сэргээх шийдвэр гарах хүртэл уг үйл ажиллагааг эрхлэхгүй.

4.7. Түдгэлзүүлсэн үндэслэл болсон зөрчил, дутагдлыг арилгаж, хэвийн үйл ажиллагаагаа хангасан тохиолдолд тухайн этгээдийн хүсэлтийг үндэслэн Хороо тусгай зөвшөөрлийг сэргээж болно:

4.7.1. тусгай зөвшөөрлийг сэргээх тухай хүсэлт, энэхүү журмын 7 дугаар хавсралтад заасан баримт бичгийн бүрдэл, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэл болсон зөрчил дутагдлыг арилгасан болохыг нотлох баримт бичгийн хамт Хороонд ирүүлнэ;

4.7.2. мэргэжлийн холбооноос ирүүлсэн саналыг үндэслэн;

4.7.3. Хороо энэ журмын 4.8-д заасан баримт бичгийг ирүүлснээс хойш ажлын 14 хоногийн дотор хянаж, тусгай зөвшөөрлийг сэргээх эсэх асуудлыг Хорооны хуралдаанаар шийдвэрлэнэ.

4.8. Хороо дараах үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

4.8.1. тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

4.8.2. энэ журмын 4.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн зөрчил, дутагдлыг тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд арилгаагүй;

4.8.3. тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

4.8.4. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа зөрчсөн;

4.8.5. үйлчлүүлэгч болон иргэдийн ашиг сонирхолд хохирол учруулахуйц ноцтой нөхцөл байдал үүссэн гэж Хороо үзсэн ;

4.8.6. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй;

4.8.7. сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн;

4.8.8. гарал үүсэл тодорхой бус үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхэлсэн бол.

4.9. Энэ журмын 4.8.1-д заасны дагуу тусгай зөвшөөрөл хүчингүй болгох хүсэлт гаргаж буй тохиолдолд энэхүү журмын 8 дугаар хавсралтад заасан баримт бичгийг тусгай зөвшөөрөл хүчингүй болгохыг хүссэн хүсэлтийн хамт Хороонд ирүүлнэ.

4.10. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохоос өмнө Хороо тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох болсон үндэслэлийг заасан мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлж, хүргэсэн огноог тэмдэглэнэ.

4.11. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ журмын 4.12-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзсэн тайлбараа Хороонд ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

4.12. Ирүүлсэн тайлбарыг үндэслэлгүй, гаргасан зөрчил арилаагүй гэж үзвэл Хороо тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

4.13. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох эсэх асуудлыг Хорооны хуралдаанаар шийдвэрлэнэ.

4.14. Хорооноос тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэр гаргаснаар тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа нь дуусгавар болно.

4.15. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор энэ талаар тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигч байсан этгээдэд албан бичгээр мэдэгдэнэ.

4.16. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэр гарсан тохиолдолд Хороо энэ талаар олон нийтэд мэдээлж, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, хүчингүй тэмдэг даран, тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувийн хэрэгт хийж холбогдох хууль тогтоомжийн дагуу Хорооны архивд шилжүүлнэ.

4.17. Хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон шийдвэр гаргасан өдрөөс хойш үйл ажиллагааг үргэлжлүүлбэл тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэн холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

4.18. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосноос учирсан аливаа хохирлыг Хороо хариуцахгүй.

Тав. Зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах, хүчингүй болгох

5.1. Тусгай зөвшөөрөлтэй этгээд нь уг үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой дараах өөрчлөлтүүдийг оруулахын өмнө тухай бүр Хороонд мэдэгдэж, зөвшөөрөл авна:

5.1.1. хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах;

5.1.2. салбар, төлөөлөгчийн газар нээх;

5.1.3. оноосон нэр өөрчлөх.

5.2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай бүр зөвшөөрөл авах бөгөөд дараах шаардлага тавигдана:

5.2.1. хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн мөнгөн хөрөнгө нь хууль ёсны орлогоос бүрдсэн байх;

5.2.2. хувьцаа эзэмшигч өөрчлөгдөж байгаа бол Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх;

5.2.3. арилжаа эрхлэгч этгээдийн хувьцааг худалдан авч буй хувьцаа эзэмшигчийн хөрөнгийн гарал үүсэл нь хууль ёсны орлогоос бүрдсэн байх;

5.2.4. энэ журмын 2 дугаар хавсралт дахь маягтын дагуу өргөдөл гаргаж, 9 дүгээр хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд ирүүлсэн байх.

5.3. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд дараах хэлбэрээр өөрчлөлт оруулж болно. Үүнд:

5.3.1. хувьцаа эзэмшигчдийн мөнгөн хөрөнгөөр;

5.3.2. үндсэн үйл ажиллагааны хуримтлагдсан ашгаас хуваарилсан ногдол ашгаар нэмж хөрөнгө оруулах;

5.3.3. хувьцаа нэмж гаргах;

5.3.4. хувьцаа эзэмшигчээс оруулсан хувьцааг Иргэний хуульд заасны дагуу өвлүүлэх, бэлэглэх, өөр хоорондоо болон гуравдагч этгээдэд худалдах;

5.3.5. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангах боломжтой, санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, хохирол учруулахгүй бол хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хорогдуулах.

5.4. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зөвшөөрөл хүсэж ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор Хороонд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

5.5. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор мөнгөн хөрөнгийг хууль ёсны үйл ажиллагаанаас олсон болох нь нотлогдохгүй, эсхүл хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтцэд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн эрх бүхий этгээдийн шийдвэр болон гэрээ хэлцэл нь хуурамч тохиолдолд зөвшөөрөл олгохоос татгалзана.

5.6. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

5.7. Салбар, төлөөлөгчийн газар нээх зөвшөөрөл олгоход дараах шаардлага тавигдана:

5.7.1. үйл ажиллагаагаа явуулах нутаг дэвсгэрийн хязгаарлалтыг тодорхойлсон, хаяг байршил нь тодорхой, байнгын ажлын байр, тоног төхөөрөмжтэй байх;

5.7.2. салбарын удирдлагаар ажиллах этгээд нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх;

5.7.3. салбар, төлөөлөгчийн газрын дотоод хяналт болон бусад үйл ажиллагааг зохицуулах журамтай байх;

5.7.4. энэ журмын 2 дугаар хавсралт дахь маягтын дагуу өргөдөл гаргаж, 10 дугаар хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд ирүүлсэн байх.

5.8. Оноосон нэр өөрчлөх зөвшөөрөл олгоход дараах шаардлага тавигдана:

5.8.1. оноосон нэрээ өөрчлөх нь үйлчлүүлэгчдэд сөргөөр нөлөөлөхгүй, төөрөгдүүлэхгүй байх;

5.8.2. энэ журмын 2 дугаар хавсралт дахь маягтын дагуу өргөдөл гаргаж, 11 дүгээр хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд ирүүлсэн байх.

5.9. Зөвшөөрөл хүсэж ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг холбогдох ажилтан хянаж, зөвлөгөө өгөх бөгөөд тухайн өргөдөл, баримт бичгийг бичгийн бүрдүүлбэр, шаардлагыг хангасан гэж үзвэл Хорооны бичиг хэрэгт бүртгүүлнэ.

5.10. Зөвшөөрөл хүсэж ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг хянаж, ажлын 30 хоногийн дотор Хорооны дарга шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд хугацааг 14 хоногоор сунгаж болно.

5.11. Зөвшөөрөл олгох тухай Хорооны даргын шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийж, баталгаажуулсны дараа Улсын бүртгэлийн байгууллагад холбогдох бүртгэлийг хийлгэнэ.

5.12. Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн шинэчилсэн буюу өөрчлөлт оруулсан дүрмийн эх хувь, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг Хороонд ирүүлнэ.

5.13. Салбар, төлөөлөгчийн газар нь Хорооноос олгогдсон зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэх ба салбар, төлөөлөгчийн газар тус бүр нь зөвшөөрлийн гэрчилгээтэй байна.

5.14. Хорооны зөвшөөрөлгүйгээр энэ журмын 5.1-д заасан өөрчлөлтүүдийг оруулсан тохиолдолд зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэн холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

5.15. Хорооноос тавьсан шаардлагыг хангаагүй тохиолдолд зөвшөөрөл олгохоос татгалзах бөгөөд энэ талаар гарсан Хорооны шийдвэрийг албан бичгээр хүргүүлнэ.

5.16. Салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгож зөвшөөрлийн гэрчилгээг хураан авна:

5.16.1. салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгах хуулийн этгээдийн шийдвэр;

5.16.2. холбогдох хууль тогтоомжид нийцээгүй үйл ажиллагаа явуулсан, Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй болон салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа нь тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нь тогтоогдсон;

5.16.3. салбар, төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй;

5.16.4. Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, салбар төлөөлөгчийн газарт тавигдах нөхцөл, шаардлагыг хангаагүй;

5.16.5. хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр.

5.17. Хорооны шийдвэр болон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн

баримтыг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад салбар, төлөөлөгчийн газрын талаарх тэмдэглэлийг хийж баталгаажуулах бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигчид нэгжийн гэрчилгээг олгоно.

5.18. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр.

Зургаа. Арилжаа эрхлэх этгээдийн холбогдох бүртгэл

6.1. Дараах өөрчлөлтүүдийг оруулахын өмнө тухай бүр Хороонд мэдэгдэж, бүртгүүлнэ:

6.1.1. эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдөх;

6.1.2. арилжаа эрхлэх этгээдийн хаяг өөрчлөгдөх.

6.2. Эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдөн томилогдох тухай бүр Хороонд холбогдох баримт бичгийг ирүүлж, хянуулан, бүртгүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг бүртгүүлэхэд дараах шаардлага тавигдана:

6.2.1. шинээр томилогдож буй эрх бүхий албан тушаалтан, салбар, төлөөлөгчийн газрын удирдлага нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх;

6.2.2. энэ журмын 2 дугаар хавсралт дахь маягтын дагуу өргөдөл гаргаж, 13 дугаар хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд ирүүлсэн байх.

6.3. Энэ журамд заасан холбогдох шаардлагыг хангаагүй эсхүл хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон тохиолдолд арилжаа эрхлэх этгээдийн эрх бүхий албан тушаалтан, салбар, төлөөлөгчийн газрын удирдлагын өөрчлөлтийг Хороо бүртгэхээс татгалзана.

6.4. Эрх бүхий албан тушаалтан болон салбар, төлөөлөгчийн газрын удирдлагын өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлтийн дагуу бүртгэл хийж, хариуг албан бичгээр мэдэгдэнэ.

6.5. Албан ёсны хаяг болон салбар, төлөөлөгчийн газрын хаяг өөрчлөгдсөн тохиолдолд ажлын 10 өдрийн дотор энэ журмын 2 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргасан өргөдлийг Хороонд албан бичгээр ирүүлж, бүртгүүлнэ.

6.6. Хаягийн өөрчлөлтийг бүртгэсэн бол тухайн зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад холбогдох тэмдэглэгээг хийнэ.

Долоо. Хяналт хариуцлага

7.1. Хороо энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах бөгөөд зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7.2. Хорооны шийдвэрийг үл зөвшөөрсөн этгээд шийдвэр гарснаас хойш Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт заасны дагуу Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлд гомдол гаргаж болно.

— МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ —

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 8 дугаар сарын 3-ны өдөр

Дугаар 296

Улаанбаатар хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Ашигт малтмалын тухай хуулийн 3.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг энэ тогтоолын 1-д заасан журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Ашигт малтмал, газрын тосны газар (С.Баярмандал) нарт, журмын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж)-т, журмыг хэрэгжүүлэх ажлыг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 151 дүгээр тогтоол, “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 355 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД

Г.ЁНДОН

Засгийн газрын 2022 оны 296 дугаар
тогтоолын хавсралт

БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Энэ журам нь ус, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт болон түгээмэл тархацтайгаас бусад төрлийн ашигт малтмалыг бичил уурхайгаар олборлох үйл ажиллагаанд хамаарна.

1.3.Энэ журмын зорилго нь үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй нөөц, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд ашигт малтмалыг бичил уурхайгаар олборлох, байгаль орчныг хамгаалах, орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэхэд оршино.

1.4.Бичил уурхай эрхлэгч этгээд нь Иргэний хуулийн 35.1-д заасан нөхөрлөл, 36.4-т заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд, мөн хуулийн 481.1-д заасан бүртгэгдээгүй нөхөрлөлийн хэлбэртэй байна.

1.5.Нэг нөхөрлөл, хоршооны гишүүдийн тоо нь 9-өөс цөөнгүй байх бөгөөд гишүүн нь өөр нөхөрлөл, хоршоонд бүртгэлгүй байна.

1.6.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд өмнө нь хөндөгдөөгүй болон нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгсөн газар ашиглуулахыг хориглоно.

Хоёр. Ашигт малтмал олборлох өргөдөл гаргах, түүнийг хянан шийдвэрлэх

2.1.Бичил уурхай эрхлэгч этгээд нь бичил уурхайгаар ашигт малтмал олборлохыг хүссэн өргөдлийг тухайн сум, дүүргийн Засаг даргад энэ журмын 1 дүгээр хавсралтад заасны дагуу гаргана.

2.2.Өргөдөлд бичил уурхайгаар ашигт малтмал олборлоход ашиглах техник хэрэгслийн гэрэл зураг, техникийн үзүүлэлтийг хавсаргасан байна.

2.3.Бичил уурхай эрхлэгч этгээд нь дараахь шаардлагыг хангасан иргэнийг бичил уурхайд ажиллуулна:

2.3.1.18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн;

2.3.2.тухайн аймаг, нийслэлд оршин суугчаар бүртгүүлсэн;

2.3.3.нөхөрлөл, хоршооны гишүүн;

2.3.4.бичил уурхайн мэргэжлийн холбооны зохион байгуулсан бичил уурхайн эрх зүйн зохицуулалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нөхөн сэргээлтийн болон бичил уурхайгаар олборлох бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох сургалтад хамрагдан гэрчилгээ авсан;

2.3.5.харьяалах аймаг, нийслэлийн татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлсэн.

2.4.Энэ журмын 2.3-т заасан шаардлагыг хангаагүй иргэнийг гишүүнээр авсан бичил уурхай эрхлэгч этгээдийн гаргасан өргөдлийг хүлээн авахгүй.

2.5.Сум, дүүргийн Засаг дарга нь энэ журмын 5.1.2-т заасны дагуу тусгай хэрэгцээнд авсан газрын шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан тухайн талбайд гаргасан өргөдлийн дарааллын дагуу бичил уурхай эрхлэгч этгээдтэй бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээг энэ журмын 2 дугаар хавсралтад заасан загварын дагуу бичил уурхайн мэргэжлийн холбоотой хамтран байгуулна.

2.6.Энэ журмын 2.5-д заасан хугацаанд сум, дүүргийн Засаг дарга бичил уурхай эрхлэгч этгээдтэй гэрээ байгуулаагүй бол гэрээ байгуулаагүй үндэслэлээ өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

2.7.Энэ журмын 9.1.1-д заасан дүгнэлтээр бичил уурхайн зориулалтаар ашиглах боломжгүй нь тогтоогдвол тухайн сум, дүүргийн Засаг дарга бичил уурхай эрхлэгч этгээдэд мэдэгдэж, өргөдлийг буцаана.

2.8.Энэ журмын 2.3.4-т заасан сургалтын агуулга, хөтөлбөрийг төрийн захиргааны байгууллага, бичил уурхайн мэргэжлийн холбоо хамтран баталж хэрэгжүүлнэ.

Гурав. Бичил уурхай эрхлэгч этгээдийн эрх, үүрэг

3.1.Бичил уурхай эрхлэгч этгээд нь дараахь эрхтэй байна:

3.1.1.бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрын талаарх мэдээллийг сум, дүүргийн Засаг даргаас авах;

3.1.2.бичил уурхайгаар ашигт малтмал олборлохыг хүссэн өргөдөл гаргах;

3.1.3.бичил уурхайгаар ашигт малтмал олборлохыг хүссэн өргөдлийн бүртгэлийн дарааллаар сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулах;

3.1.4.гэрээ байгуулсан бичил уурхай эрхлэгч этгээд нь ашигт малтмал олборлохдоо 3500 см³ хүртэлх багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий 1-ээс илүүгүй [Хавсралт 1]механизмыг ашиглах;

3.1.5.олборлосон ашигт малтмалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу борлуулах.

3.2.Бичил уурхай эрхлэгч этгээд нь дараахь үүрэгтэй байна:

3.2.1.бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, [Хавсралт 2] гишүүдийн [Хавсралт 3] бүртгэл, нөхөрлөл, хоршоо үүсгэн байгуулсан гэрээ, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ашигт малтмал олборлох талбайд байнга хадгалах;

3.2.2.нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг бичил уурхайн олборлолтын улмаас эвдэгдсэн газарт нөхөн сэргээлт хийх аргачлал, загварын дагуу батлуулж, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээнд хавсаргасан байх;

3.2.3.гэрээгээр олгосон талбайг бусдад шилжүүлэхгүй, барьцаалахгүй, худалдахгүй, түрээслэхгүй байх;

3.2.4.бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөх;

3.2.5.тухайн нутаг дэвсгэрийн Засаг даргаас тогтоож өгсөн талбайд амьдрах суурьшлын талбай, хог хаягдлын цэг байгуулах;

3.2.6.бичил уурхайн ажилтнуудыг нийгмийн даатгалд хамруулах, олгосон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос хууль тогтоомжийн дагуу хувь хүний орлогын албан татвар суутгах;

3.2.7.тэсэлгээний ажлыг тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх;

3.2.8.олборлолтын талбайд 18 нас хүрээгүй иргэнийг оруулахгүй байх;

3.2.9.үйл ажиллагаанаас олсон орлогоос хуульд заасны дагуу татвар төлөх;

3.2.10.нөхөн сэргээлтийг бичил уурхайн олборлолтын улмаас эвдэгдсэн газарт нөхөн сэргээлт хийх аргачлал, зааврын дагуу гүйцэтгэн, сум, дүүргийн Засаг даргын томилсон комисст актаар хүлээлгэн өгч, эвдрэлд орсон талбайн хэмжээ, нөхөн сэргээлтийн тайлан мэдээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлж бүртгүүлэх;

3.2.11.тухайн жилийн үйл ажиллагааны тайланг сум, дүүргийн Засаг даргад дараа оны 1 дүгээр сарын 31-ний өдөрт багтаан хүргүүлэх;

3.2.12.бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулахын өмнө Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу боловсруулсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах барьцаа хөрөнгийг тухайн сумын нөхөн сэргээлтийн дундын дансанд байршуулах;

3.2.13.ашигт малтмал олборлолт, борлуулалтын бүртгэлийг энэ журмын 7 дугаар хавсралтад заасны дагуу тогтмол хөтлөх; [Хавсралт 4]

3.2.14.бичил уурхайгаар ашигт малтмал олборлож байгаа талбайд тэсэлгээний ажил явуулахаас бусад тохиолдолд [Хавсралт 5] туслан гүйцэтгэгчээр ажил гүйцэтгүүлэхгүй байх;

3.2.15.бичил уурхай эрхлэгч этгээд нь Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлсөн байх.

3.3.Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч этгээдэд тусгай зөвшөөрлийг олгох, бүртгэх, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, хяналт, хариуцлагатай холбогдсон харилцааг “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ын дагуу Санхүүгийн зохицуулах хороо зохицуулна.

3.4.Бичил уурхай эрхлэгч этгээд нь дээрх журмын дагуу Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдэд олборлосон үнэт металл, үнэт чулуугаа борлуулна.

3.5.Бичил уурхай эрхлэгч этгээд нь Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооноос үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авна.

Дөрөв. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбай

4.1.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох нэгж талбайн хэмжээ 5 га-аас ихгүй байна.

4.2.Сум, дүүргийн нутаг дэвсгэрт бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбайн нийт хэмжээ 50 га-аас ихгүй байна.

4.3.Энэ журмын 5.1.2-т заасан шийдвэрийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга нь бичил уурхай эрхлэгч этгээдтэй энэ журмын 2 дугаар хавсралтад заасан загварын дагуу бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээг байгуулна.

4.4.Энэ журмын 4.3-т заасан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж байгаа бичил уурхай эрхлэгч этгээд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талбайгаас [Хавсралт 6] олборлосон ашигт малтмалыг борлуулахдаа ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр дээр бүртгүүлнэ.

Тав. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх, үүрэг

5.1.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь эрх, үүрэгтэй байна:

5.1.1.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн сум, дүүргийн Засаг даргын бичил уурхайн талаар авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тайланг сонсож чиглэл, зөвлөмж өгөх;

5.1.2.энэ журмын 8.1.3-т заасан дүгнэлтийг үндэслэн бичил уурхайн зориулалтаар газрыг тусгай хэрэгцээнд авах талаар гаргасан сум, дүүргийн Засаг даргын саналыг хэлэлцэн шийдвэрлэж, шийдвэрээ ажлын 10 өдөрт багтаан сум, дүүргийн Засаг даргад хүргүүлэх.

Зургаа. Сум, дүүргийн Засаг даргын эрх, үүрэг

6.1.Сум, дүүргийн Засаг дарга дараахь эрх, үүрэгтэй байна:

6.1.1.бичил уурхайгаар ашигт малтмал олборлох иргэдийг бүртгэж үнэмлэх олгох, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах;

6.1.2.бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар бичил уурхай эрхлэгч этгээдийн гаргасан өргөдлийг үндэслэн өргөдөлд заасан талбайд дүгнэлт гаргуулах саналыг аймаг, нийслэлийн Засаг даргад уламжлах;

6.1.3.энэ журмын 5.1.2-т заасан шийдвэрийг үндэслэн өргөдөл гаргасан бичил уурхай эрхлэгч этгээдтэй бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээг бичил уурхайн мэргэжлийн холбоотой хамтран байгуулах;

6.1.4.бичил уурхай эрхлэгч этгээд нь гэрээгээр тогтоосон талбайн солбицлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавих;

6.1.5.нөхөн сэргээлт хийгээгүй болон ашигт малтмал олборлох гэрээний үүргээ биелүүлээгүй бичил уурхай эрхлэгч этгээдтэй байгуулсан гэрээг цуцлах, түүнтэй дахин гэрээ байгуулахгүй байх;

6.1.6.бичил уурхайн ажилтнуудыг нийгмийн халамжийн үйлчилгээ болон нийгмийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах;

6.1.7.нөхөн сэргээлт хийлгэж, нөхөн сэргээлт хийсэн талбайг комисс томилон хүлээж авах, энэ талаарх тайланг аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх;

6.1.8.бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих;

6.1.9.химийн хорт болон аюултай бодис, хориглосон химийн бодис хэрэглэж байгаа эсэхэд хяналт тавих;

6.1.10.бичил уурхайн эрхлэгч этгээдийн үйл ажиллагааны тайланг энэ журмын 4 дүгээр хавсралтад заасан загварын дагуу гаргаж, аймаг, нийслэлийн Засаг даргад жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэх;

6.1.11.бичил уурхай эрхлэгч этгээдийн суурьшлын талбайг тогтоох;

6.1.12.бичил уурхай эрхлэгч этгээд олборлолт явуулсан талбайг нөхөн сэргээж орон нутагт хүлээлгэн өгсөн тохиолдолд нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг буцаан олгох;

6.1.13.сумын тусгай дансанд төвлөрүүлсэн бичил уурхайн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг тухайн талбайд зөвхөн зориулалтын дагуу зарцуулах;

6.1.14.нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө нь бичил уурхай эрхлэгч этгээдийн нөхөн сэргээлт хийлгүй орхисон талбайд нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгүүлэхэд хүрэлцэхгүй тохиолдолд шаардагдах хөрөнгийг бичил уурхай эрхлэгч этгээдээс албадан гаргуулах;

6.1.15.энэ журмын 3.2.10, 3.2.11-д заасан хугацаанд тайланг ирүүлээгүй бичил уурхай эрхлэгч этгээдийн бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээг цуцлах;

6.1.16.гэрээнд заасан үүргээ биелүүлж ажилласан бичил уурхай эрхлэгч этгээдтэй тухайн талбайн ашигт малтмалыг ашиглаж дуусах хүртэлх хугацаанд гэрээг жил бүр сунгах;

6.1.17.ашигт малтмалын гарал үүслийн бүртгэл, бичил уурхай эрхлэгч этгээдийг чадавхжуулах үйл ажиллагааг дэмжин, мэргэжлийн холбоотой хамтран хариуцлагатай бичил уурхайг төлөвшүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

6.1.18.газар, ус ашиглах асуудлаар гэрээнд тусгах.

6.2.Бичил уурхайд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тохиолдолд тухайн сум, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулсан комисс зохих журмын дагуу судлан бүртгэж, акт тогтоон тухайн аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт мэдэгдэнэ.

6.3.Төрийн захиргааны байгууллагаас дүгнэлт гаргаагүй талбайд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулахыг хориглоно.

6.4.Зөвхөн бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулсан этгээдэд энэ журмын 3.2.13-т заасан олборлолтын бүртгэлийг үндэслэн гарал үүслийн тодорхойлолт гаргаж өгнө.

Долоо. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн

Хурлын эрх, үүрэг

7.1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь эрх, үүрэгтэй байна:

7.1.1.аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилттой уялдуулан бичил уурхайн талаар авч хэрэгжүүлж байгаа Засаг даргын ажлын тайланг сонсож чиглэл, зөвлөмж өгөх.

Найм. Аймаг, нийслэлийн Засаг даргын эрх, үүрэг

8.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга дараахь эрх, үүрэгтэй байна:

8.1.1.бичил уурхайн үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

8.1.2.энэ журмын 6.1.2-т заасан талбайд дүгнэлт гаргуулах саналыг ажлын 10 хоногт багтаан хайгуул, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

8.1.3.энэ журмын 9.1.1-д заасан дүгнэлтийг сум, дүүргийн Засаг даргад хүргүүлэх;

8.1.4.энэ журмын 5.1.2-т заасан шийдвэр, холбогдох мэдээллийг Ашигт малтмалын тухай хуулийн 14.1-д заасны дагуу төрийн захиргааны байгууллагад хүргүүлж бүртгүүлэх;

8.1.5.бичил уурхайн зориулалтаар тусгай хэрэгцээнд авсан газрын зураг зүйн бүртгэл болон бичил уурхай эрхлэгч этгээдийн талаарх нэгдсэн судалгаа бүхий мэдээллийн сан бүрдүүлж төрийн захиргааны болон холбогдох бусад байгууллагад хүргүүлэх, цахим хуудсаар мэдээлж байх;

8.1.6.бичил уурхай эрхлэгч этгээдийн үйл ажиллагааны тайланг энэ журмын 4 дүгээр хавсралтын дагуу сум, дүүргээс авч нэгтгэн төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэх;

8.1.7.бичил уурхай эрхлэгч этгээдийн үйл ажиллагааны талаарх сум, дүүргийн Засаг даргын тайлан, мэдээллийг хэлэлцэн зөвлөмж, чиглэл өгөх;

8.1.8.бичил уурхай эрхлэгч этгээдийн үйл ажиллагааны талаар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг холбогдох мэдээллээр хангах;

8.1.9.бичил уурхайн нөхөн сэргээлтийн ажилд хяналт тавих ажлыг зохион байгуулах;

8.1.10.бичил уурхайн осол, байгалийн болон давагдашгүй хүчин зүйлс, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд авран туслах үйл ажиллагааг цаг алдалгүй үзүүлэх, нийтийн хэв журам сахиулах арга хэмжээ авах;

8.1.11.бичил уурхайн ажилтнуудыг хөнгөлөлттэй зээл, төсөл, хөтөлбөрт хамруулах, бичил уурхайгаас бусад төрлийн ажлын байр бий болгож ажлын байраар хангах ажлыг зохион байгуулах.

Ес. Төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

9.1.Хайгуул, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараахь эрх, үүрэгтэй байна:

9.1.1.энэ журмын 8.1.2-т заасан саналыг хүлээн авч Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.23-т заасан дүгнэлтийг ажлын 10 хоногт багтаан гаргаж, уг дүгнэлтэд холбогдох мэдээллийг хавсарган аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх ба шаардлагатай тохиолдолд газар дээр нь ажиллах;

9.1.2.бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрыг кадастрын зураг зүйн нэгдсэн бүртгэлд бүртгэх;

9.1.3.бичил уурхайн ажилтнуудын судалгаа гарган мэдээллийн сан бүрдүүлж, өөрчлөлт хөдөлгөөний тайланг жил бүрийн I улиралд багтаан хайгуул, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

9.1.4.бичил уурхайн ажилтнууд, нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын ажилтанд бичил уурхайтай холбогдсон хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал болон байгаль орчны нөхөн сэргээлтийн талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулах;

9.1.5.бичил уурхай эрхлэх боломжтой газрын судалгаа гаргаж, аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх;

9.1.6.энэ журмын 8.1.2-т заасан талбай нь Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.23-т заасан тодорхойлолттой нийцэж байгаа эсэхэд дүгнэлт гаргах.

Арав. Төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг

10.1.Хайгуул, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь эрх, үүрэгтэй байна:

10.1.1.Төрийн урт, дунд хугацааны бодлоготой уялдуулан бичил уурхайн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, нэгдсэн удирдлагаар хангах.

10.2.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь эрх, үүрэгтэй байна:

10.2.1.аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, бичил уурхай эрхлэгч этгээд болон бичил уурхайн мэргэжлийн холбоог бичил уурхайн байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн удирдлагаар хангах;

10.2.2.хүрээлэн буй орчны бохирдол доройтлыг бууруулах, байгалийн баялгийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;

10.2.3.бичил уурхай эрхлэгч этгээдийн нөхөн сэргээлтийн тайлан, талбайн нэгдсэн мэдээллийг санд бүртгэх.

Арван нэг. Бичил уурхайн мэргэжлийн холбооны эрх, үүрэг

11.1.Бичил уурхайн мэргэжлийн холбоо дараахь эрх, үүрэгтэй байна:

11.1.1.сум, дүүргийн Засаг даргатай хамтран энэ журмын 1.4-т заасан бичил уурхай эрхлэгч этгээдтэй гэрээ байгуулах;

11.1.2.бичил уурхайчдад бичил уурхайн эрх зүйн зохицуулалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нөхөн сэргээлтийн болон бичил уурхайгаар олборлох бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох сургалтыг зохион байгуулах;

11.1.3.бичил уурхайчдад гэрчилгээ олгох;

11.1.4.бичил уурхай эрхлэгч этгээдийн гэрээний биелэлтэд тогтмол хяналт тавьж ажиллах;

11.1.5.гэрээ байгуулсан бичил уурхай эрхлэгч этгээд, бичил уурхай эрхлэгч этгээдийн нөхөн сэргээлт, олборлолтын бүртгэлийг хөтөлж, холбогдох төрийн байгууллагуудыг мэдээллээр хангаж ажиллах;

11.1.6.ашигт малтмалын гарал үүслийн бүртгэл, хариуцлагатай бичил уурхайг төлөвшүүлэх талаар сум, дүүргийн Засаг даргатай хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэх.

Арван хоёр. Талбайг буцааж хүлээлгэн өгөх

12.1.Бичил уурхай эрхлэгч этгээд дараахь тохиолдолд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбайг буцаан хүлээлгэж өгнө:

12.1.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлөөс шалтгаалан олборлолтыг үргэлжлүүлэх боломжгүй болсон тухай эрх бүхий улсын байцаагчийн дүгнэлт гарсан;

12.1.2.талбайг цаашид ашиглах боломжгүйн улмаас хүлээлгэн өгөх хүсэлт гаргасан, гэрээг цуцалсан;

12.1.3.гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, гэрээг талууд дүгнэсэн.

12.2.Энэ журмын 12.1-д заасны дагуу талбайг буцаан хүлээлгэж өгсөн нь бичил уурхай эрхлэгч этгээдийн өөрийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт байгаль орчны нөхөн сэргээлт хийх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Арван гурав. Хяналт тавих, хариуцлага хүлээлгэх

13.1.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын хэрэгжилтэд нутгийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага, төрийн захиргааны байгууллага, бичил уурхайн мэргэжлийн холбоо хяналт тавина.

13.2.Энэ журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох
журмын 1 дүгээр хавсралт

(Энэхүү өргөдлийг гаргацтай, засваргүй бичиж бөглөнө үү)

..... аймгийн сум, дүүргийн
Засаг дарга /..... / Танаа

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох өргөдөл гаргах нь:

..... оны ... сарын ... өдөр

“ ” нөхөрлөл, хоршоог төлөөлж албан тушаалтай
(оноосон нэрийг бичих)

..... овогтой -с

..... аймаг (хот) - ийн сум (дүүрэг)-ын нутаг дэвсгэрт

байршилтай нэртэй талбайд

..... олборлох өргөдөл гаргаж байна.

(ашигт малтмалын төрөл)

Өргөдлийг хянан үзэж, бүртгэж, шийдвэрлэж өгнө үү.

Өргөдөлд дараахь бичиг баримтыг хавсаргав.
авагч бөглөнө.

Энэ зайг өргөдөл хүлээн

1. Үүсгэн байгуулсан гэрээ, дүрмийн хуулбар 1
2. Бичил уурхайчдын үнэмлэхийн хуулбар 1
3. Нөхөрлөл буюу хоршооны улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 1
4. Олборлолт явуулах талбайн байршлын зураг 1
5. Бичил уурхайчдын албан татвар төлөгчийн бүртгэлийн дэвтрийн хуулбар 1
6. Бичил уурхайчдын нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар 1
7. Тухайн талбайг сонгосон үндэслэл, тайлбар 1
8. Бичил уурхайн нөхөрлөлийн гишүүдийн “Бичил уурхайн үндсэн сургалтад хамрагдсан гэрчилгээ”

Өргөдөл гаргасан: /
/гарын үсэг/ /овог, нэр/

Өргөдлийг хүлээн авсан тухай тодорхойлолт:

Өргөдлийг 20... оны ... сарын ... өдрийн цаг минутад хүлээн авч өргөдлийн
бүртгэлийн дугаарт бүртгэв.

Өргөдлийг хүлээн авч, бүртгэсэн ажилтан /
/гарын үсэг/ /овог, нэр/

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох
журмын 2 дугаар хавсралт

БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ТУХАЙ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 2.1, 3.1.3, 6.1.3-т заасны дагуу нэг талаас

..... аймаг (хот)-ийн сум, (дүүрэг)-ын
Засаг дарга (цаашид “Засаг дарга” гэх),

нөгөө талаас “.....” нөхөрлөл, хоршоо (цаашид “Бичил уурхай эрхлэгч этгээд” гэх)-ийг төлөөлж (албан тушаал)
..., гуравдагч талаас Бичил уурхайн мэргэжлийн холбоо (цаашид “Холбоо” гэх)-ны гүйцэтгэх захирал нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараахь нөхцөлөөр харилцан тохиролцож 20.... оны дугаар сарын-ны өдөр энэхүү гэрээг (цаашид “Гэрээ” гэх) сум (дүүрэг)-анд байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Бичил уурхай эрхлэгч этгээд нь сум (дүүрэг)-ын нэртэй газарт орших гектар талбайд журмын 6.1.3-т заасны дагуу жилийн хугацаагаар (ашигт малтмалын төрөл) олборлохтой холбогдсон үйл ажиллагаа эрхэлнэ.

1.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сум (дүүрэг)-ын Засаг дарга, бичил уурхай эрхлэгч этгээдийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

Хоёр. Сум (дүүрэг)-ын Засаг даргын эрх, үүрэг

2.1. Сум (дүүрэг)-ын Засаг дарга нь “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 6 дугаар зүйлд зааснаас гадна дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. бичил уурхай эрхлэгч этгээдэд ногдох талбайн хэмжээг тогтоож, байршлын зургийг гэрээнд хавсаргах;

2.1.2. хог хаягдлын цэгийн байршлыг тогтоох;

2.1.3. бичил уурхай эрхлэгч этгээдийн олборлосон ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах талбайг тогтоох;

2.1.4. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу нөхөн сэргээлтийн зардлыг тооцож, бичил уурхай эрхлэгч этгээдтэй тохиролцсоны үндсэн дээр зохих хөрөнгийг сумын нөхөн сэргээлтийн дундын дансанд төвлөрүүлэх;

2.1.5. бичил уурхайн ажилтнуудад (цаашид “ажилтан” гэх) зориулсан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг Холбоотой хамтран зохион байгуулах;

2.1.6. энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардах;

2.1.7.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавих;

2.1.8.хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа үйл ажиллагааг зогсоох;

2.1.9.бичил уурхай эрхлэгч этгээд олборлолт явуулсан талбайг нөхөн сэргээж орон нутагт хүлээлгэн өгсөн тохиолдолд нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг буцаан олгох;

2.1.10.бичил уурхай эрхлэгч этгээдийн бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу хийж, сум, дүүргийн Засаг даргын томилсон комисст актаар хүлээлгэн өгсөн талбайн мэдээлэл, нөхөн сэргээлтийн тайлан мэдээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагад хүргүүлж бүртгүүлэх.

Гурав. Бичил уурхай эрхлэгч этгээдийн эрх, үүрэг

3.1.Бичил уурхай эрхлэгч этгээд дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1.бичил уурхай эрхлэгч этгээдэд олгосон талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаагаа явуулах;

3.1.2.ажилтнуудыг тогтоосон талбайд суурьшуулах;

3.1.3.суурьшлын талбайг тохижуулж, ахуйн болон үйлдвэрийн хог, хаягдлын цэгийг байгуулах;

3.1.4.гэрээгээр олгосон талбайд нөхөрлөл, хоршоо бус этгээдийг ажиллуулахгүй байх;

3.1.5.байгаль орчныг хамгаалж, гол, горхи, булаг шанд, уст цэгийг бохирдуулахгүй байх;

3.1.6.бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөх, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

3.1.7.хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон нөхөн сэргээлтийн чиглэлээр ажилтнуудад сургалт, сурталчилгаанд бичил уурхайчдыг идэвхтэй оролцуулах;

3.1.8.ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах үйл ажиллагааг тогтоосон талбайд гүйцэтгэх;

3.1.9.үйл ажиллагаандаа химийн хорт болон аюултай бодис хэрэглэхгүй байх, тусгай зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглахгүй байх;

3.1.10. Иргэний хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасан нөхөрлөл, мөн хуулийн 36.4-т заасан хоршооны зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгч этгээд нь ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд 3500 см3 хүртэлх багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий 2-оос илүүгүй механизмыг ашиглах;

3.1.11.бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу эрх бүхий этгээдийн тогтоосон байгаль орчны нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах / / төгрөгийг нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлэх;

3.1.12.нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн хөрөнгийг олборлолт явуулсан талбайн нөхөн сэргээлтэд зарцуулах;

3.1.13.бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу олборлолт явуулсан талбайдаа нөхөн сэргээлт хийж сум, дүүргийн Засаг даргын томилсон комисст хүлээлгэж өгөх, актаар хүлээлгэн өгсөн талбайн мэдээлэл, нөхөн сэргээлтийн тайлан мэдээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагад хүргүүлж бүртгүүлэх;

3.1.14.олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдан авах эрх бүхий хуулийн этгээд, Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдэд олборлосон үнэт металл, үнэт чулууг худалдах;

3.1.15.ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу орлогын албан татвар төлөх.

3.2.Бичил уурхай эрхлэгч этгээд нөхөн сэргээлт хийж, талбайг хүлээлгэн өгсний дараа ашигт малтмал олборлох өргөдөл дахин гаргах.

Дөрөв. Мэргэжлийн холбооны үүрэг

4.1.Төрийн захиргааны байгууллага, сум, дүүрэгтэй хамтран баталсан хөтөлбөрийн дагуу Бичил уурхайн үндсэн сургалтын хөтөлбөрийн дагуу бичил уурхайн эрх зүйн зохицуулалт, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, ашигт малтмалын гарал үүсэл, магадлан шинжилгээ, нөхөн сэргээлтийн сургалтыг нөхөрлөлийн гишүүдэд зохих журмын дагуу зохион байгуулах, гэрчилгээ олгох.

4.2.Бичил уурхайчдад гэрчилгээ олгох.

4.3.Энэхүү гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж гэрээний хэрэгжилтийн үнэлгээг жил бүр хийх, хэрэгжилтийн үнэлгээний мэдээллийг Ашигт малтмал газрын тосны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлэх.

Тав. Маргаан шийдвэрлэх

5.1.Талууд гэрээтэй холбоотой үүссэн аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ.

5.2.Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шийдвэрлэнэ.

Зургаа. Гэрээний хүчин төгөлдөр болох

6.1.Энэхүү гэрээ нь 20.... оны сарын өдрөөс 20 оны сарын өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

6.2.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон талбайд нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэж өгснөөр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно.

6.3.Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

Долоо. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

7.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

7.2. Энэхүү гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь түүний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

Гэрээ байгуулсан:

..... аймаг (хот)-ийн сум (дүүрэг)-ын Засаг дарга

/...../

/...../

/эцэг/эх/-ийн нэр, нэр

гарын үсэг,

/тамга, тэмдэг/

“.....” (нөхөрлөл, хоршоо) төлөөлж

/...../

/...../

/эцэг/эх/-ийн нэр, нэр

гарын үсэг,

/тамга, тэмдэг/

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох
журмын 3 дугаар хавсралт

АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙГААС БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ГУРВАЛСАН ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 4.3 дахь заалтын дагуу нэг талаас..... аймаг (хот)-ийн сум (дүүрэг)-ын Засаг дарга (цаашид “Засаг дарга” гэх), нөгөө талаас тус сум (дүүрэг)-ын нэртэй газарт ашигт малтмал ашиглах дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх) “.....” компанийн захирал, гуравдагч талаас “.....” нөхөрлөл, хоршоо (цаашид “Бичил уурхай эрхлэгч этгээд” гэх)-ийг төлөөлж (албан тушаал) нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) харилцан тохиролцож 20.... оны дугаар сарын -ны өдөр энэхүү гурвалсан гэрээ (“Гэрээ” гэх)-г аймаг (хот)-т байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн талбайгаас бичил уурхай эрхлэгч этгээдэд (ашигт малтмалын төрөл) олборлох зориулалтаар талбай ашиглуулахтай холбогдон Засаг дарга, тусгай зөвшөөрөл эзэмшигч, бичил уурхай эрхлэгч этгээдийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

1.2.Энэхүү гэрээг 20.... оны сарын өдрөөс эхлэн жилийн хугацаагаар байгуулав.

Хоёр. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх эрх, үүрэг

2.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1.тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн дор дурдсан солбицол бүхий цэгүүдийг холбосон шугамаар хүрээлэгдсэн гектар талбайг бичил уурхай эрхлэгч этгээдэд ашиглуулах;

Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг
1		
2		
3		
4		
5		

2.1.2.бичил уурхай эрхлэгч этгээдийн олборлосон ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах талбайн байршлыг тогтоох;

2.1.3.бичил уурхай эрхлэгч этгээдийн гэрээнд заасан солбицлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавих;

2.1.4.бичил уурхай эрхлэгч этгээдийн аюулгүй байдлын дүрмийн мөрдөлтөд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг авах;

2.1.5.бичил уурхай эрхлэгч этгээдэд нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэхэд нь мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

2.1.6.бичил уурхай эрхлэгч этгээд болон Засаг даргаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

2.1.7.бичил уурхай эрхлэгч этгээдээс тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхайн хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байхыг шаардах;

2.1.8.бичил уурхай эрхлэгч этгээд нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, уурхайн хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тухай саналыг талуудад гаргах;

2.1.9.бичил уурхай эрхлэгчдийн татвар, даатгалтай холбоотой асуудлыг хариуцахгүй байх;

2.1.10.гэрээт талбайгаас олборлосон ашигт малтмалыг худалдахдаа тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр дээр бүртгүүлэхийг бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардах;

2.1.11.бичил уурхай эрхлэгч этгээдийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг гэрээ байгуулсан өдрөөс хойш 1 сарын дотор геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх.

Гурав. Сум (дүүрэг)-ын Засаг даргын хүлээх эрх, үүрэг

3.1.Сум (дүүрэг)-ын Засаг дарга нь Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 6 дугаар зүйлд зааснаас гадна дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1.бичил уурхайн ажилтнуудад (цаашид “ажилтан” гэх) “Бичил уурхайн аюулгүй байдлын дүрэм”-ийг таниулах, ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд анхан шатны тусламж үзүүлэх, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар мэргэжлийн байгууллагаар сургалт хийлгэх ажлыг зохион байгуулах;

3.1.2.хог хаягдлын цэгийн байршлыг тогтоох;

3.1.3.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавих;

3.1.4.тусгай зөвшөөрөл эзэмшигч болон бичил уурхай эрхлэгч этгээдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

3.1.5.бичил уурхай эрхлэгч этгээдийн олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу эрх бүхий хуулийн этгээдэд борлуулж байгаа эсэхэд хяналт тавих;

3.1.6.бичил уурхай эрхлэгч этгээд болон тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

3.1.7.талууд гэрээний үүргээ биелүүлээгүй, бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөөгүй тохиолдолд бичил уурхай эрхлэгч этгээдийн ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зогсоож, талуудад гэрээг цуцлах тухай санал гаргах;

3.1.8.хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүргээ хэрэгжүүлэх.

Дөрөв. Бичил уурхай эрхлэгч этгээдийн эрх, үүрэг

4.1.Бичил уурхай эрхлэгч этгээд нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1.гэрээт талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулах;

4.1.2.гэрээгээр олгосон талбайд зөвхөн бүртгэлтэй гишүүнийг ажиллуулах;

4.1.3.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх;

4.1.4.сум (дүүрэг)-ын Засаг даргаас тогтоосон суурьшлын талбайд амьдрах, тогтоосон газарт хог, хаягдлын цэг байгуулах;

4.1.5.олборлосон ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах ажлыг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тогтоосон талбайд болон төвлөрсөн баяжуулах цехэд гүйцэтгэх;

4.1.6.гэрээт талбайн ашигт малтмалын нөөцийг бүрэн гүйцэд ашиглах;

4.1.7.бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөх, ослоос урьдчилан сэргийлэх;

4.1.8.ашигт малтмалын олборлох үйл ажиллагаанд химийн хорт болон аюултай бодис хэрэглэхгүй байх, тусгай зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг ашиглахгүй байх;

4.1.9.байгаль орчныг хамгаалж, голын горхи, булаг шанд, уст цэгийг бохирдуулахгүй байх, нөхөн сэргээлт хийх;

4.1.10.ажилтнуудын дунд холбогдох хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон нөхөн сэргээлтийн чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

4.1.11.олборлосон ашигт малтмалыг эрх бүхий этгээдэд борлуулахдаа тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр дээр бүртгүүлэх;

4.1.12.холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар төлөх, бичил уурхайчдыг нийгмийн даатгалд хамруулах;

4.1.13.гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг тусгай зөвшөөрөл эзэмшигч болон Засаг даргаас шаардах;

4.1.14.хууль тогтоомжийг мөрдөх, нийгмийн хэв журмыг сахин биелүүлэх.

Тав. Харилцан хүлээх үүрэг

5.1.Гэрээг цуцлах үндэслэл бий болсон тохиолдолд талуудад гэрээг цуцлах тухай саналаа бичгээр хүргүүлнэ.

5.2.Гэрээнд талууд харилцан хүндэтгэх зарчим дээр тулгуурлан хамтарч ажиллана.

5.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч, эсхүл бичил уурхай эрхлэгч этгээдийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан байгаль орчин, бусад этгээдэд хохирол учирвал уг хохирлыг буруутай тал барагдуулна.

Зургаа. Маргаан шийдвэрлэх

6.1.Талууд гэрээтэй холбоотой үүссэн аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ.

6.2.Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд үүссэн маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Долоо. Гэрээний хүчин төгөлдөр болох

7.1.Энэхүү гэрээ нь 20.... оны сарын өдрөөс 20.... оны сарын өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

7.2.Гэрээний хүчинтэй хугацаанд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүчингүй болсон тохиолдолд гэрээ хүчингүй болно.

7.3.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон талбайд нөхөн сэргээлт хийж, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 3.2.10-т заасны дагуу орон нутагт хүлээлгэж өгснөөр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно.

7.4.Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах талаарх саналаа аль нэг тал нөгөө талууддаа бичгээр мэдэгдсэн боловч нөгөө талууд нь ажлын 20 хоногт багтаан асуудлыг шийдвэрлээгүй, эсхүл хариу өгөөгүй тохиолдолд гэрээ хүчингүй болно.

7.5.Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

Найм. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

8.1.Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

8.2.Энэхүү гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь түүний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

Гэрээ байгуулсан:

..... аймаг (хот)-ийн сум (дүүрэг)-ын Засаг дарга

/...../ /...../

/эцэг/эх/-ийн нэр, нэр, гарын үсэг, тамга, тэмдэг/

“.....” компанийг төлөөлж

/...../ /...../

/эцэг/эх/-ийн нэр, нэр, гарын үсэг, тамга, тэмдэг/

“.....” нөхөрлөл, хоршоог төлөөлж

/...../ /...../

/эцэг/эх/-ийн нэр, нэр, гарын үсэг, тамга, тэмдэг/

“.....” Бичил уурхайн мэргэжлийн холбоог төлөөлж

/...../ /...../

/эцэг/эх/-ийн нэр, нэр,

/гарын үсэг, тамга, тэмдэг/

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын
4 дүгээр хавсралт

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧ ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН ГАРГАХ ЗАГВАР

Аймаг	Сум	Талбайн нэр/ тусгай зөвшөөрлийн дугаар	Солбицол	Олборлолт явуулж байгаа талбайн хэмжээ (га)	Ашигт малтмалын төрөл	Ашиглалт		Нөхөрлөл, хоршоо,				Үүнээс		Үүнээс			Үүнээс			Олборлолт явуулж эхэлснээс хойш эвдрэлд орсон талбай (га)	Нөхөн сэргээлт хийсэн талбай (га)	Бичил уурхайчдын ослын мэдээ
						Ил	Далд	Бичил уурхай эрхлэгч этгээдийн нэр	Гэрээ байгуулж, олборлолт эхэлсэн огноо	Гишүүдийн тоо	эр	эм	байнга	улсрын чанартай	орон нутгийн иргэд	Бичил уурхайчдын овог нэр, регистрийн дугаар	Насанд хүрсэн хүмүүс	Журам зөрчил 18 хүртэлх насны хүүхэд ажиллуулсан эсэх				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	

Тайлан гаргасан: Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын
..... /албан тушаал/..... /овог, нэр, гарын үсэг, тамга, тэмдэг

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох
журмын 5 дугаар хавсралт

БИЧИЛ УУРХАЙН ХҮДЭР ОЛБОРЛОЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

Бичил уурхайн нөхөрлөл/хоршооны нэр:

Аймаг/сум:

№	Хүдэр олборлосон огноо	Хүдэртэй, Шуудайны тоо	Нийт жин (кг)	Ажилласан хугацаа (цаг)	Ажилласан хүний тоо	Тэмдэглэл хөтөлсөн хүний овог, нэр	Гарын үсэг
1							
2							

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох
журмын 6 дугаар хавсралт

20.... оны сарын-ны өдөр

№ аймаг
..... сум

БИЧИЛ УУРХАЙН ХҮДРИЙН ГАРАЛ ҮҮСЛИЙН БАТАЛГААЖИЛТЫН ХУУДАС

..... бичил уурхайн нөхөрлөл/хоршооны олборлосон
..... ширхэг шуудай, тонн машины дугаартай
марктай хүдрийн гарал үүслийг баталгаажуулан, нэртэй хүдэр
боловсруулах үйлдвэрээр хүдэр баяжуулахыг зөвшөөрөв.

Хүчинтэй хугацаа: 20 оны сарын өдөр хүртэл

..... бичил уурхайн нөхөрлөл/ хоршооны ахлагч

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох
журмын 7 дугаар хавсралт

20 оны сарын өдөр	 аймаг.....сум	20 оны сарын өдөр	 аймаг.....сум
Бичил уурхайгаар олборлосон алтны баталгаажилтын хуудас		Бичил уурхайгаар олборлосон алтны баталгаажилтын хуудас	
Бичил уурхайн хүдрийн гарал үүслийн баталгааны хуудасны дугаар		Бичил уурхайн хүдрийн гарал үүслийн баталгааны хуудасны дугаар	
Хүдрийн хэмжээ		Хүдрийн хэмжээ	
Бүртгэсэн: Цехийн төлөөлөгч, (Нэр, гарын үсэг, тамга)		Бүртгэсэн: Цехийн төлөөлөгч, (Нэр, гарын үсэг, тамга)	
Баяжуулсан алтны хэмжээ		Баяжуулсан алтны хэмжээ	
Хүлээлгэн өгсөн: Баяжуулах цехийн лабораторийн ажилтан (нэр, гарын үсэг)		Хүлээлгэн өгсөн: Баяжуулах цехийн лабораторийн ажилтан (нэр, гарын үсэг)	
Хүлээн авсан: Бичил уурхайн нөхөрлөл/хоршооны ахлах (нэр, гарын үсэг)		Хүлээн авсан: Бичил уурхайн нөхөрлөл/хоршооны ахлах (нэр, гарын үсэг)	
Худалдан борлуулсан: Үнэт металл, үнэт чулууны худалдаа эрхлэгч (нэр, байгууллага, гарын үсэг, тамга)		Худалдан борлуулсан: Үнэт металл, үнэт чулууны худалдаа эрхлэгч (нэр, байгууллага, гарын үсэг, тамга)	

— МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ —

2010 оны 11 дүгээр
сарын 3-ны өдөр

Дугаар 281

Улаанбаатар хот

ДҮРЭМ, ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ (СОРЬЦЫН ХЯНАЛТ, БҮРТГЭЛ)

Захиргааны хариуцлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 46.1, 46.2, Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. “Монгол Улсын сорьцын хяналтын дүрэм”-ийг 1 дүгээр, “Үнэт металлын сорьц тогтоох, баталгаажуулах, эрдэнийн чулуу тодорхойлох, тэдгээрийг бүртгэх журам”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.
2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам, жагсаалт батлах тухай” Засгийн газрын 1997 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 245 дугаар тогтоол, “Дүрэм шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 1998 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 33 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД Н.АЛТАНХУЯГ

Монгол Улсын Засгийн газрын
2010 оны 281 дүгээр тогтоолын
2 дугаар хавсралт

ҮНЭТ МЕТАЛЛЫН СОРЬЦ ТОГТООХ, БАТАЛГААЖУУЛАХ, ЭРДЭНИЙН ЧУЛУУ ТОДОРХОЙЛОХ, ТЭДГЭЭРИЙГ БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үнэт металл, тэдгээрээр хийсэн эдлэлийн сорьц тогтоох шинжилгээ хийх, баталгаажуулах, эрдэнийн чулуу тодорхойлж гэрчилгээ олгох, үнэт металл хайлж гулдмайлах, эдгээр үйл ажиллагааны бүртгэлийг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Үнэт металл, тэдгээрээр хийсэн эдлэлийн сорьц тогтоох шинжилгээ хийх, баталгаажуулах, эрдэнийн чулуу тодорхойлж гэрчилгээ олгох, үнэт металлыг хайлж гулдмайлах ажлыг сорьцын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /цаашид “сорьцын хяналтын асуудал хариуцсан байгууллага” гэх/ хийнэ.

1.3. Үнэт металл, эрдэнийн чулуу (цаашид “эрдэнэс” гэх) олборлогч, үйлдвэрлэгч, арилжаалагч байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь Ашигт малтмалын тухай хуулийн 46.1, Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 15.1 дэх хэсгийг баримтлан сорьцын хяналтын асуудал хариуцсан байгууллагаар үнэт металлын сорьц тогтоолгож, эрдэнийн чулууг тодорхойлуулан баталгаажуулна.

1.4 Монгол Улсын олон улсын гэрээгээр зохицуулагдаж байгаа сорьцын баталгааны тэмдэг бүхий, үйлдвэрлэгчийн барааны болон тухайн улсын сорьцын баталгааны тэмдэгтэйгээс бусад үнэт эдлэлийг сорьцын баталгаагүй гэж үзнэ. Сорьцын баталгаагүй эдлэлийг сорьц тогтоох шинжилгээнд хамруулж баталгаажуулна.

Хоёр. Үнэт металл, тэдгээрээр хийсэн эдлэлээс дээж авах, сорьц тогтоох шинжилгээ хийх, эрдэнэсийг баталгаажуулах

2.1. Үнэт металл, тэдгээрээр хийсэн эдлэлээс дээж авах, сорьц тогтоох шинжилгээ хийх, эрдэнэсийг баталгаажуулах үйл ажиллагааг үнэт металлын сорьц тогтоох лаборатори хийж гүйцэтгэнэ. Лаборатори нь сорьц тогтоох шинжилгээний дүнг актаар баталгаажуулна.

2.2. Сорьц тогтоох шинжилгээний дээжийг гулдмай, эдлэлийн үндсэн хайлшийг төлөөлж чадах хэсгээс дараахь байдлаар авна:

2.2.1. үнэт металл гулдмай болон томоохон цул эдлэлээс өрөмдөж, хөндий болон нарийн хийцтэй эдлэлийн бүрдэл болох жижиг хэсгээс тасалж, задгай утасны хоёр үзүүрээс тасалж, ороолттой утасны задгай талын үзүүрээс хоорондоо 1 метр зайтай хэсгээс тасалж, дэвтэрлэсэн хуудас үнэт металлын аль нэг хуудаснаас тасалж, хэт жижиг бутархай хэсгүүдийг нэгтгэн хайлуулсны дараа тасалж, нунтаг тоосонцор байдалтай бол хольж хутган ижил хэсгүүдэд хувааж түүний аль нэг хэсгээс таслах байдлаар дээж авна;

2.2.2. томоохон цул эдлэл, гулдмайнаас дээж авах цэгийг дараахь байдлаар тодорхойлж өрөмдөж авна:

2.2.2.1. 6000 граммаас дээш жинтэй гулдмайн дээд болон доод талын хоёр өнцгийн диагоналийн уртын дөрөвний нэгтэй тэнцэх хэсгээс цутгамлын зузааны хоёрны нэг хүртэл гүн өрөмдөж, цутгамлын дээд болон доод талаас солбиж тус бүр хоёр дээж;

2.2.2.2. 100-6000 грамм хүртэл жинтэй гулдмайн дээд доод талын хоёр булангийн диагоналийн уртын дөрөвний нэгтэй тэнцэх хэсгээс гулдмайн зузааны хоёрны нэг хүртэл гүн өрөмдөж цутгамлын дээд, доод талаас солбиж тус бүр нэг дээж;

2.2.2.3. 100 грамм хүртэл жинтэй гулдмай, цутгамал буюу бүхэл хэсгийн голыг нэвт өрөмдөж.

2.3. Сорьц тогтоох химийн шинжилгээг олон улсын стандарт /ISO 1725/-ын шаардлагад нийцүүлэн баталсан аргачлалаар, улсын болон байгууллагын стандартын дагуу хийнэ.

2.4. Аж ахуйн нэгж, иргэдээс сорьц тогтоолгохоор нэг удаа ирүүлсэн гулдмай бүрт, үнэт эдлэлийн нэг төрлийн 100 ширхэг тутмаас нэг ширхэг эдлэлд, нэг төрлийн эдлэл нь 100 ширхэгт хүрэхгүй байвал ирүүлсэн тооны эдлэл тутмаас нэг ширхэг эдлэлд химийн шинжилгээ хийнэ.

2.5. Сорьц тогтоох химийн шинжилгээний үр дүнг үндэслэн стандартын сорьцод тохирсон үнэт эдлэлийг рентгенофлюоресценцийн аппаратаар нэг бүрчлэн шалгасны дараа сорьцын баталгааны тохирох тэмдгийг дарж баталгаажуулна.

Дөрөв. Үнэт металлыг хайлж гулдмайлах

4.1. Үнэт металлыг сорьцын хяналтын асуудал хариуцсан байгууллагад хайлж гулдмайлна. Гулдмайн хэмжээ 12.5 кг-аас илүүгүй байна. Нөөц ихтэй томоохон ордыг ашиглаж байгаа уурхайн үйлдвэрлэлийн дамжлагад цэвэршүүлэх цех ажиллаж байгаа тохиолдолд уг аж ахуйн нэгж нь үнэт металл хайлуулах зуух ажиллуулж болно.

4.2. Үнэт металлыг хайлсан цех энэхүү журмын 2 дугаар хавсралтаар баталсан “Үнэт металл хайлсан тухай акт” бичиж, тухайн аж ахуйн нэгжийн гулдмайн дугаарыг гулдмай тус бүрт тавина.

Тав. Үнэт металл, эрдэнийн чулууны бүртгэл тооцоо

5.1. Үнэт металл олборлогч аж ахуйн нэгж нь олборлосон үнэт металлын мэдээг энэхүү журмын 3 дугаар хавсралтаар баталсан “Үнэт металл олборлолтын журнал”-д бүртгэнэ. Журналыг тухайн уурхайн үнэт металл хүлээн авах комисс хөтөлж, хадгална.

5.2. Аж ахуйн нэгж нь үнэт металл олборлолтын жилийн тайланг энэхүү журмын 4 дүгээр хавсралтаар баталсан маягтын дагуу гаргаж, Үнэт металл олборлолтын журналын хамт дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор сорьцын хяналтын асуудал хариуцсан байгууллагад хүргүүлж хянуулна.

Долоо. Бусад зүйл

7.2. Энэхүү журмыг зөрчсөн байгууллага, албан тушаалтан, иргэдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сорьцын хяналтын улсын байцаагч хариуцлага хүлээлгэнэ.

— САЙДЫН ТУШААЛ —

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

2017 оны 06 сарын
23-ны өдөр

Дугаар А/115, А/123

Улаанбаатар хот

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 22.1.3-т заасныг тус тус үндэслэн Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Дүрмийг мөрдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Даваадорж нарт даалгасугай.

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД
Н.НОМТОЙБАЯР**

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД
Ц.ДАШДОРЖ**

БИЧИЛ УУРХАЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү дүрмийг бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж буй бичил уурхай эрхлэгч этгээд болон ажилтнууд дагаж мөрдөнө.

1.2. Энэхүү дүрмээр зохицуулаагүй бичил уурхайн аюулгүй байдлын шаардлагыг “Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм”, “Далд уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм”, “Нүүрсний далд уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм”-ээр зохицуулна.

1.3. Бичил уурхайгаар олборлосон хүдрийг баяжуулахад баяжуулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг мөрдөж ажиллана.

1.4. Тэсэлгээний ажлыг тэсэлгээний ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх ба гүйцэтгэгч нь “Тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг мөрдөж ажиллах бөгөөд бичил уурхай эрхлэгч этгээд нь бие даан тэсэлгээний ажил явуулахыг хориглоно.

1.5. Бичил уурхайн ажилтан нь “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 6.1.1-д заасан үнэмлэхийг энэхүү дүрмийн хавсралтаар баталсан журмын дагуу авсан байна.

Хоёр. Нийтлэг шаардлага

2.1. Бичил уурхай эрхлэгч этгээд нь ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг дараах байдлаар хариуцан ажиллана:

2.1.1. шинэ ажилтнуудад бичил уурхайн аюулгүй байдлын дүрэм, зааврыг танилцуулж, аюулгүй ажиллагааны шаардлага, үүрэг, хариуцлагыг тайлбарлан таниулж, ажлын байрны урьдчилсан, анхан шатны болон давтан зааварчилгаа өгөх;

2.1.2. бичил уурхайн ажилтанд ажлын байрны урьдчилсан, анхан шатны зааварчилгаа өгсний дараа ажлыг эхлүүлэх;

2.1.3. улиралд нэгээс доошгүй удаа ажлын байрны давтан зааварчилгаа өгөх;

2.1.4. ажлын байрны урьдчилсан, анхан шатны болон давтан зааварчилгаа авсан ажилтнуудыг журналд бүртгэж, гарын үсэг зуруулах;

2.1.5. ажил эхлэхийн өмнө ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй ажиллахад шаардлагатай ажлын тусгай хувцас (малгай, бээлий гэх мэт), нэг бүрийн хамгаалах хэрэгслийг зөв өмссөн эсэх, ажил гүйцэтгэхэд шаардагдах багаж хэрэгсэл аюулгүй ажиллагааны шаардлага хангасан эсэхийг шалгах;

2.1.6. ажил эхлэхийн өмнө ажлын байр, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг шалгаж, ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зөрчил илэрсэн тохиолдолд түүнийг арилгасны дараа ажлыг үргэлжлүүлэх;

2.1.7. өвчтэй буюу эрүүл мэндийн байдлаар ажиллах чадваргүй байгаа бичил уурхайн ажилтныг тухайн өдөр ажилд гаргахыг хориглох;

2.1.8. ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд нэгээс доошгүй удаа хамруулах;

2.1.9. ослын үед анхан шатны тусламж үзүүлэхэд шаардлагатай эм, хэрэгслийг бэлэн байлгах;

2.1.10. ажилтнуудыг тоног төхөөрөмжийн ажлын бүс, догол, мөрөгцгийн доор, тээврийн хэрэгслийн зам дээр амарч, унтахыг хориглох;

2.1.11. осол гарах, амь нас, эрүүл мэндэд сөрөг, аюултай байдал бий болсон тохиолдолд ажлаа зогсоож, ажилтнуудад яаралтай мэдэгдэж, аюулын бүсийг орхих.

2.2. Бичил уурхайд осол гарсан тохиолдолд “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн дагуу ослыг судлан бүртгэж, сум, дүүргийн Засаг дарга болон холбогдох байгууллагад тухай бүр мэдэгдэнэ.

2.3. Тухайн жилд гарсан ослын мэдээллийг дараа жилийн нэгдүгээр сард багтаан сум, дүүргийн Засаг дарга болон холбогдох байгууллагад хүргүүлнэ.

2.4. Бичил уурхайд гарсан ослын шалтгааныг судалж цаашид ийм төрлийн осол гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.5. Олборлолт явуулсан талбайд хүн, мал унаж гэмтэхээс хамгаалсан хаалт тавьж, тэмдэг тэмдэглэгээ байршуулна.

2.6. Бичил уурхайн талбайд үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх ус зайлуулах суваг, шуудуу гаргана.

2.7. Бичил уурхайн талбайд аюулгүй ажиллагааны анхааруулах самбар, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулна.

Гурав. Бичил ил уурхай

3.1. Мөрөгцгийн өндрийг хөрс, чулуулгийн тогтоц, шинж чанараас хамааран хэт өндөр, огцом босоо мөрөгцөг (хажуу хана) гаргахыг хориглох бөгөөд ашиглалтын нөхцөл, аюулгүй байдлыг хангах зорилгоор зөвшөөрөгдсөн өндөртэй ажлын доголдууд гаргаж ашиглалт явуулна.

3.2. Ажлын мөргөцгийн налуугийн өнцөг сул хөрс, чулуулагт 500-аас ихгүй, хадархаг чулуулагт 800-аас ихгүй байна.

3.3. Олборлолтын талбайн өргөн нь хүн, техник ажиллахад чөлөөтэй, тэдгээрийн аюулгүй байдлыг хангасан байна.

3.4. Ажлын мөргөцөгт саравч гаргаж ухахыг хориглоно.

3.5. Дээд, доод доголдууд дахь ажлын мөргөцгүүд нэг босоо шугам дээр давхцаж болохгүй бөгөөд нэг доголоос нөгөөд шилжихэд 0.8 м-ээс багагүй өргөнтэй бат бөх шат ашиглах эсхүл 450-аас ихгүй налуутай гарц гаргасан байна.

3.6. Ашиглагдсан хоосон орон зайг буцааж дүүргэх, хаалт, хашаа босгох, анхааруулах тэмдэг тавих замаар аюулгүй болгоно.

Дөрөв. Бичил далд уурхай

- 4.1. Ордын тогтоц, чулуулгийн шинж чанар, уул техникийн нөхцөлөөс хамааран далд уурхайд босоо, налуу, хэвтээ ам гаргана. Уурхайн амыг гаргахдаа бат бөх, ан цавгүй, хатуу чулуулагтай, нуралт, гулсалт үүсэхээргүй, хөрсний болон үерийн ус орохооргүй газрыг сонгоно.
- 4.2. Бичил уурхайн ажилтнууд, олборлосон ашигт малтмалыг уурхайгаас гаргахад зориулсан, хоорондоо холбогдсон хоёроос доошгүй гарц гаргасны дараа олборлолт явуулна. Уурхайгаас газрын гадаргууд гарах нэг амаар олборлолт явуулахыг хориглоно.
- 4.3. Уурхайн аманд нуралт, гулсалтаас хамгаалсан бэхэлгээ хийнэ. Бэхэлгээг шуудайлж савласан элс, шороо, чулуу, мод, бетоноор хийнэ.
- 4.4. Уурхайн налуу амны налуугийн өнцөг нь тогтвортой, хатуу чулуулагтай газарт 450-аас, хатуулаг багатай буюу тогтворгүй чулуулагтай газарт бол 100-аас илүүгүй байна.
- 4.5. Уурхайн босоо 2 амны хоорондын зай 10 м-ээс багагүй байна.
- 4.6. Уурхайн босоо, налуу амны амсрыг зориулалтын материалаар хашиж бэхлэх, хамгаалалт хүрээ хийж “Аюултай” гэсэн анхааруулах тэмдэг тавина.
- 4.7. Уурхайн малталтын өндөр нь 1.5 м, өргөн нь 1.2 м-ээс багагүй байна.
- 4.8. Ажилтнууд малталтаар явахад зориулсан хэсгийн налуу нь 150-аас ихгүй байх ба үүнээс их бол бэхлэгээнд бариул, гишгүүр, шат зэргийг хөдөлгөөнгүй бэхлэн тоноглоно.
- 4.9. Босоо аманд өргүүр ашиглана. Газар доор хүн ажиллаж байгаа үед өргүүрийг ажиллуулах хүнгүй орхих, түгжээгүй өргүүр ашиглахыг хориглоно.
- 4.10. Тогтвортой хатуу чулуулаг дундуур нэвтэрсэн хэвтээ, налуу малталтыг бэхлэхгүй байж болох бөгөөд нурал үүсэхүйц хэт их орон зай гаргаж малтахыг хориглоно.
- 4.11. Хатуулаг багатай, тогтворгүй чулуулаг дундуур нэвтэрсэн хэвтээ ба налуу малталтыг дараах байдлаар бэхэлнэ:
- 4.11.1. хүдрийн биет, хоосон чулуулгаар багана үүсгэж үлдээх;
- 4.11.2. мод, төмрөөр тулгуур, багана босгох;
- 4.11.3. элс, шороог шуудайд савлаж багана өрж босгох;
- 4.11.4. мод, төмрөөр хүрээ зангидаж чулуугаар дүүргэсэн багана босгох;
- 4.11.5. мод, төмрөөр бэхэлгээ хийх.
- 4.12. Уурхайн малталтын явц, тэсэлгээний ажлын дараа аюултай байдал илэрвэл ахлагчид яаралтай мэдэгдэж уг аюулыг яаралтай арилгах арга хэмжээ авна.
- 4.13. Ашиглахгүй болсон, цаашид хүндрэл бэрхшээл учруулж болзошгүй далд малталтыг хааж, аюулгүй болгох арга хэмжээ авна.
- 4.14. Уурхайн гүний малталт 10 м-ээс урт байвал байгалийн болон зохиомол агааржуулалтын систем ашиглана.

4.15. Байгалийн агааржуулалтыг зөв хийхийн тулд уурхайн амнууд газрын гадаргуу дээр 2 өөр түвшинд байх шаардлагатай. Энэ шаардлагыг хангах боломжгүй бол энгийн хоолой (яндан) гаргаж агааржуулна.

4.16. Уурхайн малталт 20 м-ээс урт байвал зохиомол агааржуулалт хийнэ. Зохиомол агааржуулалтад сэнс ашиглана. Агаар дамжуулахад агаар нэвтрүүлдэггүй материалаар хийсэн хоолой ашиглана.

Тав. Овоолгын ажил ба усан сан

5.1. Уурхайн ам руу шороо нурж орохооргүй зайд овоолго байгуулна.

5.2. Ашигт малтмалын нөөц бүхий газарт овоолго байгуулахыг хориглоно.

5.3. Усан сан, ус хураагуурууд болон суваг шуудуу нь хүн, мал унаж, живж осолдохоос сэргийлсэн хаалт, хашлагатай байх бөгөөд эргэн тойронд нь анхааруулах, хориглох тэмдэг тавьсан байна.

Зургаа. Бичил уурхайн тоног төхөөрөмж

6.1. Бичил уурхайн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж нь уурхайд ашиглах зориулалттай түгжээ, хаалт хамгаалалттай байна.

6.2. Хийн алх, өрмийг өөр газар шилжүүлэн ажиллуулахын өмнө төхөөрөмжийг унтрааж хоолойноос хийг гаргасан байна.

6.3. Гараар барьж ажиллуулдаг цахилгаан багаж хэрэгсэл нь цахилгаан гүйдлийн аюулаас хамгаалах давхар тусгаарлагчтай байна.

6.4. Хий тоосны тэсрэх аюултай (нүүрсний) уурхайд очны аюулгүй байдлыг хангасан цахилгаан багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглана.

6.5. Уурхайн гүнд дотоод шаталт хөдөлгүүр бүхий техник, тоног төхөөрөмж ашиглахыг хориглоно.

6.6. Уурхайд ашиглаж байгаа өргүүрийн олс, ган таталтыг тогтмол шалгаж, ямар нэг зөрчил илэрсэн тохиолдолд солих шаардлагатай.

Долоо. Хөдөлмөрийн эрүүл ахуй

7.1. Бичил уурхайн тоосжилт, хорт хий, бодисын нөлөөллөөс дараах байдлаар хамгаална:

7.1.1. ажилтнууд ам, хамрын хаалт зэрэг тоосноос хамгаалах хэрэгсэл байнга хэрэглэх;

7.1.2. уурхайн тоосжилт ихтэй хэсэгт зохиомол агааржуулалт хийх;

7.1.3. бичил уурхайн ажлын бүсийн агаарын бүтэц, найрлагыг агаар хэмжигч багаж, эсхүл дөлний хамгаалалттай дэн ашиглаж шалгах;

Агаар дахь тоосны зөвшөөрөгдөх дээд хэмжээ

№	Тоосны шинж чанар	Зөвшөөрөгдөх дээд Хэмжээ, мг/м3
1	Цахиурын давхар ислийн агуулга 70 %-аас их (кварц, динас г.м.)	1
2	Цахиурын давхар ислийн агуулга 10-70 % (гранит, шамот, слюда г.м.)	2
3	Цахиурын давхар ислийн агуулга 2-10 % (шатамхай занар, зэс сульфидийн хүдэр, нүүрс, шавар г.м.)	4
4	Цахиурын давхар ислийн агуулга 2 %-аас бага	10

7.1.4. уурхайн ажлын бүсийн агаарт хүчилтөрөгч (O₂) 19.5%-аас багагүй, нүүрс хүчлийн хий (CO₂) 0.5 %-аас ихгүй байх;

7.1.5. уурхайд тэсэлгээ хийлгэсний дараа зохиомол агааржуулалт хийж хортой хий, бодис, тоосыг зайлуулж агаарын найрлагыг хэмжих;

Агаар дахь зарим хортой хий, бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ

№	Хортой хий, бодис	Эзлэхүүн, %	Концентраци, г/ м3
1	Азотын ислүүд		
	N ₂ O ₅ -д шилжүүлснээр	0.0001	5
	NO-т шилжүүлснээр	0.0002	2
2	Нүүрстөрөгчийн дутуу исэл CO	0.0016	20
3	Хүхэрт устөрөгч H ₂ S	0.00066	10
4	Хүхэрлэг ангидрид SO ₂	0.00035	10
5	Акролеин CH ₂ =CHCHO	0.00009	0.2
6	Формальдегид CH ₂ O	0.00004	0.5
7	Бензипрен 3.4	-	0.00015

7.1.6. тэсэлгээний ажил болон ажлын байрыг халаахаар галлагаа хийсний дараа агааржуулалт хийж, агаарын найрлага дахь бодисын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл уурхайд орохыг хориглох;

7.1.7. агаар дутагдах, амьсгалахад хэцүү болох, толгой эргэх, толгой өвдөх, дотор муухай болох зэргээр ямар нэг химийн хорт бодис ялгарч байгааг мэдэрвэл ажлын байрыг яаралтай орхин гарч шаардлагатай агааржуулалт хийх;

7.1.8. химийн хорт болон аюултай бодис ашиглахыг хориглох.

7.2. Шуугиан, доргионы хортой нөлөөллөөс дараах байдлаар хамгаална:

7.2.1. бичил уурхайн ажлын бүсийн шуугианы ерөнхий түвшин 85 дБА-аас ихгүй байх ёстой бөгөөд зөвшөөрөгдөх хэмжээнээс их шуугианд сонсголын эрхтэн хамгаалах чихний бөглөө, чихэвч хэрэглэх;

7.2.2. бичил уурхайд чулуулгийг цохиж буулгах, бутлах, хийн алх, өрөм ашиглах үед ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл ашиглах;

7.3. Ажилтнуудын амьдрах суурьшлын бүс, хог хаягдлын менежмент:

7.3.1. бичил уурхайн ажилтнууд олборлолтын талбайн гадна сум, дүүргийн Засаг даргын тогтоож өгсөн суурьшлын бүсэд амьдрах;

7.3.2. сум, дүүргийн Засаг даргын тогтоосон талбайд ариун цэврийн шаардлага хангасан хог хаягдлын цэг болон бие засах газар барьж байгуулах;

7.4. Бичил уурхайн гэрэлтүүлэг:

7.4.1. уурхайн харанхуй бүсэд ажиллах үед ажилтан бүр зориулалтын нэг бүрийн гэрэлтүүлэгчийг хэрэглэнэ;

7.4.2. гэрэлтүүлэгч нь 8 цагаас доошгүй хугацаагаар тасралтгүй, хэвийн ажиллах хүчин чадалтай байна;

7.4.3. уурхайд нэг бүрийн гэрэлтүүлэгчгүй орох, уурхайн малталтад гэрлээ асаахгүй ажиллах, явах, амрахыг хориглоно.

Найм. Дүрэм зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

Энэхүү дүрмийг зөрчсөн буруутай этгээдэд зөрчлийн байдал, түүний үр дагаврыг харгалзан холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийн
1 дүгээр хавсралт

“БИЧИЛ УУРХАЙН АЖИЛТНЫ ҮНЭМЛЭХ”-ИЙН ТУХАЙ ЖУРАМ

1. Бичил уурхайн ажилтан нь бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоор Иргэний хуулийн 35.1-д заасан нөхөрлөл, 36.4-д заасан хоршоо, мөн хуулийн 481.1-д заасан бүртгэгдээгүй нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээдэд гишүүнээр бүртгүүлсэн, тухайн аймаг, сумд оршин суугч, 18 нас хүрсэн Монгол Улсын иргэнд Бичил уурхайн ажилтны үнэмлэхийг олгоно.
2. Бичил уурхайн ажилтны үнэмлэхийг авснаар бичил уурхайгаар ашигт малтмал олборлох эрхтэй болно. Нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөлийн аль хэлбэрт гишүүнээр орсныг үнэмлэх дээр тэмдэглэнэ.
3. Бичил уурхайн ажилтны үнэмлэхийн хугацаа нь олгосон өдрөөс эхлэн 1 жилийн хугацаатай байна. Үнэмлэхийг 2 удаа сунгаж болно. Бичил уурхайн ажилтны үнэмлэхийн сунгалтыг хийлгээгүй бол түүнийг хүчингүйд тооцож дахин нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөлийн гишүүнээр элсэж, шинээр авч бичил уурхайгаар ашигт малтмал олборлох эрхтэй болно.
4. Бичил уурхайн ажилтнуудын иргэний үнэмлэх, хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр, гишүүнээр элссэн нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөлийн үүсгэн байгуулсан гэрээ, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг сум (дүүрэг)-ын Засаг даргын Тамгын газарт хадгална.
5. Бичил уурхайн ажилтнаар өөр нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөлд гишүүнээр шилжин ажиллахад шинээр үнэмлэх олгох ба үнэмлэхээ авсны дараа ажил хийх эрхтэй болно.
6. Бичил уурхайн ажилтан бичил уурхайн аюулгүй байдлыг дүрмийн шаардлагыг зөрчсөн тохиолдолд бичил уурхайн ажилтны үнэмлэхийг хураан авч бичил уурхай эрхлэх эрхийг хасна. “Бичил уурхайн ажилтны үнэмлэх”-ийг сум (дүүрэг)-ын мэргэжлийн хяналтын байгууллагын улсын хяналтын байцаагч хураан авч сум (дүүрэг)-ын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгнө.

Бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийн
2 дугаар хавсралт

БИЧИЛ УУРХАЙН АЖИЛТНЫ ҮНЭМЛЭХИЙН ЗАГВАР

Үнэмлэх № ...	СУНГАЛТ
_____ овогтой _____ нь _____ (нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөл)-ийн гишүүн тул бичил уурхайгаар ашигт малтмал олборлох эрхтэй. _____ сум (дүүрэг)-ын Засаг даргын Тамгын газраас 20 оны сарын өдөр олгов. Хүчинтэй байх хугацаа: 20 оны сарын өдөр хүртэл Тамга сум (дүүрэг)-ын Засаг дарга 	Хүчинтэй байх хугацаа: 20 оны сарын өдөр хүртэл сунгав. Тамга сум (дүүрэг)-ын Засаг дарга Хүчинтэй байх хугацаа: 20 оны сарын өдөр хүртэл сунгав. Тамга сум (дүүрэг)-ын Засаг дарга

Сум, (дүүрэг)-ын Засаг даргын Тамгын газар үнэмлэхийн дугаар олгохдоо
Үндэсний статистикийн хорооны Засаг захиргааны нэгжийн кодын дагуу бүртгэнэ.

Тухайлбал: Дорнод аймаг 21, Хэрлэн сум 01 кодтой тул “21-01-” гэж
бүртгэнэ.

— УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН — САЙДЫН ТУШААЛ

2019 оны 10 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар А/205

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Энэ журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Геологи, Уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Мөнхтөр/, Ашигт малтмал, газрын тосны газар /Х.Хэрлэн/-т тус тус даалгасугай.

Гурав. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Г.Ганхүү/-т даалгасугай.

САЙД

Д.СУМЬЯАБАЗАР

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн
А/205 дугаар тушаалын хавсралт

БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журмаар газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдлаас ашигт малтмал ялган авах, баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам нь ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, бусад эрх бүхий этгээдээс түүхий эд худалдан авч баяжуулах үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдэд хамаарна.

Хоёр. Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

2.1. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг:

2.1.1. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авах журмыг баримтлан Улсын комисс томилох;

2.1.2. Баяжуулах үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, хүлээн авах.

2.1.3. Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд хяналт тавих

2.2. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг

2.2.1. Баяжуулах үйлдвэрийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хүлээн авч шийдвэрлэх;

2.3. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг:

2.3.1. Баяжуулах үйлдвэрийн байршил, талбайг зураг зүйн бүртгэлд бүртгэх;

2.3.2. Баяжуулах үйлдвэрт ашиглагдаж байгаа техник, технологид үнэлэлт, дүгнэлт өгөх, техник, технологийн бодлогыг хэрэгжүүлэх;

2.3.3. Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, тайланг Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлд заасны дагуу хүлээн авах, нэгтгэх;

2.4. Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

2.4.1. Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгт заасан улсын хяналтыг тавьж ажиллана.

ГУРАВ. БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилсон Улсын комисс үйлдвэрийг хүлээж авсны дараа баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлэх;

3.2.Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлэхдээ Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх;

3.3.Ашигт малтмал баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг хагас үйлдвэрлэлийн болон технологийн туршилтын үр дүнд тулгуурлан боловсруулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хүргүүлж хэлэлцүүлэх;

3.4.Баяжуулах үйлдвэрийн ажиллагсдын ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлсэн байх;

3.5.Баяжуулах үйлдвэрийн эдэлбэр газар, ус ашиглах гэрээг холбогдох эрх бүхий этгээдтэй байгуулсан байх;

3.6.Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан жилийн үйлдвэрлэлийн төлөвлөгөө болон тухайн жилийн тайланг төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

3.7.Энэ журмын 5.2-т заасны дагуу технологийн хөндлөнгийн хяналт, сорьцлолт хийлгэсэн тайланг тухайн жилийн баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны тайланд хавсаргах;

3.8.Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд дараахь хууль, дүрэм, заавар, стандартыг баримталж ажиллана:

3.8.1.Ашигт малтмалын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам;

3.8.2.Ашигт малтмалыг баяжуулах, ялгах бутлах ба хүдэр баяжмалыг бөөнцөглөх фабрикийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм;

3.8.3.Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам;

3.8.4.Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах журам;

3.9.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр баяжуулах үйлдвэр, цехийн үйл ажиллагаа нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд учирч болзошгүй хортой нөлөөллийг урьдчилан тодорхойлж, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхойлох;

3.10.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд ашигт малтмал баяжуулах үйлдвэр, цехийн үйл ажиллагааг байгаль орчинд хохирол багатай явуулах, агаар мандал болон усны бохирдол, хүн, амьтан ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх цогц арга хэмжээг тусгах;

3.11.Баяжуулах үйлдвэр, цехийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирсан нөлөөллийг тухай бүр бүртгэн, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг жил бүр гаргаж, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд тус тус хүргүүлэх;

3.12.Баяжуулах үйлдвэрт холбогдох хууль, тогтоомжийн дагуу олборлосон, гарал үүсэл нь тодорхой ашигт малтмалыг худалдан авч болох бөгөөд түүнийг тээвэрлэх автозам, төмөр зам гэх мэт бусад дэд бүтцийн асуудлыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэсэн байх;

3.13. Гарал үүсэл нь тодорхойгүй ашигт малтмалыг баяжуулахгүй байх;

3.14. Баяжуулах үйлдвэрт хэрэглэх химийн хорт болон аюултай бодисыг худалдан авах, хадгалах, тээвэрлэх, ашиглах болон устгахад Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах болон устгах журмыг баримтлах;

3.15.Хаягдлын аж ахуйн зураг төслийг тооцоо судалгааны үндсэн дээр боловсруулах бөгөөд энэ нь техник, эдийн засгийн үндэслэлийн салшгүй хэсэг байх.

3.16.Хаягдлын аж ахуйн зураг төсөлд тусгагдсан цэвэр, бохир усны нуур, цөөрмийг үүсгэхдээ холбогдох дүрэм, журам, стандартыг баримтлах;

3.17.Хэрэв гадаадаас ажиллах хүч авч ажиллуулах бол Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч авах тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэгт заасныг мөрдөж ажиллах.

ДӨРӨВ. Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага

4.1.Баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжийг аймаг, нийслэлээс томилсон техникийн комисст хүлээлгэн өгч акт гаргуулсан байх;

4.2.Баяжуулах үйлдвэрийн техник, технологи нь орчин үеийн шаардлагад нийцсэн, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөлгүй байх;

4.3.Агаар мандал, хөрс, усны чанарт нөлөөлөх хорт хий, химийн хорт болон аюултай бодисын агууламжийг зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байх;

4.4.Баяжмал дахь үндсэн болон дагалдах ашигт элемент бүрийн агуулгыг тодорхойлсон байх;

4.5.Баяжуулах үйлдвэрт шаардлагатай ус, цахилгаан, дулаан хангамжийн эх үүсвэрийг бүрдүүлэх, холбогдох зөвшөөрлийг авч шаардлагатай тохиолдолд гэрээ байгуулсан байх;

4.6.Үйлдвэрийн гадаад орчин дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

4.6.1.Үйлдвэрийн хаяг, байршлын ерөнхий зургийг байршуулсан байх;

4.6.2.Зам, талбайг цардсан, анхааруулах болон мэдээлэх тэмдэг, тэмдэглэгээ, гэрэлтүүлэгтэй байх,

4.6.3.Тохижилт, эрүүл ахуйн шаардлага хангасан байх;

4.6.4.Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг түр хадгалах болон устгах, тусгайлан зассан цэг талбайтай байх;

- 4.6.5.Бүтээгдэхүүн, материал, химийн бодисыг зөөвөрлөх, ачиж буулгах зориулалтын цардсан зам, талбайтай байх;
- 4.6.6.Химийн бодис хадгалах зориулалтын агуулахтай байх.
- 4.7.Баяжуулах үйлдвэрийн ажлын байранд тавигдах шаардлага. Үүнд:
 - 4.7.1.Ажлын байрны тодорхойлолттой байх;
 - 4.7.2.Технологийн дамжлага бүр мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байх;
 - 4.7.3. Хүний нөөцийг мэргэжил дээшлүүлэх болон давтан сургалтад хамруулсан байх;
 - 4.7.4.Баяжуулах үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нэгдсэн дүрэмд нийцсэн байх;
 - 4.7.5.Үйлдвэрийн доторх дэвсгэр зураг, орц, гарцын схемийг байршуулсан байх;
 - 4.7.6.Ажлын байрны дүгнэлт гаргуулсан байх;
- 4.8.Баяжуулах үйлдвэр дээр дараах баримт бичгийг байлгана. Үүнд:
 - 4.8.1.Хуулийн этгээдийн гэрчилгээ (хуулбар);
 - 4.8.2.Химийн хорт болон аюултай бодис ашиглах тусгай зөвшөөрөл;
 - 4.8.3.Үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл;
 - 4.8.4.Баяжуулах үйлдвэрийн хаягдлын аж ахуйн зураг төсөл;
 - 4.8.5.Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө болон тайлан, сар, улирал, долоо хоногийн мэдээ;
 - 4.8.6.Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө;
 - 4.8.7.Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ;
 - 4.8.8.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө;
 - 4.8.9.Газар ашиглах гэрээ;
 - 4.8.10.Ус ашиглах гэрээ;
 - 4.8.11.Цахилгаан ашиглах гэрээ;
 - 4.8.12.Хөрөнгө түрээслэх болон бүтээгдэхүүн борлуулах гэрээ;
 - 4.8.13.Үйлдвэрийн үндсэн түүхий эдийг худалдан авах гэрээ, хэлцэл;
 - 4.8.14.Ажил гүйцэтгэх зааварчилга;
 - 4.8.15.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилга, сургалтын бүртгэл;
 - 4.8.16.Баяжуулах үйлдвэрийн ажилчдын судалгаа (Мэргэжлийн боловсон хүчин, орон нутгаас ажиллагсдын мэдээлэл);
 - 4.8.17.Төлөвлөгөөт хяналт, сорьцолтын тайлан, хяналтын байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлийн тайлан;

4.8.18.Баяжуулалтын технологийн хяналтын өдөр тутмын бүртгэл.

4.9.Баяжуулах үйлдвэр нь технологийн заавартай байх бөгөөд 5 жил тутамд шинэчлэн үйлдвэр, хэсгийн эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулсан байх.

4.10.Тоног төхөөрөмжийн ашиглалтын паспортыг хөтлөх.

4.11.Хаягдлын аж ахуйн хяналт, шинжилгээ, үнэлгээний ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

ТАВ. Баяжуулах үйлдвэрийн технологийн хяналт, сорьцлолт

5.1.Баяжуулах үйлдвэрийн технологийн хаягдлыг зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор технологийн дотоод хяналт сорьцолтыг тогтмол хийнэ.

5.2.Баяжуулах үйлдвэрийн алдагдал хаягдлыг тогтоох хөндлөнгийн технологийн хяналт сорьцолтыг мэргэжлийн байгууллагаар жилд нэгээс доошгүй удаа хийж гүйцэтгүүлнэ.

ЗУРГАА. Бичил уурхайгаар олборлосон ашигт малтмалыг баяжуулах талаарх зохицуулалт

6.1.Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч нь баяжуулах ашигт малтмалын гарал үүсэл, тоо хэмжээ, бичил уурхай эрхлэгч этгээдийн бүртгэлийг хөтөлнө.

6.2.Баяжуулах үйлдвэрийн хаягдлыг гүйцээн баяжуулах зорилгоор борлуулснаас олсон орлогыг хэрхэн хуваарилах, захиран зарцуулах талаар ашигт малтмал нийлүүлсэн бичил уурхай эрхлэгч этгээдтэй харилцан тохиролцож, гэрээ байгуулна.

6.3.Бичил уурхай эрхлэгч этгээд баяжуулах үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилга, дотоод журмыг дагаж мөрдөнө.

ДОЛОО. Баяжуулах үйлдвэрийг хаах

7.1.Ашигт малтмалын тухай хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу үйлдвэрийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хаах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7.2.Баяжуулах үйлдвэр хаалт хийхдээ Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмыг баримтална.

НАЙМ. Хариуцлага

8.1.Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд Зөрчлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

— БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД, — УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 8 дугаар
сарын 17-ний өдөр

дугаар А/226, А/182

Аргачлал, төлөвлөгөөний загвар батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т заасныг үндэслэн, Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалыг 1 дүгээр хавсралтаар, Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний загварыг 2 дугаар хавсралтаар, Нөхөн сэргээлтийн мэдээний тайлангийн загварыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аргачлал, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга Г.Нямдаваа, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Даваадорж нарт даалгасугай.

3. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын дагуу нөхөн сэргээлт хийлгэж, нөхөн сэргээлт хийсэн талбайг ажлын хэсэг томилон актаар хүлээж авсан талаар тайланг аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэхийг сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Дээрх мэдээ, тайланг нэгтгэж, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Ашигт малтмал, газрын тосны газарт жил бүрийн эхний улиралд багтаан хүргүүлэхийг Аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга нарт үүрэг болгосугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД
Д.ОЮУНХОРОЛ

УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД
Ц.ДАШДОРЖ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан
2017 оны 8 дугаар сарын 17-ний өдрийн
А/2269,А/182.тоот тушаалын
1 дүгээр хавсралт

БИЧИЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН УЛМААС ЭВДЭГДСЭН ГАЗАРТ НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙХ АРГАЧЛАЛ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү аргачлалын зорилго нь бичил уурхайн олборлолтын улмаас эвдэрч доройтсон газар (Цаашид “эвдэрсэн газар” гэх)-ыг байгалийн унаган төрхөд ойртуулан, олон нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн, нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн байдлаар нөхөн сэргээхэд оршино.

1.2. Бичил уурхайн болон хууль бусаар ашигт малтмал ашигласан, эвдэгдэж эзэнгүй орхигдсон газарт байгаль орчны онцлог, газрыг цаашид ашиглах чиглэлийг тогтоосны дараа байгаль орчны нөхөн сэргээлтийг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.

1.3. Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх орон нутгийн төсөв, хөрөнгөөр энэхүү аргачлалыг мөрдөж иргэдийн нөхөрлөл, иргэдээр нөхөн сэргээлт хийлгэж болно.

1.4. Усны нөөц, цацраг идэвхт элемент агуулсан хүдэр, газрын тос, байгалийн хийн олборлолт, химийн хортой, аюултай бодис ашигласан уурхай түүний барилга байгууламж, тэсэлгээний ажил хийгдсэн газарт энэхүү аргачлалыг ашиглахгүй.

1.5. Бичил уурхайн нөхөн сэргээлтийг техникийн болон биологийн гэсэн хоёр үе шаттайгаар гүйцэтгэнэ.

ХОЁР. ТӨЛӨВЛӨЛТ

1.1 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн хүрээнд хийх ажлын хэмжээ, хугацаа, ажиллах хүч, нөхөн сэргээлтийн зардал зэргийг тодорхойлсны үндсэн дээр нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулан сум, дүүргийн Засаг даргаар батлуулан дагаж мөрдөнө. Төлөвлөгөөнд дараах асуудлуудыг тусгана. Үүнд:

1.1.1 Тухайн газрын эвдрэлийн хэмжээг тогтоож, нөхөн сэргээх зардлыг тооцох; (Нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх баг бүрдүүлж, унаа, хоол, хүнс болон цалин хөлсний талаар урьдчилсан тооцоо хийсэн байна);

1.1.2 Нөхөн сэргээлтэд ашиглах гар багаж хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж. (Хүрз, лоом, жоотуу, цахилгаан өрөм, шаардлагатай тохиолдолд уул уурхайн бага оврын машин техник хангамжийг бэлтгэх);

1.1.3 Нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах зардал, түүний эх үүсвэр (Бичил уурхайчдын дундын сан, орон нутгийн төсвийн хөрөнгө, төслийн хөрөнгө оруулалт г.м) нь тодорхой байх;

1.1.4 Эвдэрсэн газрыг цаашид ашиглах чиглэлийг тогтоож сум, дүүргийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдөд танилцуулсан байна. Газар ашиглалтын хэлбэр нь бэлчээр, хөдөө аж ахуйн газар, аялал жуулчлал, сургалт зэрэг газар ашиглалтын бүх төрөл байж болно. Тухайн газрын онцлог шинж, нөхцөл байдлыг тодорхойлон бичиглэл хийх; (Тал, хөндий, сайр, үерийн татам, тал хээр, ойт хээр, цөл, уулын хээр, цөлөрхөг хээр, говь г.м);

1.1.5 Нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн газарт голын голдрилыг сэргээх, гадагш урсгалгүй тогтонги усан сан, цөөрөм үүсгэхийг хориглоно. Ус зайлуулах суваг байгуулж болно;

1.1.6 Хөрсний бохирдол үүссэн байж болзошгүй тохиолдол бүрийг Аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газарт мэдээлэх, шаардлагатай үед дээж сорьцуудыг авч шинжлүүлэн байгаль орчны хяналтын улсын байцаагчаар нөхөн сэргээлт хийхийн өмнө, хойно дүгнэлт гаргуулна.

ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙХ ГАЗРЫН ХИЛ ХЯЗГААР

1.1 Нөхөн сэргээлт хийх талбайн солбицлыг GPS-ээр хэмжиж, тодорхой шаардлага хангасан масштабын зурагт буулган эвдэрсэн газрын хэмжээг тодорхойлно. GPS- ээр хэмжиж тогтоосон солбицол бүхий цэг (20-25см өндөр, 25-30см өргөн);-т пайз тавьж тэмдэгжүүлнэ. (Пайзанд цэгийн нэр, зориулалт, устгаж болохгүй талаарх анхааруулгыг бичсэн байна);

1.2 Талбайн зах, замын уулзвар өндөрлөг, цэгүүд дээр “Нөхөн сэргээлт хийгдэж байна, нөхөн сэргээлтээс өөр үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн бичээс бүхий жижиг самбар байрлуулна;

1.3 Талбайн хилийг тэмдэгжүүлэхдээ газар ухаж зурвас гаргах, шуудуу татах, овоо босгох зэргээр ямар нэгэн байдлаар газарт нөлөө үзүүлэх үйлдэл хийхийг хориглоно;

ДӨРӨВ. ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

1.1. Техникийн нөхөн сэргээлтийн бэлтгэл ажил

Эвдэрсэн газарт дүүргэлт хийх, хэлбэршүүлэх, тэгшлэх, шимт хөрсөөр хучих зэргээр биологийн нөхөн сэргээлтэд бэлтгэх ажлыг техникийн нөхөн сэргээлт гэнэ.

1.2. Техникийн нөхөн сэргээлтийн ажлыг эхлэхийн өмнө дараах бэлтгэл ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

a) Техникийн нөхөн сэргээлт хийх ажлын хэмжээг тогтоох;

b) Нөхөн сэргээлт хийх техник технологийг сонгох;

c) Газрын эвдрэлийг эзэлж буй талбай, түүний гүнээс хамаарч Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS 5916:2008 стандартыг баримтлан тодорхойлон ангилах;

1.3. Дүүргэлт хийх материалын хэмжээг тооцно. Үүнд:

а) Нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж буй газрын эвдрэлийн хэмжээ (эвдэрсэн талбайн нийт хэмжээ, нүхний хамгийн их болон бага гүн, дундаж гүн, үүссэн овоолгын талбай, дундаж өндөр г.м)-г тоолж бүртгэх;

б) Овоолго болон ухмал газрын нийт хэмжээг хяналт үнэлгээний хүснэгтийн хавсралт 2-т тусгасан томъёоны дагуу эзлэхүүнээр нь тооцож, нөхөн сэргээлтэд ашиглаж болох материалын хэмжээг тодорхойлох;

в) Хяналт үнэлгээний хүснэгтийн хавсралт 2-т тусгасан томъёогоор тооцож гаргасан овоолго болон нүхний эзлэхүүнийг харьцуулан үзэж, дүүргэлтэд ашиглах материал хүрэлцээтэй эсэхийг тогтоох;

д) Нөхөн сэргээлт хийх талбай дахь нүх, овоолго, зам зэргийг газрын зурагт тэмдэглэх, нөхөн сэргээлт хийх эрэг, хэцийн налуу, эгц байдлыг үнэлэх, тодорхойлох;

1.4. Техникийн нөхөн сэргээлтийг гүйцэтгэх

1.1.1. Техникийн нөхөн сэргээлтийг гүйцэтгэхдээ аюулгүй байдлын шаардлагыг ханган ажиллана. Үүнд:

а) Нурах эрсдэлтэй, суулт үүссэн нүх болон уурхайн доторх хонгилын тоог гаргана. Нурах эрсдэл хэт өндөр байгаа тохиолдолд энэхүү аргачлалын дагуу нөхөн сэргээлт хийхгүй байх;

б) Нүх, уурхайн босоо аманд дүүргэлт хийхдээ нурах эрсдэлтэй уурхайн хонгилыг нурааж аюулгүй болгох, нүх болон уурхайн хонгилын доод хэсгийг хайрга болон том, хүнд чулуу (боломжтой тохиолдолд) ашиглан дүүргэлт хийх;

в) Нүх болон уурхайн хонгилын газрын гадаргууд ойр буюу өнгөн хэсэгт хайрга, элс, гадаргуугийн хэсэгт илүү жижиг, хөнгөн материал ашиглах;

д) Талбайд үүссэн овон товон гадаргууг тэгшлэх, налуу гадаргууг орчных нь гадаргуугийн хэлбэр төрхтэй ойртуулан хэлбэршүүлэх, тогтворжуулах арга хэмжээ авах;

е) Усны урсгалын нөлөөгөөр элэгдэлд өртөж болзошгүй бол усны элэгдлээс сэргийлэх, хөрсний тогтвортой байдлыг хангах зорилгоор олборлолтоос үүссэн овоолго материал, чулуулгаар дүүргэлт хийх. (Хэлбэржүүлэхдээ налууг зохих өнцгөөс хэтрүүлэхгүй байх);

ф) Гидрологийн судалгааны дагуу усны голдирол бүхий газруудад усны урсгалын нөлөөнд өртөж эвдрэхээс урьдчилан сэргийлэх, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх. (Тохойрсон хэсэгт том чулуугаар бэхэлгээ хийх замаар элэгдлийн эрчмийг бууруулах г.м);

г) Алтны үндсэн орд болон жоншны ордын хувьд хангалттай хэмжээний овоолго материал байхгүйн улмаас нүхийг бүрэн дүүргэх боломжгүй байдаг. Энэ тохиолдолд тухайн нүхийг мал болон бусад амьтдын хувьд аюулгүй болгож “орох, гарах гарц” бүхий замыг гаргаж өгөх шаардлагатай. Нүх, уурхайн босоо ам зэргийг бүрэн дүүргэх шаардлагатай бол ойролцоо орших сумын засаг даргын зөвшөөрсөн цэгээс авсан материалаар нүх, уурхайн босоо аманд дүүргэлт хийх;

h) Уул уурхайн бага оврын техник ашиглан, овоолго, хаягдал чулуулаг, хана мөргөцгийн оройг намсгаж, хэлбэршүүлэх, дүүргэлт хийсэн талбайг тэгшлэх, хэлбэржүүлэхдээ аль болох гар багаж ашиглах, шаардлагатай тохиолдолд бага оврын техник ашиглах (Хавсралт 3);

i) Уурхайн тоног төхөөрөмж, машин техник ашигласны улмаас дагтаршиж, нягтарсан хөрсийг сийрэгжүүлэх;

j) Техникийн нөхөн сэргээлт хийсэн газрын гадаргууг эхлээд хөрсөн доорх шимтлэг шороогоор дараа нь хадгалсан шимт хөрсөөр хучиж биологийн нөхөн сэргээлт хийхэд тохиромжтой байх нөхцөлөөр хангах;

1.1.2. Хучилт хийх шимт хөрсийг тодорхойлох, бэлтгэх

Нөхөн сэргээлт хийх талбай дахь шимт хөрсний овоолгын байршлыг тодорхойлох, зохистой хадгалах, хамгаалах нь өртөг багатай, үр дүнтэй нөхөн сэргээлтийн гол чухал хүчин зүйл болдог. Олборлолт хийж дууссан талбайд байгаа шимт хөрсийг олж тогтооно. Шимт хөрсний овоолго нь дараах газруудад байж болно. Үүнд:

a) Шимт хөрсийг тусад нь овоолсон овоолго;

b) Овоолгын доод хэсэгт дарагдсан шимт хөрс;

c) Эрэг, гуу жалгыг зохих өнцөг гарган налуулах, хэлбэржүүлэх явцад хөндөгдөж буй шимт хөрс гарах ба органик агууламж баялаг хөрс бараан үе давхаргатай харагддаг;

d) Тухайн газарт шимт хөрсний олдоц муу бол өөр газраас шимт хөрс авахдаа байгаль орчин, газар нутгийг эвдэлж, сүйтгэхгүй байх бөгөөд зохих зөвшөөрөлтэй авч ашиглана;

e) Эвдэгдсэн талбайг хучих, шимт хөрсний давхарга нь 10 см-ээс доошгүй зузаантай байх шаардлагатай талбайг харгалзан, шимт хөрсний нийт хэмжээг тооцно; (Шимт хөрсний нийт хэмжээг тооцох томъёог Хавсралт 2-т оруулав)

1.1.3. Техникийн нөхөн сэргээлт хийсэн бүх талбайд шимт хөрсний хучилт хийхээр төлөвлөж тооцох ба хэрэв хангалтгүй тохиолдолд шимт хөрсөөр зайлшгүй хучилт хийх газруудыг тодорхойлж түүвэрлэн хийж болно. Үүнд:

e) Шимт хөрсөөр хучилт хийх.

f) Чийгтэй, нойтон нөхцөлд машин, техникийн ашигласнаас болж үүсдэг хөрсний дагтаршил, нягтарших эрсдэлийг багасгахын тулд шимт хөрсөөр хучилт хийх, үүссэн гадаргыг биологийн нөхөн сэргээлтэд бэлтгэхдээ аль болох гар багаж ашиглаж ажиллах;

g) Нөхөн сэргээлт хийх нүхний амсрыг тэлж налуулах явцад гарсан шимт хөрсийг гар багажаар тусгайлан ялган цуглуулж, доорх давхаргыг нь нурааж налуулсны дараа уг шимт хөрсөөр хучилт хийх;

h) Шимт хөрсний олдоц, хэмжээнээс шалтгаалан техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг шимт хөрсөөр бүхэлд нь буюу эсвэл хэсэгчилсэн байдлаар 10 см-ээс багагүй зузаантайгаар хучилт хийх;

i) Нөхөн сэргээлт хийх талбайн сийрэгжүүлэлтийг борнойдох болон хүрэл, жоотуу зэрэг гар багажаар хийх гэх мэт болно.

ТАВ. БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

Биологийн нөхөн сэргээлт нь бичил уурхайн нөхөн сэргээлтийн ажлын эцсийн үе шат болно.

1.1. Хөрсний органик агууламжийг нэмэгдүүлэх

Уурхайн олборлолтын явцад шимт хөрс нь багасах, бусад материалтай холилдсоны улмаас чанар нь муудах, бохирдох тохиолдол их байдаг. Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч болно. Үүнд:

- a) Хөрсний бүх давхаргын органик агууламжийг нэмэгдүүлэх;
- b) Ус хадгалах, барих чадавхыг нь нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- c) Малын өтөг, бууцыг цуглуулах ба нөхөн сэргээлтэд тохиромжтой нутгийн ургамлын үрийг түүж бэлтгэх;
- d) Малын өтөг, бууцыг нөхөн сэргээлт хийх талбайн гадаргууд шимт хөрсөөр бага хучигдсан газар болон шимт хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх зорилгоор зохих хэмжээгээр тараан цацах;
- e) Боломжтой тохиолдолд өвс, сүрэл зэрэг бусад хадаж, огтолж авсан ойр орчмын ургамлыг техникийн нөхөн сэргээлт хийсэн гадаргуу дээр тарааж, шимт хөрстэй хольж дэвсэх; (Энэхүү хэрчсэн ургамал нь хөрсний чийгийг хадгалахад туслах ба салхиар зөөгдөн ирсэн үрийг тогтоон барьж, хөрсөнд үр болон органик агууламжийг нэмэгдүүлэхэд тусалдаг)
- f) Ой, ойт хээрийн орчинд нөхөн сэргээсэн газарт өмхөрсөн унанги мод, холтос, мөчир, гишүүг тараах. (Энэхүү өмхөрсөн мөчир, гишүү нь хөрсөнд задран шингэж, сээр нуруугүй амьтдын амьдрах орчныг бүрдүүлэх ба тус газар салхиар хийсэн ирэх үр, ургамлын занга болж тогтоон барихад тусалдаг)

1.2. Байгалийн аясаар сэргэн ургамалжих чадавхыг үнэлэх

Тухайн газрын ургамалжилтын байдал болон ойролцоох газрын байгалийн аясаар ургамалжих чадавх нь биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийх нөхцөлийг харгалзан өндөр, дунд, сул гэж ангилна.

1.1.1. Байгалийн аясаар сэргэн ургамалжих төлөв байдал нь “Өндөр” гэж үнэлэгдсэн талбайд биологийн нөхөн сэргээлт хийх шаардлагад техникийн нөхөн сэргээлт хийх талбайг шимт хөрсөөр хучиж байгалийн аясаар ургамалжина гэж үзнэ. “Өндөр” гэсэн ангилалд хамаарах үзүүлэлтүүдийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

- a) Эвдэрсэн газрын хөрсний үзүүлэлт маш сайн;
- b) Орчмын ургамлын бүрхэвч баялаг;
- c) Бүс нутагт хур тунадасны хэмжээ өндөр;
- d) Газар ашиглалт нь байгалийн сэргэлттэй нийцтэй.

1.1.2. “Дунд” гэсэн ангилалд хамаарах талбайд биологийн нөхөн сэргээлтийн зарим нэгэн үйл ажиллагаа явуулах шаардлагатай ба тухайн газарт шимт хөрсний органик агууламжийг нэмэгдүүлэх, тухайн бүс, бүслүүрт ургадаг ургамлын үр, суулгац тарихдаа мэргэжлийн байгууллага, ажилтны дүгнэлт, зөвлөмжийн дагуу биологийн нөхөн сэргээлт хийнэ. “Дунд” гэсэн ангилалд хамаарах үзүүлэлтүүдийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

- a) Эвдэрсэн газрын хөрсний үзүүлэлт харьцангуй сайн;
- b) Орчмын ургамлын бүрхэвч харьцангуй баялаг;
- c) Бүс нутагт хур тунадасны хэмжээ хангалттай;
- d) Газар ашиглалт бага зэрэг явагдсан г.м.

1.1.3. Байгалийн аясаар сэргэн ургамалжсан төлөв байдал нь “Сул” гэж үнэлэгдсэн талбайд биологийн нөхөн сэргээлтийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Тухайн нөхөн сэргээлтэд ашиглах шимт хөрсийг олж тогтоох, хадгалах, хамгаалах, ургамалжуулах, усалгаа хийж арчилж хамгаална. Гэхдээ байгалийн бүс бүслүүрийн онцлогоос үүдэн тухайлбал, говийн нөхцөлд ургамлын бүрхэвч сийрэг, хур тунадас хангалтгүй, шимт хөрсний олдоц муу тул биологийн нөхөн сэргээлтийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаа хязгаарлагдмал болох учраас мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагын тусламжтайгаар биологийн нөхөн сэргээлт хийнэ. “Сул” гэсэн ангилалд хамаарах үзүүлэлтүүдийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

- a) Эвдэрсэн газрын хөрсний үзүүлэлт тохиромж муутай;
- b) Орчмын ургамлын бүрхэвч сийрэг;
- c) Бүс нутагт хур тунадасны хэмжээ хангалтгүй;
- d) Газар ашиглалт ихээр явагдсан г.м.

5.3 Ургамлын зүйлийг тодорхойлох, жагсаалтыг бэлтгэх

Ургамлын бүрхэвчийн үнэлгээнд үндэслэн биологийн нөхөн сэргээлтийн цар хүрээг тодорхойлох ба нөхөн сэргээлтэд тухайн бүс бүслүүрийн зонхилох ургамлыг тарина.

1.1.1. Биологийн нөхөн сэргээлт нь тухайн экологийн бүс болон орон нутгийн орчны нөхцөл зэрэгт тохирсон байх хэрэгтэй. Үүний тулд тухайн орон нутагт ургадаг ургамлын зүйлүүдийг тодорхойлох нь зүйтэй. Орон нутгийн ургамлын зүйлийн жагсаалтыг доорх таван төрөлд ангилж бэлтгэнэ. Үүнд:

a) Ерөнхий жагсаалт: Орчмын хэд хэдэн газарт 1-5 м² талбайг сонгон авч, талбай доторх бүх ургамлын ерөнхий бичиглэл хийнэ. Үүнд тухайн орчны зонхилогч болон дэд зонхилогч ургамлыг тодорхойлох;

b) Тухайн газарт хийсэн ургамлын ерөнхий бичиглэлд үндэслэн үрийн нөөцийг бүрдүүлэх, тарихад “хамгийн тохиромжтой ургамал”-ын төрөл зүйлийг тодорхойлж, биологийн нөхөн сэргээлтэд ашиглах;

c) Байгалийн аясаар ургамалжих ургамлын төрөл зүйлийг тодорхойлон, биологийн нөхөн сэргээлтийн зорилгод нийцэж байгаа эсэхийг тодорхойлох;

Нөхөн сэргээлтийн дараах газар ашиглалтыг харгалзан үзэж биологийн нөхөн сэргээлтэд ашиглах ургамлын төрөл зүйлд үнэлгээ хийх (бэлчээрийн ач холбогдолтой ургамал г.м); Зарим тохиолдолд тохирох буурцагт ургамал ашиглах нь хөрсний үржил шимийг сайжруулах ач тустай.

1.4. Биологийн нөхөн сэргээлтийг гүйцэтгэх

Тухайн газарт биологийн нөхөн сэргээлт ямар түвшинд явагдахаас шалтгаалан биологийн нөхөн сэргээлтийг дараах дэс дарааллаар гүйцэтгэнэ. Үүнд:

- а) Нөхөн сэргээлтэд ашиглах тохиромжтой ургамал, байгалийн аясаар ургах чадвартай зүйлийг тогтоох, мэргэжлийн байгууллагаас зөвлөмж авах;
- б) Тохиромжтой ургамал, байгалийн аясаар ургах ургамлын үр (Нэг га-д цацах үрийн хэмжээ ойролцоогоор 5 кг байна.)-ийг аль болох ихээр цуглуулах;
- в) Өтөг, бууцтай, үр /Өтөг, бууц, үрийн холимгийг хөрсний шимт чанараас шалтгаалан янз бүрийн хэмжээгээр хольж/-ийг хөрсөнд тарааж цацахад бэлтгэх;
- г) Өтөг бууц, үрийн холимгийг шимт хөрсөнд тарааж, цацсаны дараа нөхөн сэргээлт хийсэн хөрсөнд ургамлын үр, өтөг бууц зэрэг шим тэжээлт бодис нэвтрэн орох боломжийг хангах зорилгоор тармуурдаж, хөрсөнд холих;
- д) Ойр орчмын газраас өвс хадаж аваад, хөрсийг хучсан өвс, сүрэл, бусад ургамлыг талбайд тогтвортой хадгалахын тулд өвсөө, шимт хөрстэй тармуураар хольж тараах;

1.1.1 Ойг нөхөн сэргээх

а) Бичил уурхайн олборлолтод өртсөн талбай ой бүхий газар байсан бол тухайн ойг нөхөн сэргээх, арга технологийг тодорхойлж, шаардагдах зардлыг ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний 1 га талбайн нормативт зардлыг үндэслэн тооцож гаргана.

б) Ойг нөхөн сэргээх ажилд мод үржүүлгийн газарт ургуулсан стандартын шаардлага хангасан тарьц, суулгацыг ашиглах ба ойгоос өсвөр залуу мод, сөөгийг шилжүүлэн суулгах, харь зүйлийн мод сөөг ашиглахыг хориглоно.

в) Ойг нөхөн сэргээх ажилд эрх бүхий байгууллагаас баталсан хууль, журам, стандарт, технологийн зааврыг мөрдөж ажиллана.

г) Ой нөхөн сэргээлт хийсэн талбайг эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу улсын ойн санд хүлээлгэн өгнө.

1.1.2. Биологийн нөхөн сэргээлтийг хийдээ үд дүнг нь дээшлүүлэх зорилгоор дараах арга хэмжээг хориглоно. Үүнд:

а) Биологийн нөхөн сэргээлтэд харь зүйлийн ургамал болон хувиргасан амьд организм (гений өөрчлөлттэй ургамал) ашиглах;

б) Биологийн нөхөн сэргээлт хийхэд тухайн бүс бүслүүрийн зонхилох болон дэд зонхилох бүлгийн ургамлаас өөр зүйл сонгох;

в) Биологийн нөхөн сэргээлтийг мэргэжлийн байгууллагын зөвлөмжийг зөрчин гүйцэтгэх. гэх мэт

ЗУРГАА. УУРХАЙН МӨЧЛӨГИЙН ХАНДЛАГА (НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ШАТАЛСАН АРГА)

1.1 Уурхайн загвар, төлөвлөлт: Бичил уурхайчид шинэ талбайд шилжих үед уурхайн мөчлөгийн хандлагыг авч хэрэгжүүлнэ. (Нөхөн сэргээлтийг үр дүнтэй, чанартай болон үр ашигтай хэрэгжүүлэхэд төлөвлөлт ихээхэн ач холбогдолтой байдаг.);

1.2 Сөрөг нөлөөллийг бууруулах шаталсан арга нь нөлөөллийг багасгах арга замыг тодорхойлно. (Тухайн нөхөн сэргээлтийн ажлыг хамгийн үр дүнтэй болгох нөхцөлийг бүрдүүлдэг);

1.3 Эхлээд сөрөг нөлөөллөөс зайлсхийж, дараа нь уул уурхайн үйл ажиллагааны явцад нөлөөллийг саармагжуулан, эцэст нь үр дүнтэй нөхөн сэргээлтийг гүйцэтгэнэ.

1.4 Тухайн газрын байгаль орчин, биологийн төрөл зүйлийн эрсдэлийг тодорхойлох, уул уурхайн загвар, төлөвлөгөө, зураг төсөл боловсруулан хэрэгжүүлнэ.

1.5 Газрын нөхөн сэргээлтийн мөчлөг: эхлээд хүнд чулуулаг материал, дараа нь хаягдал материал, чулуулаг, сүүлд нь шимт хөрсөөр дүүргэлт хийх буюу олборлолтын урвуу дарааллаар явуулна.

1.6 Шимт хөрсний менежмент сайн хийвэл нөхөн сэргээлтэнд дахин бордоо авах шаардлагагүй бөгөөд тарьсан үр хурдан хугацаанд соёолдог.

ДОЛОО. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

1.1 Хог хаягдлын тухай хуулийн 8.1.9а, 9.3.2 дахь хэсэгт заасны дагуу нөхөн сэргээлт хийх талбайн хог хаягдлыг цэвэрлэж, энгийн хог хаягдлыг аймаг, нийслэлийн Засаг даргын тогтоосон цэгт булшилна;

1.2 Хог хаягдлын тухай хуулийн 2 дугаар бүлгийн 7.1.3, 5 дугаар бүлэгт тус тус заасны дагуу химийн хортой аюултай бодис ашигласны улмаас үүссэн хог хаягдлыг тээвэрлэх, устгах арга хэмээ авна;

1.3 Бүх төрлийн батарей, хуванцар сав, баглаа боодол зэрэг аюултай хаягдлыг ангилахад эрүүл ахуйн болон байгаль орчны хяналтын улсын байцаагчийн зааварчилгааг авч, тогтоосон цэгт зайлуулна. Аюултай хог хаягдлыг зайлуулах үед байгаль орчны улсын байцаагчийн хяналтын доор ажиллана;

1.4 Эвдэрч, доройтсон газарт орхигдсон уурхайн хаягдал тоног төхөөрөмжийг зайлуулна.

НАЙМ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

1.1 Мэргэжлийн байгууллага, албан тушаалтанд хандаж, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаарх сургалт хийлгэж, түүнд нөхөн сэргээлтийн ажилд оролцох хүн нэг бүрийг хамруулна;

1.2 Нөхөн сэргээлтийн багийн гишүүн тус бүрийг хөдөлмөр хамгааллын иж бүрэн хэрэгсэл (ажлын хувцас, малгай, бээлий, хошуувч, нүдний шил г.м)-ээр хангагдсан байна;

1.3 Газар доорх хонгил, эрэг, тав газар, далан, хүн, мал, амьтан унаж гэмтэх эрсдэлтэй газрууд буюу нурж, суулт өгч болзошгүй газрууд, нүх, шуудуу зэрэг газруудыг тогтоож, улаан дарцаг хатгах буюу тойруулан тууз татаж тэмдэгжүүлнэ;

1.4 Нөхөн сэргээлт хийх нөхөрлөл, төрийн бус байгууллага нь нөхөн сэргээлтийн аюулгүй ажиллагааны журмыг боловсруулан мөрдөнө.

ЕС. НӨХӨН СЭРГЭЭСЭН ТАЛБАЙГ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ

1.1 Нөхөн сэргээлт хийсэн талбайд сум, дүүргийн Засаг даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг хүлээн авч мөн цаашид хяналт тавьж байна.

1.2 Нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэсэн нөхөрлөлөөс ажлын хэсэг нь нөхөн сэргээлт хийсэн талбайг хүлээн авсны дараа нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн баг нь тодорхой хугацаа (3-аас доошгүй жилд хяналт тавина).

Нөхөн сэргээлт хийсэн талбайг хүлээлгэн өгснөөс хойш их хэмжээний өөрчлөлт гарсан тохиолдолд (хүлээлгэн өгсний дараагаар суулт өгөх, гуу жалга үүсэх г.м) нөхөн сэргээлт хийсэн тал (бичил уурхайчид); нөхөн сэргээлтийн ажилд гарсан эвдрэлийг арилгаж ажиллана.

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хяналт үзлэг хийсэн огноо				
I.1 Нөхөрлөл/Хоршооны танилцуулга				
Нөхөрлөл/Хоршооны нэр				
Багийн ахлагч (Нөхөрлөл/Хоршооны тэргүүн)				
Газар эзэмшлийн статус (лиценз)				
Сум/дүүрэгтэй байгуулсан гэрээний дугаар, огноо				
I.2 Нөхөн сэргээх газрын мэдээлэл				
Газрын нэр				
Газрын байршил	Аймгийн нэр:	Сумын нэр:	Багийн нэр:	Аймаг, сумын товөөс
Талбайн хэмжээ:				
Газарзүйн солбицлын цэгүүд, тогтоосон хил хязгаар:				
Орд, ашигт малтмалын төрөл (үндсэн/шороон)				
Талбай ашиглалтын статус	Эвдрэлд өртөж, орхигдсон	Олборлолт хийж буй	Шинээр газрын зөвшөөрөл авах	
Хамгаалалтын чухал ач холбогдол бүхий нөөц (нөхөн сэргээх газрын орчимд)	Экологийн бүс; биологийн төрөл зүйл			
	Усны нөөц:			
	Түүх соёлын өв:			
Цаашдын газар ашиглалтын хэлбэр				
I.3 Бичил уурхайн нөхөн сэргээлтийн төслийн мэдээлэл				
Хугацаа				
Ажиллах хүчин	(нөхөн сэргээлтэд ажилласан хүний тоо)			
Уурхайн машин, хүнд техникийн ашиглалт	(Хэрэв уурхайн машин, техникийг нөхөн сэргээлтэд ашигласан бол техникийн үзүүлэлтийг бичих)			
Санхүүжүүлсэн эх үүсвэр				

II. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Тодорхойлолт	Шалгуур үзүүлэлтүүд	Тийм	Үгүй¹	N/A	Тайлбар (Илэрсэн дутагдал, залруулах арга хэмжээг тодорхой бичих, тэмдэглэх)
1. Хог хаягдлын менежмент						
1.1	Ахуйн хог хаягдлын цэвэрлэгээ, зайлуулалт	Нөхөн сэргээлтийн талбай дахь хог хаягдлыг цэвэрлэж, зайлуулсан эсэх.				
1.2	Аюултай хог хаягдлыг зайлуулсан байдал	Химийн болон аюултай хог хаягдлыг ялгах, зайлуулах, аюулгүйжүүлэх арга хэмжээ авсан эсэх.				
2. Гадаргуугийн тогтворжилт, хэлбэржүүлэлт						
2.1	Эвдрэлийн цар хүрээг үнэлсэн тооцоолол (тоон үзүүлэлтээр)	Нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж буй газрын эвдрэлийн хэмжээ (эвдэрсэн талбайн нийт хэмжээ, нүхний хамгийн их болон бага гүн, дундаж гүн, үүссэн овоолгын талбай, дундаж өндөр г.м)-г тогтоох.				
2.2	Гидрологийн үнэлгээ, усны менежментийн арга хэмжээ авсан нөхцөл	Усны голдирол бүхий газруудыг олж тодорхойлсон эсэх Нөхөн сэргээсэн гадаргууг урсгал усны элэгдэлд өртөж, эвдрэхээс сэргийлэх, голын голдирлыг сэргээх арга хэмжээ авсан эсэх.				
2.3	Нурах, суулт, цөмрөлт үүсэх эрсдэлийг бууруулсан байдал.	Нүх туннель, шрупыг зохих шаардлагын дагуу булалт, дүүргэлт хийсэн эсэх; нуралт, цөмрөлт үүсэхээс урьдчилсан сэргийлэх арга хэмжээ авсан эсэх.				
2.4	Ойр орчмын хөндөгдөөгүй гадаргуутай ойртуулан хэлбэршүүлсэн байдал	Стандартын түвшинд буюу хөрсний тогтвортой байдлыг хангаж, тэгшилгээг 35° болон түүнээс бага налуутай хийсэн эсэх.				

2.5	Дутуу орхисон нүх, шрул, ил харагдах хаягдал овоолго үлдээгүй, бүрэн дуусгасан байдал	Нөхөн сэргээлтийн талбай дахь бүх нүх туннелийг бүрэн булж дуусгасан эсэх.			
2.6	Дүүргэлтийн материалын хүрэлцээтэй байдал	Дүүргэлтэд ашигласнаас үлдсэн овоолгыг тарааж тэгшилгээ хийсэн эсэх. Бусад газраас дүүргэлтийн материал зөөж авчирсан эсэх, хэрэв нэмэлт материал зөөсөн бол тэр орчимд сөрөг нөлөөлөл, эвдрэл үүсгэсэн эсэх.			
2.7	Уурхайн машин техник ашигласан байдал	Хэрэв булалт дүүргэлтэд техник ашиглах шаардлагатай байсан бол эргэн тойрны эрүүл газрын ургамалан нөмрөг/ хөрсийг гэмтэхээс сэргийлсэн эсэх. Хэлбэржүүлэлт тэгшилгээ хийсний дараа хүнд машинаас үүдэлтэй хөрсний дагтаршил, нягтаршлаас зайлсхийж, хөрс сийрэгжүүлэлт хийсэн эсэх.			
3. Шимт хөрсний менежмент, хадгалалт					
3.1	Шимт хөрсний олдоц, хадгалалт хамгаалалт	Нөхөн сэргээлт хийх талбай дахь үржил шимт хөрсийг олж тодорхойлох, нөхөн сэргээлтийн явцад зохих ёсоор хадгалах хамгаалалт хийсэн эсэх. Хэрэв бусад газраас шимт хөрс авсан бол зохистой ашиглаж, шинээр газар сүйтгэхээс зайлсхийсэн эсэх.			
3.2	Шимт хөрсний хучилт	Ухайн талбай дахь шимт хөрсний олдцоос хамааран хэлбэржүүлсэн талбайд өнгөн хөрсний хучилтыг шаардлагын дагуу хийсэн эсэх.			
3.3	Хөрс сайжруулах арга хэмжээнүүд	Биологийн нөхөн сэргээлтэд бэлдэн, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх зорилгоор малын өтөг, бууц цуглуулж, үр цацах арга хэмжээ авсан эсэх.			

3.4	Уурхайн машин техникийн зохистой ашиглалт	Уурхайн машин, техник ашигласан тохиолдолд хөрсний дагтаршил, нягтарших аюулаас сэргийлсэн эсэх, дагтаршил үүсгэсэн газруудад гар багажаар хөрс сийрэгжүүлэх буюу хөнгөн техникээр борнойдох арга хэмжээ авсан эсэх.				
4. Биологийн нөхөн сэргээлт						
4.1	Орчны ургамлын бүрхэвчид хийсэн үнэлгээ	Тухайн нутагт ургадаг ургамлын төрөл зүйлүүд буюу зонхилогч ургамлуудыг тодорхойлж, бичиглэл хийсэн эсэх. Нөхөн сэргээлтэд ашиглах ургамлын төрөл зүйл ба хөл газрын ургамлуудыг тодорхойлж, тогтоосон эсэх. Нөхөн сэргээлтэд ашиглахад тохиромжтой ургамлын үрийг түүж цуглуулсан эсэх.				
4.2	Нутгийн ургамлын үр түүж бэлтгэсэн байдал	Тохирох нөхцөл бүхий газруудад мод бут шилжүүлэн суулгах, үрсэлгээ, мөчрөөр тайрц бэлтгэж тарьсан эсэх.				
4.3	Хөрс сайжруулалт, органик агууламжийг нэмэгдүүлсэн арга хэмжээ	Түүсэн ургамлын үрийг малын өтөг, бууцтай хольж, талбайд тарьсан эсэх.				
4.4	Хадлан бэлтгэж, тарааж хучсан байдал	Хадлан хийх боломжтой газруудад биологийн нөхөн сэргээлтийн үр дүнг нэмэгдүүлэх, хөрс хамгаалахын тулд ойр орчмоос өвс хадаж шимт хөрстэй хольж тармуурлан тараасан эсэх.				
4.5	Тарьсан мод бут, үрслэгээний усалгаа	Мод, бут, сөөг тарьсан нөхцөлд бие даан ургах хүртэл нь усалгаа хийж хуваарь гаргаж арчилгаа тордлогоо хийж буй эсэх.				

5. Бусад хамгаалал, менежментийн асуудлууд (зэрлэг амьтан, мал, соёл түүх болон оролцогч талууд г.м)				
5.1	Зэрлэг амьтан үзүүлэх нөлөөллийг бууруулсан	Тухайн бичил уурхайн нөхөрлөл/ТББ нөхөн сэргээлтийн явцад ойр орчмын зэрлэг амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг (түлш бэлтгэх, ан агнах, үргээх дайжуулах г.м) бууруулах, тэднийг хамгаалах арга хэмжээ авсан эсэх.		
5.2	Уурхайн мөчлөгт суурилсан арга зүйг хэрэгжүүлсэн байдал	Олоорлолт идэвхтэй хийхийн зэрэгцээ байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг бууруулах үүднээс ургамалан нөмрөг сүйдэхээс сэргийлэх, олборлолтын явцад шимт хөрөнний хадгалалт, хамгаалалт зохих ёсоор		
5.3	Мал болон бусад амьтдын хувьд аюулгүй нөхцөлийг бүрдүүлж, орох, гарах гарц бэлтгэсэн байдал	Хийж буй эсэх. Хэрэв хэт гүн нүх, уурхайн амыг бүрэн дүүргэх боломжгүй (үндсэн орны эвдрэлээс үүссэн) газруудад ан амьтны аюулгүй байдлыг хангаж орж гарах гарц бэлтгэсэн эсэх.		
5.4	Соёлын өвийн хамгаалал	Ойр орчимд соёлын өвийг тодорхойлж, хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлсэн эсэх.		
6. Нөхөн сэргээлтийн дараах хяналт мониторинг ба тордлогоо				
6.1	Нөхөн сэргээлтийн дараах арчилгаа тордлогоо хийх төлөвлөгөө	Талбайг хүлээлцэхийн тулд нөхөн сэргээлтийн дараах мониторинг, арчилгаа тордлогын төлөвлөгөө гаргаж тохиролцсон байх. Цаашид хууль бус ХАМО иргэд ахиж ухахаас сэргийлж хамгаалах талаар орон нутгийн удирдлага, бичил уурхайчид хэрхэн хамтарч ажиллах талаар тохирсон байх.		

(Footnotes)

1 “Үгүй” гэсэн үгнэлгээ өгсөн тохиолдол бүрд БУНСА-ын ямар шаардлагандыг зөрчсөн тухай, цаашид зарлуулах, сайжруулах шаардлагатай арга хэмжээний тухай “Тайлбар” хэсэгт тодорхой тэмдэглэх.

III. НӨХӨН СЭРГЭЭСЭН ТАЛБАЙД ХИЙСЭН ХЯНАЛТ, ҮЗЛЭГИЙН ДҮН

1.1 Үнэлгээ, дүгнэлт

Тухайн нөхөн сэргээлтийн талбайд БУНС-ын аргачлалын үндсэн шаардлагуудыг зөрчсөн эсэх талаар тэмдэглэх

.....

.....

.....

.....

.....

Хэрэв ямар нэгэн зөрчил илэрсэн бол, засах/сайжруулахын тулд цаашид авч хэрэгжүүлэхээр тохиролцсон арга хэмжээнүүдийг бичих

.....

.....

.....

.....

.....

1.2 Ерөнхий дүгнэлт, үнэлгээ өгсөн талаар доор бичих

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Хүлээн авах комисс/ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

1.
2.
3.

Зөвшөөрсөн: Бичил уурхайчдын нөхөрлөл/хоршооны ахлагч
овог.нэр

Он сар өдөр

1. Дүүргэлт хийх материалыг тооцох

- 1.1 Талбай дахь нийт нүх, овоолго, тав газар (тал талаасаа ухагдаж үлдсэн хэсэг)-ыг тоолж бүртгэх;
- 1.2 Нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж буй газрын эвдрэлийн хэмжээ (эвдэрсэн талбайн нийт хэмжээ, нүхний хамгийн их болон бага гүн, дундаж гүн, үүссэн овоолгын талбай, дундаж өндөр г.м)-г тогтоох;
- 1.3 Овоолго болон тав газрын нийт хэмжээг дараах томъёоны дагуу эзлэхүүнээр нь тооцож, нөхөн сэргээлтэд ашиглаж болох материалын хэмжээг тодорхойлно. Үүнд:

1.4

$$V_o = (S_1 \times h_1) + (S_2 \times h_2) + \dots + (S_n \times h_n)$$

V_o -талбай дахь овоолгын нийт эзлэхүүн, м³;

$S_1, S_2 \dots S_n$ -овоолгуудын дундаж талбай, м²;

$h_1, h_2 \dots h_o$ -овоолгын дундаж өндөр, м.

- 1.5 Нүхний хэмжээг дараах томъёоны дагуу эзлэхүүнээр нь тооцож, нөхөн сэргээлтийн ажилд шаардагдах материалын хэмжээг тодорхойлно.

Үүнд:

$$V_n = (S_1 \times h_1) + (S_2 \times h_2) + \dots + (S_n \times h_n)$$

V_n -талбай дахь нүхнүүдийн нийт эзлэхүүн, м³;

$S_1, S_2 \dots S_n$ -талбай дахь нүхнүүдийн дундаж талбай, м²;

$h_1, h_2 \dots h_n$ -талбай дахь нүхнүүдийн дундаж гүн, м.

- 1.6 Дээрх хоёр томъёогоор тооцож гаргасан овоолго болон нүхний эзлэхүүнийг харьцуулан үзэж, дүүргэлтэд ашиглах материал хүрэлцээтэй эсэхийг тогтооно.

Хучилт хийх шимт хөрсийг тооцох, бэлтгэх

- 1.7 Шинээр олборлолт явуулж буй газрын шимт хөрсний зузааныг хэмжиж, нийт хөрс хуулалт хийх талбайтай харьцуулан шимт хөрсний эзлэхүүнийг дараах томъёогоор тооцож олно. Үүнд:

$$V_{x.э} = S_{o.т} \times h_{x.з}$$

$V_{x.э}$ -шимт хөрсний эзлэхүүн, м³;

$S_{o.т}$ -олборлолтын талбай, м²;

$h_{x.з}$ -шимт хөрсний зузаан, м.

- 1.8 Техникийн нөхөн сэргээлт хийж хэлбэржүүлсэн газарт хучилт хийх шаардлагатай талбайн хэмжээг тогтоосны үндсэн дээр шимт хөрсөөр 10 см-ээс багагүй зузаантай хучилт хийхээр тооцож, түүнд шаардагдах шимт хөрсний нийт хэмжээг тооцож гаргах; Шимт хөрсний нийт хэмжээг тооцохдоо доорх томъёог ашиглана. Үүнд:

$$V_{n.x} = S_{x.т} \times h_{x.з}$$

$V_{n.x}$ - нийт шимт хөрсний эзлэхүүн, м³;

$S_{x.т}$ - хөрсний эзлэх талбай, м²;

$h_{x.з}$ - шимт хөрсний зузаан, м.

Шимт хөрсний тооцоо хангалттай гарсан бол техникийн нөхөн сэргээлт хийсэн бүх талбайд хучилт хийхээр төлөвлөж тооцох ба хэрэв хангалтгүй тохиолдолд шимт хөрсөөр зайлшгүй шаардлагатай хучилт хийх газруудыг тодорхойлно.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан
2017 оны 8 дугаар сарын 17-ний өдрийн
А/2269,А/182 тоот тушаалын 2 дугаар хавсралт

..... аймгийн сумын нэртэй талбайн
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
/загвар/

1. Ерөнхий мэдээлэл

1. 1. Бичил уурхай эрхлэгч этгээдийн нэр:		2. Бичил уурхай эрхлэгч этгээдийн ахлагч:	
3. 3. Бичил уурхай эрхлэгч этгээдийн товч танилцуулга (байгуулагдсан огноо, түүх, гишүүнчлэл, үйл ажиллагааны чиглэл, улсын бүртгэлийн дугаар):			
4. Нөхөн сэргээх газрын нэр:		5. Нөхөн сэргээх газрын байршил:	
6. Нөхөн сэргээх талбайн статус:	Га талбай	Газарзүйн солбицлын цэгүүд:	Хугацаа
i) Гар аргаар олборлолт хийсэн иргэдийн үйл ажиллагаанд өртөж, эвдэрсэн газар			
ii) Бичил уурхай эрхлэгч этгээдийн одоо ашиглаж буй газар			
iii) Санал болгож буй шинэ газар			
iv) Бусад нөхөн сэргээх талбай			
7. Ажиллах хүчний мэдээлэл (хүний тоо):			
8. Машин механизм ашиглах тохиолдолд энэ тухай мэдээлэл (техникийн үзүүлэлт, хүчин чадал):			
9. Нөхөн сэргээлт хийх санхүүжилтийн эх үүсвэр, дүн			
Бичил уурхай эрхлэгч этгээдийн нөхөн сэргээлтийн (дундын) сан		-----	
а	Аймгийн санхүүжилт	-----	
б	Сумын санхүүжилт	-----	
в	Бичил уурхайн бүртгэгдээгүй нөхөрлөл, нөхөрлөл, хоршооны санхүүжилт	-----	
г	Бусад	-----	
10. Нөхөн сэргээх газрын олборлолт, эвдрэлийн түүх			
11. Төсөл хэрэгжиж буй газрын байгаль орчны төлөв байдлын товч мэдээлэл:			
i) Газар зүйн бүсчлэлд хамаарах байдал:			
ii) Орчмын усны нөөцийн байдал:			
iii) Хөрс, ургамал, ан амьтны талаарх товч мэдээлэл:			

2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Урьдчилсан төсөв мян. төг
Нэг. Бэлтгэл зохион байгуулалт			
- Ажил эхлэх үеэс машин механизмыг нэг замаар явуулах. Замын тэмдэгжүүлэлт хийх - Аюулгүй байдлыг хангах үүднээс нөхөн сэргээлтийн ажилд оролцох бичил уурхайчид хувийн хамгаалах хэрэгсэл бүрэн өмсөх, хөдөлмөрийн болон галын аюулгүй ажиллагааны - Болзошгүй гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, холбогдох багаж төхөөрөмжийг байнгын бэлэн байдалд байлгах - Аянга, үерийн уснаас хамгаалах сэргийлэх арга хэмжээ авах - Ажил эхлэхээс өмнөх байдлыг харуулсан фото зураг, дүрс бичлэг хийж баримтжуулах - Зохих шаардлагын дагуу ахуйн хог хаягдлыг зайлуулах (Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын 2.4 хэсэг);			
Бохирдлоос урьдчилан сэргийлэх: усны чанар (гадаргын ба гүний ус) болон хөрс			
- Тухайн талбай орчмын усны нөөцийн чанарыг алдагдуулахгүй байх арга хэмжээ авах; - Үерийн уснаас хамгаалах далан шуудуу барих зэрэг холбогдох арга хэмжээ авах;			
Машины хөдөлгүүрийн тос, түлш газарт асгахаас урьдчилан сэргийлэх бохирдуулахгүй байх арга хэмжээг хэрэгжүүлэх.			
Ургамлын бүрхэвч хамгаалах, доройтлоос урьдчилан сэргийлэх			
Машин механизм явах зам нэмж гаргахыг хориглох замаар байгалийн өөрөө нөхөн төлжих үйл явцыг нэмэгдүүлэх; бэлчээрийн талбай болон ургамлын бүрхэвчийг аль болох устгахгүй байх, сөрөг нөлөөлөл бага байлгах; байгалийн болон нутгийн ургамлын үрийг цуглуулан нөхөн сэргээлтэд хэрэглэх;			

Амьтан			
- Нөхөн сэргээлт явуулах талбай орчим тухайн нутагт суурьшсан амьтны амьдрах орчныг алдагдуулах зэрэг сөрөг нөлөөллөөс сэргийлэх арга хэмжээ авах; Амьтдыг хамгаалах, ан, амьтан агнах, худалдаалах үйлдлийг хориглох, тэдгээрийн нүүдэл, шилжилт хөдөлгөөнд саад хийхгүй байх; - Хэт чанга дуу чимээ, хурц, тод гэрлээс үүдэн амьтад үргэн дайжиж болзошгүй тул ажлын талбайн гадна шөнийн цагаар хурц, тод гэрэл, дуу, шуугиан гаргахаас зайлсхийх. - Нөхөн сэргээлт явуулах талбайн ойр орчмын ан амьтан ундаалдаг уст цэг, гүний усны бүс, хуурай сайр зэргийг тодорхойлсон тэмдэглэл хийж, эдгээрийн ойролцоо зам, харгуй байлгах зэрэг үйл ажиллагаа явуулахаас татгалзах;			
Соёлын өв			
Үйл ажиллагааны явцад түүх дурсгалын зүйлс болон соёлын олдвор олдсон тохиолдолд холбогдох газарт мэдээлж, түүнийг хамгаалах арга хэмжээ авах;			
Орон нутгийн иргэд ба бичил уурхайчид			
Нөхөн сэргээлтийн ажлын байгаль орчин, нийгэм үзүүлэлтийг сайжруулах талаар орон нутгийн иргэдээс гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй санал гомдлыг нь барагдуулах, хамтран ажиллах.			
Хоёр. Газрын нөхөн сэргээлт			
Техникийн нөхөн сэргээлт - Нөхөн сэргээх газрын солбицлыг авч талбайн хэмжээг гаргах. - Нөхөн сэргээлт явуулах газар орчмын судалгаа хийх, (газар, хөрсний эвдрэл доройтлын хэмжээг тодорхойлох) - Тухайн газрыг цаашид ямар зориулалтаар ашиглахыг талуудтай хамтран тодорхойлох (бэлчээр, хөдөө аж ахуйн чиглэлээр гэх мэт) - Нөхөн сэргээлтэд ашиглах гар багаж хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж (хүрз, лоом, жоотуу, цахилгаан өрөм, шаардлагатай тохиолдолд уул уурхайн бага оврын машин техник г.м)-ийг бэлтгэх.			

● Нөхөн сэргээлт хийх талбайд хүн, мал, амьтан оруулахгүй байхаар тэмдэгжүүлэлт хийх ● Талбай дахь нийт цооног, нүх ам, овоолго, тав мөргөцөг газар (тал талаасаа ухагдаж үлдсэн хэсэг)-ийг тоолж бүртгэх. ● Овоолго болон тав газрын нийт хэмжээг эзлэхүүнээр нь тооцож, нөхөн сэргээлтэд ашиглаж болох материалын хэмжээг тодорхойлох; ● Нөхөн сэргээлт хийх зардлын тооцоог гаргах. ● Нөхөн сэргээлт хийх талбай дахь цооног, нүх, овоолго, тав газар, эрэг, хэцийн налуу, эгц байдлыг тодорхойлон зураглал гаргах; ● Эдгээрт хэрэглэх том, чулуу, хайрга, элс зэрэг материалуудыг бэлтгэх. ● Нүх, хонгил, босоо ам зэрэгт дүүргэлт хийх ● Ташуу, налуу, эрэг, овон товон гадаргууг тэгшлэх ● Олборлолтын явцад үүссэн хотойлт, нурулт, цөмрөлтийг хурдас чулуулгаар дүүргэх, аюулгүй болгох; ● Шимт хөрсийг тодорхойлох, бэлтгэх (Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу) ● Нөхөн сэргээлт хийх талбай дахь шимт хөрсний байршлыг тодорхойлох, зохистой хадгалах, хамгаалах. ● Нөхөн сэргээлт хийсэн газраа шимт хөрсөөр хучих, хэлбэржүүлэх ажиллагаа хийх Биологийн нөхөн сэргээлт (Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу) ● Орон нутгийн ургамлын төрөл зүйлийг тодорхойлох ● Орчмын хэд хэдэн газарт 1-5 м.кв талбайг сонгон авч, талбай доторх бүх ургамлын ерөнхий бичиглэл хийнэ. Үүнд тухайн орчны зонхилогч болон дэд зонхилогч ургамлыг тодорхойлох; ● Малын өтөг, бууцыг ойр орчмын газар нутгаас цуглуулах ● Нөхөн сэргээлтийн тохиромжтой ургамлын төрөл зүйлийн үрийг цуглуулах ● Өвс, сүрэл, өмхөрсөн унанги мод, холтос, мөчир, гишүү зэргийг цуглуулах ● Үржил шимт хөрсний хэмжээ нөхөн сэргээх талбайд хүрэлцээтэй эсэхийг судлах; ● Мод тарихаар төлөвлөсөн бол тухайн орчмоос мод, суулгац бэлтгэх газраа тодорхойлно, суулгацын нийт хэмжээг гаргасны дараа зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авах; ● Нөхөн сэргээлтэд хэрэглэх нийт мод, суулгацын тоог тарих талбайн хэмжээтэй харьцуулан тооцож гаргана. ● Талбайд үр цацах, түүнийг хамгаалах арга хэмжээ авах			
--	--	--	--

Гурав. Олборлолтын мөчлөгт суурилсан нөхөн сэргээлт хийх хандлага (Шинээр газрын зөвшөөрөл авч олборлолт хийж буй тохиолдолд) Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалыг харна уу			
- Олон наст ургамлууд (өвслөг болон бутлаг) ургаж буй байршлуудыг тодорхойлох, нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийх, нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах - Нүх, шруф, шуудуу хаана гаргах төлөвлөлт хийж, шимт хөрсний хуулалт яаж хийх, хаана овоолго үүсгэхээ төлөвлөх - Хуулалт хийсэн шимт хөрсийг уурхайн олборлолтын явцад хаягдаж үрэгдэхгүй байхаар төлөвлөж шимт хөрсний овоолго хийх			
Дөрөв. Нөхөн сэргээлт хийсэн талбайг хүлээлгэн өгөх			
- Томилогдсон ажлын хэсэгт, нөхөн сэргээлтийн ажлын явцыг танилцуулж, хэлэлцэх - Талбайг албан ёсоор акт үйлдэж, хүлээлгэн өгөх, нөхөн сэргээлтийн дараах мониторинг, арчилгаа тордлогоог зөвшөөрсөн хугацаанд хариуцан хийх			

БАТАЛСАН:

..... СУМ, ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА /

Хянасан:

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан
2017 оны 8 дугаар сарын 17-ний өдрийн
А/2269,А/182 тоот
Тушаалын 3 дугаар хавсралт

..... аймгийн сумын нэргүй талбайн
Нөхөн сэргээлтийн тайлангийн загвар

Аймаг	Сум	Олборлолт явуулж байгаа талбайн хэмжээ (га)	Нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй			Олборлолт явуулж эхэлснээс хойш эвдрэлд орсон талбай (га)	Нөхөн сэргээлт хийсэн талбай (га)	Нөхөн сэргээлт хийсэн талбайг хүлээн авсан актын дугаар, бусад мэдээлэл
			Бичил уурхай эрхлэгч этгээдийн нэр	Гэрээ байгуулж, олборлолт эхэлсэн огноо	Гишүүдийн тоо			
1	2	3	4	5	6	7	8	9

БОАЖГ-ын дарга

БОАЖГ-ын мэргэжилтэн



Санхүүжүүлэгч



Үндсэн хэрэгжүүлэгч



Хамтрагчид



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

